12/15/2017

# Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

# 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

17

2.

**Contents**

НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ... 4
1.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл ... 4
1.2 Хяналт шалгалт ... **Error! Bookmark not defined.**
**1.2.1** ... **Error! Bookmark not defined.**
**1.2.2 Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх** ... **Error! Bookmark not defined.**
**1.2.3 Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах хүрээнд** ... **Error! Bookmark not defined.**
**1.2.4** ... **Error! Bookmark not defined.**
1.3 Судалгаа, дүн шинжилгээ ... 10
**1.3.1 "Монгол Улсын хувийн хэвшлийн салбар дахь хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" сэдэвт судалгааны ажил хийх, тайлан боловсруулах** ... 11
**1.3.2 Хүүхдийн эрх, хамгааллын талаар судалгаа хийх, тайлан боловсруулах** ... 12
**1.3.3 Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрх** ... 12
**1.3.4 Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд судалгаа, дүн шинжилгээ хийх** ... 13
**1.3.6** ... 14
**1.3.7 Тодорхой сэдвийн хүрээнд хүний эрхийн нөхцөл байдалд сар тутам дүн шинжилгээ хийж, тайлагнах** ... 15
1.4 Хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж шийдвэрлэх **Error! Bookmark not defined.**
**1.4.1** ... **Error! Bookmark not defined.**
**1.4.2** ... **Error! Bookmark not defined.**
**1.4.3** ... **Error! Bookmark not defined.**
**1.4.4** ... **Error! Bookmark not defined.**
**1.4.5** ... **Error! Bookmark not defined.**
ХОЁР. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ... 35
2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт, уулзалт ... 35
**2.1.1 Хүний эрхийн цуврал лекц зохион байгуулах** ... 35
**2.1.2 “Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалтыг зохион байгуулах** ... 35
**2.1.3 Хуульчийн багц цаг олгох сургалт зохион байгуулах ажлын хүрээнд** ... 35
**2.1.4** ... 37
**2.1.5** ... 37
**2.1.6 ХЭСХ, ХЭБ, Хүүхдийн эрх зэрэг сэдвээр цахим сургалт зохион байгуулах, сургалтын агуулга, арга зүйг баяжуулах** ... 38
**2.1.7** ... 38
**2.1.8** ... 39
**2.1.9** ... 39
**2.1.10** ... 43
**2.1.11** ... 43
**2.1.12 Залуучууд хөгжлийн төвийн сургагч багш, гишүүдэд сургалт зохион байгуулах (Улаанбаатар хот болон 11 аймагт)** ... **Error! Bookmark not defined.**
**2.1.13** ... 44
**2.1.14** ... 44
2.2 Хүний эрхийн сурталчилгаа ... 47
**2.2.1** ... 47
**2.2.2** ... 47
**2.2.3** ... 49
**2.2.4 Олон улын хүний эрхийн өдрийн арга хэмжээ зохион байгуулах.** ... 49
**2.2.5** ... 51
**2.2.6 Ном хэвлэл түгээсэн талаар сар тутам тайлагнах** ... 52
**2.2.7** ... **Error! Bookmark not defined.**
**2.2.8** ... 53
**2.2.9** ... **Error! Bookmark not defined.**
ГУРАВ: ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА. **Error! Bookmark not defined.**
3.1 ... **Error! Bookmark not defined.**
**3.1.1** ... **Error! Bookmark not defined.**
ДӨРӨВ: ЗАХИРГАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ... **Error! Bookmark not defined.**

4.1 Гадаад хамтын ажиллагаа ........ Error! Bookmark not defined.
**4.1.1** ........ **Error! Bookmark not defined.**
**4.1.2** ........ **Error! Bookmark not defined.**
**4.1.3** ........ **Error! Bookmark not defined.**
**4.1.4** ........ **Error! Bookmark not defined.**
**4.1.5** ........ **Error! Bookmark not defined.**
**4.1.6** ........ **Error! Bookmark not defined.**
4.2 Дотоод хамтын ажиллагаа ........ **Error! Bookmark not defined.**
**4.2.1** ........ **Error! Bookmark not defined.**
**4.2.3** ........ **Error! Bookmark not defined.**
**4.2.4** ........ **Error! Bookmark not defined.**
ТАВ: БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА ........ **Error! Bookmark not defined.**
5.1 Комиссыг чадавхижуулах, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа. ... **Error! Bookmark not defined.**
**5.1.1 Чадавхи бэхжүүлэх сургалт** ........ **Error! Bookmark not defined.**
**5.1.2** ........ **Error! Bookmark not defined.**
5.2 ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.1** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.2** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.3** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.4** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.5** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.6** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.7** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.8** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.9** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.10** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.11** ........ **Error! Bookmark not defined.**
**5.2.12** ........ **Error! Bookmark not defined.**

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасны дагуу Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичиж жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэдэг. Комисс 16 дахь илтгэлээ боловсруулж 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн барьсантай холбогдуулан 9 телевиз, 7 мэдээллийн цахим хуудас энэхүү үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэв.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажлын хүрээнд Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны дарга, хэлтсийн дарга, референтүүд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх, нэвтрүүлэгт оролцох зэргээр сурталчилгаа нөлөөлийн үйл ажиллагааг явууллаа.

Энэ удаагийн илтгэлд Комиссын хийсэн хяналт шалгалт, судалгаа, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, иргэний нийгмийн болон бусад байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, дүн шинжилгээ, Засгийн газар, яам, агентлаг, бусад байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хүний эрхийн дараах асуудлыг авч үзлээ. Үүнд:

**Нэгдүгээр бүлэг.** “Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал”

Хүүхдийн эрх, хамгааллын талаар хүүхэд, эцэг эх, олон нийтийн мэдлэг, хандлагын төлөв байдал, түүнээс үүдэн гарч буй хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, хүүхдийн эрхийн зөрчил гарч буй орчин зэрэг хүүхэд хамгааллын тулгамдаж буй зарим асуудал.

Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрх хэсэгт Баян-Өлгий аймагт суугаа тува, дөрвөд, урианхай, халх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, төрийн албан ёсны хэл болон хос хэлний сургалтын чанар, түүнээс үүдэлтэй хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт, мөн багшийн мэргэжлийн бэлтгэл, боловсролын чанар, сургалтын орчин.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол, тусгай хэв шинжтэй цэцэрлэгийн хүртээмж, орчин, нөхцөл байдал болон байнгын асаргаа, сувилгаа шаардагдах хүнд хэлбэрийн, давхар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, халамжийн нөхцөл байдал, үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагуудын орон байрны хүртээмж, ажиллагчдын чадавх, хүний нөөц, үйл ажиллагааны уялдаа холбоо зэрэг асуудлыг тусгав.

**Хоёрдугаар бүлэг. “**Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал”

Сэдвийн хүрээнд Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажсан төрийн албан хаагч болон худалдаа, үйлчилгээ, ноос ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрийн аж ахуйн нэгжид ажиллагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн зарим асуудлыг судалж бичив.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, сонгон шалгаруулалт, өргөдөл гомдол, маргаан шийдвэрлэлтийн байдал, төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсаныг тогтоосон шүүхийн шийдвэр биелэхгүй байгаагаас тухайн албан хаагчид учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зарим асуудал.

Жижиг дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбараар төлөөлүүлэн тэнд ажиллагчдын хөдөлмөрийн гэрээ, цалин хөлс, ажлын цаг, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний хэрэгжилт, ажлын байран дахь дарамт, хөдөлмөрийн маргаан, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа зэргийг судалж тусгав.

**Гуравдугаар бүлэг.** “Цэргийн алба хаагч, ажилтны хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт”

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, мэргэших, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн талаар Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа Зэвсэгт хүчний 23 анги, Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 17 анги, нийт 40 анги, байгууллагыг хамруулан зохион байгуулсан хяналт шалгалт, судалгааны ажлын дүнд үндэслэн цэргийн алба хаагч, ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн асуудлыг тусгасан болно.

**Дөрөвдүгээр бүлэг.** “Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт”

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах байгууллага байгуулах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгох асуудлыг Комисст ирүүлсэн гомдол, мэдээлэл, холбогдох хуулийн байгууллагын эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх судалгаа, тоо баримтыг үндэслэн боловсруулав.

**Тавдугаар бүлэг. “**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал”

Төрийн байгууллагуудын жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой чиг үүргийн хэрэгжилтийн байдал, ололт амжилт, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны өнөөгийн төлөв байдлыг төрийн холбогдох байгууллагын тайлан мэдээ, судалгаа материалд түшиглэн бичив.

Монгол Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулахаар дээрх асуудлаар 19 саналыг илтгэлд тусган хүргүүлэв.

Хавсралтаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 13 болон 14 дэх илтгэлийг хэлэлцсэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 28, 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдлыг хүргүүлэв.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо 2017 оны 10 дугаар сарын 17-ны хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 12/28 дугаар тогтоолоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж тус ажлын хэсэгт Комиссын дарга Ж.Бямбадорж, Комиссын гишүүн П.Оюунчимэг нар ажиллаж байна.

Тус ажлын хэсэг 2017 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Эрээн хот болон Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллахад ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг оролцон ажиллаж Замын-Үүд суманд хүүхэд хамгааллын байр байгуулахтай холбоотой зардлыг 2018 оны орон нутгийн төсөвт суулган шийдвэрлүүлсэн байна. Мөн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны хороотой хамтран зохион байгуулсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг"-т Комиссын гишүүн П.Оюунчимэг "Хүүхдийн эсрэг хүчирхийллийн өнөөгийн нөхцөл, байдал” сэдвээр, 2017 оны 11 дүгээр сарын 24-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан “Хүүхэд эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах төрийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах, олон нийтийн оролцоо, хяналт” нэлттэй хэлэлцүүлэгт Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж оролцож илтгэл тавин байр сууриа илэрхийллээ.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийн 5 дахь сэдэв болох Жендэрийн тэгш эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө. Ундрах, ахлах референт Х.Мөнхзул, референт Э.Туул нар яамд, төрийн байгууллага, 21 аймаг болон нийслэлийн засаг даргын тамгын газар, иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албад хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй мэдээллийг нэгтгэж дуусган, илтгэлийн бүлгийг боловсруулав.

Комиссын 13, 14 дэх илтгэлээр өгсөн зөвлөмжийг хэлэлцээд УИХ-аас гаргасан 28, 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг үнэлэх хавсралтын албадан хөдөлмөрийн конвенцтэй дотоодын холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх заалтын хэрэгжилтийг үнэлж нэгтгэв.

Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн ажилтнууд дараах сэдвүүдээр 16 дахь илтгэлийг боловсруулсан байна. Үүнд:

- Цэргийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт
    - Хилийн цэргийн байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрх
    - Зэвсэгт хүчний байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрх
- Эрүү шүүлтээс ангид байх эрх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн зарим асуудал

- сургуулийн өмнөх боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт
- давхар, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асрамжийн асуудал

<u>Илтгэлийг хэвлүүлж, холбогдох газруудад хүргүүлэв.</u>

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуульд шинэчлэн найруулга хийгдсэнтэй холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссоос УИХ-д өргөн барьдаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд 2017 оноос эхлэн хэвлэхгүй болсон байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг “Соёмбо принтинг” ХХК-д 1500 хувь хэвлүүлж төрийн болон төрийн бус байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудас, цахим номын сангийн талбарт цахим хэлбэрээр байршуулаад байна.

Илтгэлийг ИНБ-уудад танилцуулах уулзалт зохион байгуулав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг танилцуулах Хүний эрхийн байгууллага ба төр, иргэний нийгмийн түншлэл 13 дахь удаагийн ээлжит уулзалтыг 4 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулав. Бэлтгэл ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын 150 төлөөлөгчид урилга, хөтөлбөр хүргүүлснээс Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зэрэг төрийн 13 байгууллага, иргэний нийгмийн 87 байгууллагын төлөөлөл ирж оролцов. Уг үйл ажиллагааг Монгол HD телевиз, Ийгл телевиз, Монголын Үндэсний олон нийтийн радио, www.murch.mn, www.news.mn, www.dorgio.mn, www.uurhai.mn, Mongolian economy сэтгүүл, Өдрийн сонины сэтгүүлчид ирж сурвалжлан иргэд олон нийтэд мэдээллээ. Үйл ажиллагаанд төрийн байгууллагуудаас оролцогчдын нэрс авч, оролцогчдын жагсаалт гарган, хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтөлсөн болно.

### 1.2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Комисс төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийт 99 хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

| Зорилго | Шалгалт хийсэн обьект | Тоо | Авсан арга хэмжээ |
|---|---|---|---|
| Мэдээллийн дагуу | ШШГЕГ-ын харьяа Хорих 407,409, 425 дугаар анги | 3 | |
| | Өнөр бүл хүүхдийн төв | 1 | |
| 2017 оны Комиссын төлөвлөгөөнд тусгасны дагуу | ШШГЕГ-ын харьяа Хорих 433, 435, 437, 439, 445, 457, 423, 413, анги | 8 | Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй шалтгаан, нөхцлийг арилгуулахаар ЗӨВЛӨМЖ, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд тус тус ШААРДЛАГА хүргүүлж хуулийн хугацаанд хариу ирүүлсэн байна. |
| | Цагдан хорих байр /орон нутаг/ | 41 | |
| | Баривчлах, эрүүлжүүлэх, саатуулах байр /орон нутаг/ | 30 | |
| Төлөвлөгөөт | Төрийн байгууллага, ТӨХК /Хилийн МХГ, Нисэх/ | 10 | |
| | Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилт /Ховд/ | 1 | |
| Гомдлын дагуу | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг | 5 | |
| **Нийт** | | **99** | |

Хяналт шалгалтын тоон мэдээллийг өмнөх онуудтай харьцуулбал:




| | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Обьектын тоо | 1 | 41 | 10 | 7 | 96 | 22 | 13 | 6 | 29 | 10 | 26 | 69 | 59 | 131 | 27 | 108 | 99 |

**1.2.1 Төвлөрсөн хорих анги, цагдан хорих байр, захиргааны журмаар албадан саатуулах, баривчлах байранд хяналт шалгалт зохион байгуулах**

ШШГЕГ-ын харьяа 8 хорих ангид хяналт шалгалт хийснээс 6 хорих ангид төлөвлөгөөний дагуу, 2 хорих ангид гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийсэн байна. Дараах ангиудад төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийгдсэн. Үүнд:

1. Өвөрхангай аймаг дахь Комиссын ажилтан ШШГЕГ-ын харьяа Хорих 423 дугаар ангид ял эдэлж буй ялтны эрхийн хэрэгжилтэд 2017 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хяналт шалгалт хийж, ШШГЕГ-ын даргад Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгасан талаараа хуулийн хугацаанд хариу ирүүлсэн байна.
2. Комисс, ШШГЕГ-тай хамтран 2017 оны 4 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Зүүн хараа сум дахь ШШГЕГ-ын харьяа Хорих 433 /чанга/, 413 /чанга/, Дархан-Уул аймаг дахь ШШГЕГ-ын харьяа Хорих 435 /чанга/, 445 /жир/ дугаар ангиудад ял эдэлж буй ялтны эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.
3. Комиссын гишүүний баталсан удирдамжийн дагуу 2017 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Ховд аймаг дахь ШШГЕГ-ын харьяа Хорих 457 /жир/ дугаар ангид ял эдэлж буй ялтны эрхийн хэрэгжилтэд П.Оюунчимэг гишүүн ахлан хэлтсийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Г.Уганбаатар, БДШХЭБХ-н ажилтан О.Ичинхорлоо, Ховд аймаг дахь Комиссын ажилтан Г.Солонго нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийв. Илтгэх хуудас боловсруулах, санал асуулга нэгтгэх ажлууд хийгдэж байгаа бөгөөд мөн Комиссын гишүүний зөвлөмж боловсруулж хүргүүлэхээр ажиллаж байна.
4. Ховд аймаг дахь Комиссын ажилтан тус аймгийн ШШГА-ны Цагдан хорих байр болон Цагдаагийн газрын харьяа Захиргааны журмаар саатуулах байранд 2017 оны 6 дугаар сарын 18-ны өдөр хяналт шалгалт хийж, илтгэх хуудсыг боловсруулж ирүүлсэн байна.
5. Орхон аймаг дахь Хорих 435 дугаар ангид Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2017 оны 10 дугаар сард хяналт шалгалт хийсэн бөгөөд хяналт шалгалтын дүнг үндэслэн ШШГЕГ-ын даргад шаардлага хүргүүлсэн байна.
6. Булган аймаг дахь 439 дүгээр ангид Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2017 оны 10 дугаар сард хяналт шалгалт хийсэн бөгөөд хяналт шалгалт хийв.

**1.2.2 Морь унаач хүүхдийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх**

Комиссын даргаас чиглэл өгсний дагуу бие даасан хяналт шалгалт хийгээгүй болно. Харин тус хэлтсээс орон нутаг дахь ажилтнуудад тухайн аймаг, орон нутагт зохион байгуулагдаж буй баяр наадмын хурдан морины уралдааны явцад хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр орон нутгийн удирдлага хэрхэн ажиллаж байгаа талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл цуглуулах зааварчилгааг боловсруулж, Комиссын Ажлын албаны даргын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 4/342 дугаар албан бичгээр нийт орон нутаг дахь ажилтнуудад хүргүүлсэн байна.

**1.2.3 Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх**

Комисс 2015 онд сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд ХНХЯ, БСШУСЯ-тай хамтран 10, 186, Энэрлийн түүчээ, Бяцхан сувд зэрэг цэцэрлэгийг сонгон хяналт шалгалт явуулсан бөгөөд дээрх яамдад хяналт шалгалтаар илэрсэн

зөрчлийг арилгуулахаар Комиссын гишүүний шаардлагыг хүргүүлж байсан байна. Иймээс өмнө хүргүүлсэн Комиссын гишүүний шаардлагын мөрөөр авсан арга хэмжээний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2/83 дугаар, Боловсрол, соёл, шинжлэх ухааан, спортын сайд Ж.Батсуурьт 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2/84 дугаартай албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн мэдээллийг илтгэл боловсруулахад ашиглав.

### 1.2.4 Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах

Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай байгуулсан Санамж бичигт заасны дагуу Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд тус газраас 84 хуудас материал ирүүлсэн болно.

МХЕГ-ын даргын баталсан 01/99 тоот удирдамжийг дагуу Хот суурин газрын хөрсний бохирдлын байдалд хяналт шинжилгээ хийхэд нийслэлийн суурьшлын бүсийн хөрсний дээжинд хийсэн нян судлалын шинжилгээний үзүүлэлтээр нийт 45.5 хувь нь /66/ бага буюу хоёрдугаар зэргийн, 32.4 хувь нь (47) дунд буюу гуравдугаар зэргийн, 22.1 хувь нь (32) их буюу дөрөвдүгээр зэргийн бохирдолтой ангилалд хамаарсан байна. Хөрсний нян судлалын бохирдлын түвшинг дүүргүүдээр авч үзвэл Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт хамгийн их бохирдолттой, Багануур, Налайх дүүрэгт хөрсний бохирдлын түвшин харьцангуй бага түвшинд үнэлэгдсэн байна.

Мөн Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж, арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламж “Харгиа”, Архангай, Ховд, Хөвсгөл, Төв аймгийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас дээж авч шинжлүүлэн үнэлгээ дүгнэлт өгсөн байна. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас 2017 оны 5, 11 дүгээр саруудад дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамруулж, Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын шаардлагатай харьцуулж үнэлгээ дүгнэлт өгөхөд 5 дугаар сард хийсэн шинжилгээний дүнгээр химийн хэрэгцээт хүчилтөрөгч стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 3.6 дахин их, жигнэгдэгч бодис 2.7 дахин их, 11-р сард авсан шинжилгээгээр биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 6.9 дахин их, химийн хэрэгцээт хүчилтөрөгч 2.5 дахин их, жигнэгдэгч бодис 2.8 дахин их бохирдолттой гарчээ.

**Жич:** Дээрх баримт, мэдээлэл нь 17 дахь илтгэлийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт сэдвийг боловсруулахад ашиглагдана.

### 1.2.5 Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх

Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд дараах хяналт шалгалтыг хийсэн байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Комиссын дарга Ж.Бямбадорж ахлан, референт Б.Сэмжидмаа, Сэлэнгэ аймаг дахь Комиссын ажилтан Д.Гантулга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийв.
2. Ховд аймгийн Булган сум дахь Булган боомтын Хилийн мэргэжлийн хяналтын албаны ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 6 дугээр сарын 16-ны өдөр Комиссын гишүүн П.Оюунчимэг ахлан, хэлтсийн дарга Т.Ихтамир нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийв.
3. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 10 дугаар сарын 5-ны өдөр гишүүн П.Оюунчимэгээр ахлан, хэлтсийн дарга Т.Ихтамир, Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн референт Г.Золзаяа, О.Ичинхорлоо, Дорноговь аймаг дахь ахлах мэргэжилтэн Б.Нандин-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийв.
4. Увс аймгийн Давст сум дахь Боршоон боомтын Хилийн мэргэжлийн хяналтын албаны ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 10 дугаар сарын 5-ны өдөр тус аймаг дахь Комиссын шинжээч Я.Хонгорзул хяналт шалгалт хийж, илтгэх хуудсыг ирүүлсэн байна.
5. Дорнод аймгийн Чулуунхороот сум дахь Эрээн цав боомтын Хилийн мэргэжлийн хяналтын албаны ажилчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр ахлах референт Л.Дүгэрсүрэн ахлан, тус аймаг дахь Комиссын ахлах мэргэжилтэн Д.Дугарсүрэн нар хяналт шалгалт хийв.

6. Дорнод аймгийн Чойбалсан сум дахь Хавирга боомтын Хилийн мэргэжлийн хяналтын албаны ажилчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр тус аймаг дахь Комиссын ахлах мэргэжилтэн Д.Дугарсүрэн нар хяналт шалгалт хийв.

**Жич:** Хяналт шалгалтын илтгэх хуудас, ажилтнуудаас авсан санал асуулгыг нэгтгэж боловсруулсан, холбогдох эрх зүйн акт, дүрэм журамд дүн шинжилгээ хийж 2018 онд УИХ-д өргөн барих Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд оруулахаар ажиллаж байна.

**1.2.6 Гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх**

Гомдлын мөрөөр 6, мэдээллийн мөрөөр 3 нийт 9 хяналт шалгалт хийсэн байна.

1. Гомдлын мөрөөр 2017 оны 4 дүгээр сарын 10-11, 17-ны өдрүүдэд Комиссын гишүүн Н.Ганбаяр ахлан, референт Б.Сэмжидмаа, Г.Ууганбаатар, М.Мөнхшүр, Ж.Гантуяа, Х.Ичинхорлоо нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Гёте” дунд сургуульд суралцагч хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, Комиссын гишүүний Зөвлөмж хүргүүлсэн байх ба хуулийн хугацаанд хариу ирүүлсэн байна.
2. Гомдлын мөрөөр 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдөр МУИС-ын харьяа Байгаль-Эх лицей ахлах сургуулийн багш, ажилчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу хэлтсийн дарга Т.Ихтамир ахлан, референт Б.Нандинцэцэг, Ж.Гантуяа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийж, МУИС-ын захиралд багш, ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийг хангаж ажиллах талаар Комиссын гишүүний шаардлага хүргүүлсэн байх ба шаардлагын мөрөөр арга хэмжээ авч тус сургуулийн захирлыг чөлөөлсөн гэх хариуг ирүүлсэн байна.
3. Гомдлын мөрөөр Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу П.Оюунчимэг гишүүнээр ахлуулан хэлтсийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Б.Сэмжидмаа, М.Мөнхшүр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ШШГЕГ-ын харьяа Хорих 409 дүгээр ангид ялтны эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, гомдолд дурдсан асуудлыг ШШГЕГ урьд шийдвэрлэсэн байв.
4. Гомдлын мөрөөр Баянхонгор аймаг дахь Комиссын ажилтан тус аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран Нисэх онгоцны буудлын ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр хяналт шалгалт хийж, мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн акт гарсан байна.
5. Мэдээллийн мөрөөр 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтэд гишүүн Н.Ганбаяраар ахлуулсан ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар илэрсэн зарим зөрчил дутагдал, бодлогын түвшинд шийдвэрлэх асуудлын талаар Монгол улс дахь эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал хэсэгт оруулсан болно.
6. Мэдээллийн мөрөөр 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Говьсүмбэр аймаг дахь ШШГЕГ-ын харьяа Хорих 425 /жир/ дугаар ангид ял эдэлж буй ялтны эрхийн хэрэгжилтэд П.Оюунчимэг гишүүн ахлан хэлтсийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Г.Ууганбаатар, Говьсүмбэр аймаг дахь Комиссын ажилтан н.Наранбаатар нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийж, ШШГЕГ-ын даргад Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн бөгөөд холбогдох арга хэмжээг авч, хариуг ирүүлсэн байна.
7. Гомдлын мөрөөр “Өнөр бүл” хүүхдийн төв асрамжийн газарт хяналт шалгалт хийхээр төлөвлөсний дагуу 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр гишүүн Н.Ганбаяр ахалсан ажлын хэсэг ажилласан болно. Ажлын хэсэгт хэлтсийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн, ахлах референт Х.Мөнхзул, референт Г.Ууганбаатар, ахлах мэргэжилтэн О.Ичинхорлоо нар оролцсон. Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.
8. Мөн гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийх ажлын хүрээнд ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Комиссын дарга Ж.Бямбадорж ахалсан ажлын хэсэг ажилласан болно. Ажлын хэсэгт ГХШХ-ийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Б.Сэмжидаа, референт Г.Ууганбаатар, референт Г.Түвшинжаргал нар оролцсон.Одоогоор хяналт шалгалтын илтгэх хуудсыг боловсруулж байгаа бөгөөд шалгалтын үр дүнд хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар ЗӨВЛӨМЖ, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд тус тус зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

9. Трансжендэр эмэгтэйг эрэгтэйчүүдийн эрүүлжүүлэхэд эрүүлжүүлснээс гадна бэлгийн чиг баримтжаагаар ялгаварлан, хэл үгээр доромжилж бие эрхтэнд нь халдсан гэх гомдлын дагуу Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлстийн Эрүүлжүүлэх байранд удирдамж батлуулж, хэлтсийн дарга Т.Ихтамир, референт Г.Ууганбаатар, референтийн үүрэг гүйцэтгэгч Б.Номин нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалт хийв. Хяналт шалгалтын илтгэх хуудсыг боловсруулж, ЦЕГ-ын даргад зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

**1.3 Судалгаа, дүн шинжилгээ**
*Хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд дүн шинжилгээ хийж, санал хүргүүлэх, холбогдох ажлын хэсэгт ажиллах*

Улсын Их Хуралд өргөн баригдсан, хэлэлцэгдэж буй хууль, тогтоомжийн төсөлтэй тухай бүр танилцан 2017 онд эхний хагас жилийн байдлаар 12 хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, журмын төсөлд хүний эрхийн зарчим, хэм хэмжээний дагуу дүн шинжилгээ хийж, 134 саналыг хууль санаачлагчид хүргүүлсэн байна. Үүнд:

| д/д | Хуулийн төслийн нэр | Саналын тоо | Санал хүргүүлсэн албан тушаалтан | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлах “Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журам”-ын төсөл | 13 санал | Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт | 2017.01.18. 3/48 |
| 2 | Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | 18 санал | Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт | 2017.02.01. 3/77 |
| 3 | Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдах “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл | 2 санал | Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт | 2017.02.21. 1/132 |
| 4 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | 31 санал | Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт | 2017.03.15. 1/163 |
| 5 | Дотуур байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS... :2017 стандартын төсөл | 12 санал | “Хүүхэд хөгшдийг ивээх төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Амарсанаа | 2017.04.07. |
| 6 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | 18 санал | Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал | 2017.05.11. 1/254 |
| 7 | Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл | 11 санал | Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан | 2017.05.11. 1/255 |
| 8 | Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлах “Саатуулах байрны дэглэм, журам”-ын төсөл | 6 санал | Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт | 2017.07.06. 1/346 |
| 9 | Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл | 8 санал | Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан | 2017.09.05. 4/380 |
| 10 | Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга | 2 санал | ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар | 2017.10.02. 4/440 |
| 11 | “Зохистой хөдөлмөрийг хангах замаар 2030 он хүртэлх Тогтвортой | 1 санал | Үндэсний статистикийн хорооны | 2017.12.13. 4/610 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: Монгол Улсад ТХЗ-ын хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал"-ын талаарх тайлан | | Хүн, ам нийгмийн статистикийн газрын дарга А.Амарбал | |
| 12 | "Бүх нийтийн эрх зүйн боловсрол"-ын хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, хөтөлбөрийн төсөл | 12 санал | Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж | 2017.12.19. 1/633 |

Тайлант хугацаанд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл, ЗХАХ-ийн дарга Ө.Ундрах, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэг ГХШХ-ийн дарга Т.Ихтамир, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ахлах референт Л.Дүгэрсүрэн, Ахмад настны хөгжил, хамгааллын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ахлах референт З.Өнөржаргал, Залуучуудын үндэсний хөтөлбөрийг дэмжих ажлын хэсэгт референт Г.Золзаяа нар тус тус ажиллаж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн найруулахтай холбоотой ХЗДХЯ-наас ирүүлсэн санал асуулгын хүрээнд хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар гаргасан санал, хүний эрхийн боловсрол, сурталчилгааны талаарх саналын нэгдсэн мэдээллийг Комиссоос хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар гаргасан санал зөвлөмж, болон бусад нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрт 2001-2017 онд нийт 2893 саналыг гаргасан байна.

Үүний зэрэгцээ УИХ-д өргөн баригдсан хуулийн төслийн мэдээлэл, 2017 онд шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн мэдээллийг шинэчлэн боловсруулж Комиссын дарга, гишүүд, АА-ны даргад зохих журмын дагуу танилцуулж, ABLE-д байршуулан, Комиссын цахим мэдээллийн санд хууль тогтоомжид хүргүүлсэн саналыг нэгдсэн бүртгэлийг тогтмол хийж байна.

Хэлтсийн ажилтнууд нийт 6 хууль тогтоомж, эрх зүйн актын төслийн ажлын хэсэгт орж ажилласнаас гадна 6 хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж, санал өгч ажилласан байна. Үүнд:

| Хууль тогтоомж, эрх зүйн актын ажлын хэсгийн нэр | | Гүйцэтгэсэн ажилтны нэр |
|---|---|---|
| 1. | Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | Т.Ихтамир |
| 2. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль | |
| 3. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга | |
| 4. | Цаазаар авах ялыг сэргээх,<br>Эрүүгийн хуульд оруулах асуудлыг судлах | |
| 5. | Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | Л.Дүгэрсүрэн |
| 6. | Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | Б.Сэмжидмаа |
| **Хууль тогтоомж, эрх зүйн актын төслийн нэр** | | **Гүйцэтгэсэн ажилтны нэр** |
| 7. | Гадаадын иргэнийг саатуулах байрны журамд санал | Т.Ихтамир<br>Л.Дүгэрсүрэн |
| 8. | Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал | Л.Дүгэрсүрэн<br>Г.Ууганбаатар |
| 9. | МУ-ын Засгийн газраас НҮБ-ын Хүний эрхийн хороонд хүргүүлэх нэмэлт тодруулга мэдээлэл бэлтгэсэн | Л.Дүгэрсүрэн<br>Б.Нандинцэцэг<br>Г.Ууганбаатар<br>Ж.Гантуяа |
| 10. | Саатуулах байрны дэглэм, журмын төсөл | Т.Ихтамир<br>Л.Дүгэрсүрэн<br>Ж.Гантуяа |

| | | |
|---|---|---|
| 11. | Монгол Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл | Хэлтсийн ажилтнууд |
| 12. | Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн төсөл | Т.Ихтамир Л.Дүгэрсүрэн |

**1.3.1 "Монгол Улсын хувийн хэвшлийн салбар дахь хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" сэдэвт судалгааны ажил хийх, тайлан боловсруулах**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Европын Холбооны дэмжлэг, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын техникийн туслалцаатайгаар хувийн хэвшлийн салбарт худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн зарим асуудлыг судаллаа. Судалгааг 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд Карьер хөгжлийн хүрээлэн төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгэв.

Судалгааг Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний 59, ноос ноолуурын чиглэлийн 19, нийт 78 жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ААНБ-ын ажил олгогч, ажилтнууд болон экстертийн 1750 төлөөллийг хамруулж чанарын болон тоон судалгааны аргаар явуулав.

Тус судалгааны үр дүнг ХЭҮК-оос УИХ-д өргөн барьдаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ тусгаж, бодлого, эрх зүйн чиглэлээр хэрэгжүүлэх санал зөвлөмжийг хууль тогтоогч, шийдвэр гаргагчдад хүргүүллээ.

"Хувийн хэвшил дэх хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" судалгааны ажлын тайлангийн орчуулгыг хянаж, ОУХБ-д хүргүүлэв. Судалгааны ажлын тайлангийн хэлэлцүүлэх уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд 9 дүгээр сард ЗХАХ-ийн ажилтнууд Халиун, Г.Уянга нар уулзалтын зар, урилгыг цахим шуудангаар түгээж, бүртгэл хөтлөн ЗХАХ-ийн дарга Ө.Ундрах хэлэлцүүлгийн эхний хэсгийг чиглүүлж, ОУХБ-ын шинжээч, зөвлөх нарт орчуулга хийж оролцов.

Мөн Хүний эрхийн олон улсын өдөр зохион байгуулах ажлын хүрээнд "Хувийн хэвшил дэх хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" зөвлөлдөх уулзалт болон судалгааны ажлын тайлангийн хэлэлцүүлэх уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд ЗХАХ-ийн ажилтнууд Халиун, Г.Уянга нар уулзалтын зар, урилгыг цахим шуудангаар түгээж, бүртгэл хөтлөх, тараах материал бэлдэх ажлыг гүйцэтгэн ЗХАХ-ийн дарга Ө.Ундрах хэлэлцүүлгийн үеэр ОУХБ-ын зөвлөхөд нарт орчуулга хийж оролцлоо.

Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн хэрэгжилтийг анх удаа цогцоор нь судалж, судалгааны тайланг товхимол болгон монгол англи хэл дээр хэвлүүлэн УИХ, Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгэм, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийтэд түгээж байна. Судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг нийт 3 удаа 90 орчим оролцогчтой зохион байгуулж, холбогдох талуудын судалгааны дүгнэлт, санал зөвлөмжийг танилцуулж ажиллаа.

Хүний эрхийн Үндэсний Комисс Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран 2017оны 12 дугаар сарын 6-ны өдөр "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл болон хувийн хэвшил дэх хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт" зөвлөлдөх уулзалтыг Засгийн газар, ажил олгогч ажилтны төлөөллийн байгууллагын удирдах албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулж, хөдөлмөрлөх эрхийн чиглэлээр Монгол Улсын нэгдсэн орсон гэрээ, конвенцуудын хэрэгжилт хэр байгааг, Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн хэрэгцээ шаардлага, хөдөлмөрийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлсэн нь чухал ач холбогдолтой боллоо.

**1.3.2 Хүүхдийн эрх, хамгааллын талаар судалгаа хийх, тайлан боловсруулах**

Комисс нь Гууд Нэйборс олон улсын байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран “Хүүхдийн эрхийн цахим сургалт” төслийг 2016-2017 онд хэрэгжүүлж, энэхүү төслийн хүрээнд “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа, “Хүүхдийн эрхийн цуврал нэвтрүүлэг”, “Төрийн алба хаагчдыг чадавхижуулах онлайн сургалт”, “Хүүхдийн эрхийн клуб” дэд төслүүдийг хэрэгжүүлж байна.

“Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгааг Улаанбаатар хотын 7 дүүрэг, 8 аймгийн нутаг дэвсгэрт амьдарч буй 12-18 насны нийт 4264 хүүхэд, 2743 эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд хамгааллын хамтарсан багийн 152 гишүүнийг хамруулан хийлээ.

“Хүүхдийн эрх, хамгаалал” судалгааны үр дүнд тулгуурлан Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар бие даасан бүлэг боловсруулж, УИХ-д өргөн барьснаар хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаар хууль тогтоогч, үүрэг хүлээгч нарт бодит мэдээлэл хүргэж, цаашид хууль эрх зүйн болон бодлогын түвшинд хийх өөрчлөлтөд зохих нөлөөллийн ажил боллоо.

Энэхүү судалгааны тайланг монгол, англи, солонгос хэл дээр хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгов. Мөн хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн албан хаагчид, үүрэг хүлээгчдийн хүүхдийн эрхийн талаарх үүрэг, хариуцлага, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчид зэрэг насанд хүрэгчдийн төдийгүй хүүхэд, өсвөр насныхны хүүхдийн эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийн зөрчлийг таньж, мэдээллэдэг чадвар, дадлыг бий болгох үүднээс төрийн албан хаагчдад зориулс
ан цахим сургалтын модуль, иргэдэд зориулсан 10 цуврал киног бэлтгэв. Тус байгууллагатай хамтран 2016-2017 онд хэрэгжүүлсэн “Хүүхдийн эрхийн цахим сургалт”-ын модулийг Комиссын цахим сургалтын талбарт байршуулан 2018 оноос цахим сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

### 1.3.3 Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрх

Монгол Улсад амьдарч буй үндэстний цөөнхөөс хамгийн их хүн амтай Баян-Өлгий аймаг бөгөөд казах хүүхдүүдийн сурч боловсрох эрх, боловсролын чанарыг хөндөн судалсан судалгаанууд байдаг болович тэрхүү цөөнхийн дотор мөн цөөнх болж, өөрсдийн хэл, соёлоороо ялгаран амьдарч буй тува, дөрвөд, урианхай, халх хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, боловсролын чанар, суралцахад тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлсэн судалгаа 2016 оныг хүртэл огт хийгдээгүй байсан.

Иймд Баян-Өлгий аймагт амьдарч байгаа угсаа гарал, хэл, соёлын хувьд ялгаатай, хэлний цөөнх болох халх, дөрвөд, урианхай, тува, казах угсаатны бүлгийн хүүхдүүдийн сурч боловсрох эрх, төрөлх хэлээрээ сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, санал зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв.Энэхүү судалгааны ажлыг “Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл” төрийн бус байгууллага Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хамтран гүйцэтгэхээр 2016 оны 12 дугаар сарын 6-ний өдөр №SNHROCM/2016/010 дугаар гэрээ байгуулсан болно.

Комиссын даргын баталсан “Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт” судалгааны ажлын удирдамжийн дагуу судалгааны баг 2016 оны 12 дугаар сарын 5-22-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Буянт, Цэнгэл, Булган зэрэг 8 сумаас судалгааны мэдээллийг цуглуулан, боловсруулах, тайлан бичих ажлыг гүйцэтгэсэн.

Судалгаанд зорилтот бүлгийн буюу хэлний цөөнх 9-10 насны 60, 11-18 насны 156, хяналтын бүлгийн буюу Казах хэлтэй 9-10 насны 57, 11-18 насны 155 сурагч, эцэг эх, асран хамгаалагч 169, багш 85, боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, удирдлага 11, нийт 693 хүн хамрагдсан. Судалгааны багийн урьдчилсан тайлангийн мэдээлэлд тулгуурлан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн нэгдүгээр бүлгийн Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрх дэд сэдэв болгон оруулж, шийдвэр гаргуулахаар холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлээд байна.

### 1.3.4 Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага 2016 оны 1 дүгээр сараас эхлэн хүний наймааны хохирогч болон шилжин суурьшигчийг эрсдэлээс хамгаалах зорилгоор 2 жилийн хугацаатай төслийг Монгол дахь уул уурхайн үйл ажиллагаа түлхүү явагдаж буй бүс нутаг Өмнөговь, Дорноговь аймагт хэрэгжүүлж байна.

Төслийн үндсэн зорилго нь Монгол улсын иргэний нийгмийн чадавхийг сайжруулах, шилжин суурьшигчид, хүний наймааны хохирогчдод тусламж дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, хүний наймаа болон хүний эрхийн зөрчилтэй тэмцэгч байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхижуулах юм. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2010 онд хэрэгжүүлсэн “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомжид хийх судалгаа, дүн шинжилгээ” төслийн хүрээнд боловсруулсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийн хэрэгжилтэд өгөх зөвлөмжийг боловсруулахад чиглэж байна. Иймд Комисс Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран баталсан удирдамжийн дагуу “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийх” судалгааны ажлыг “Иргэдэд туслах хүний эрх” ТББ-ын тэргүүн хуульч С.Дондов гүйцэтггэсэн болно.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг боловсронгуй болгох чиглэлээр нийт 14 санал зөвлөмж гаргалаа.

*Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнтэй холбогдох хүний эрхийн асуудлуудын талаар дүн шинжилгээ, нөлөөллийн ажил зохион байгуулах*

*Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, Жендэрийн үндэсний тогтолцооны талаар дүн шинжилгээ хийх*

Комисс нь Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4.б дэх хэсэгт заасны дагуу уг хуулийг хэрэгжүүлэх талаар үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой чиг үүргийн хэрэгжилтийн байдал, ололт амжилт, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээний хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба, яамд, нийслэлийн болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг нийт 61 төрийн байгууллагаас асуулгаар мэдээлэл цуглуулж, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны өнөөгийн төлөв байдлыг тодорхойллоо.

Дүн шинжилгээгээр жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд яамдын салбар зөвлөл, аймаг, нийслэлийн салбар хороод тэргүүлэх үүрэгтэй боловч дийлэнх нь үйл ажиллагаа тогтмолжоогүй, жендэрийн асуудлаарх мэдлэг, ойлголт сул, мэдээлэл хангалтгүй байгаа нь тогтоогдов. Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг авч үзэхэд тайлан гаргах зэрэг хэлбэрийн төдий шинжтэй ажлууд хийгдсэн байх бөгөөд ялангуяа дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөх, төсөвт тусгуулах зэрэг илүү бодлогын түвшний чиг үүргийг хэрэгжилт хангалтгүй байлаа.

Мөн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд дээрх байгууллагуудын явуулсан үйл ажиллагааг судлахад гол төлөв олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн санаачлага, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн ажлыг эс тооцвол тухайн байгууллагын санаачлагаар хуульд заасны дагуу төсвийн санхүүжилтээр явуулсан ажил хомс байна. Иймд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд жендэрийн асуудалд ач холбогдол өгдөггүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх идэвх, санаачлага дутмаг гэж үзлээ.

Ийнхүү Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдлын талаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ тусгаж УИХ-аас шийдвэр гаргуулахаар 4 санал зөвлөмжийг хүргүүллээ.

Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнтэй холбогдох хүний эрхийн асуудлаар

- Референт Г.Ууганбаатар 2017 оны 09 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Дорноговь аймгийн Улаанбадрах, Замын-Үүд сумдад ажиллаж тус сумдын нутаг дэвсгэр дэх байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хэрхэн хангагдаж буй талаар мэдээлэл цуглуулж, Улаанбадрах суманд 44 оролцогчийг хамруулсан сургалт зохион байгуулж нөлөөллийн ажиллагаа хийв.
Дархан-Уул аймаг дахь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламж, явган хүний зам, гарцыг MNS 5682-2006, MNS 6056-2009, MNS 6055-2009 стандартад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх.

Комиссын даргын 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу референт Б.Сэмжидмаа, Дархан-Уул аймаг дахь ахлах мэргэжилтэн Ц.Долгорсүрэн, тус аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтран 2017 оны 6 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламж, явган хүний зам, гарцыг MNS 5682-2006, MNS 6056-2009, MNS 6055-2009 стандартад нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж,

иргэдээс санал асуулга авч дүн шинжилгээний илтгэх хуудсыг 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Комиссын даргад танилцуулсан байна.

## ХОЁР. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт, уулзалт

#### 2.1.1 Хүний эрхийн цуврал лекц зохион байгуулах

2017 онд 6 удаагийн хүний эрхийн цуврал лекцийг зохион байгуулахаар төлөвлөснөөс нэг илтгэгч ажлын шаардлагаар оролцох боломжгүй болсон тул 5 удаагийн лекцид 714 хүн хамрагдсан байна.

1. 2017 оны эхний лекц буюу 31 дэх удаагийн Хүний эрхийн олон нийтийн лекцийг 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр МУИС-ын хичээлийн 1 дүгээр байрны Лекцийн танхимд "Тогтвортой хөгжлийн 4-р зорилго: Нийгмийг хувирган өөрчлөх боловсролын хүч чадал" сэдвээр зохион байгуулсан бөгөөд илтгэгчээр "Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч Д. Тунгалаг оролцож, боловсролын асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд, сургуулийн багш нар, ИНБ, иргэд, оюутнууд зэрэг 74 хүн хамрагдлаа.

2. Энэ оны 2 дахь лекц буюу 32 дахь удаагийн лекцийг 2017 оны 5 сарын 24-ний өдөр МУИС-ын хичээлийн 1 дүгээр байрны Лекцийн танхимд “Хүний эрхийн хангахад Парламентын чиг үүрэг” сэдвээр зохион байгуулсан бөгөөд илтгэгчээр УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Д.Цогтбаатар оролцож, ХЭҮК-той Санамж бичиг байгуулсан байгууллагуудын ажилтнууд, иргэд, ИНБ, оюутнууд, ХЭҮК-ын ажлын албаны ажилтнууд зэрэг 40 хүн хамрагдлаа.

3. НҮБ-ын Хүрээлэн буй орчин хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Жон Нокс Монгол Улсад айлчилсантай холбогдуулан Ц.Оюунгэрэлийн “Усны эрх” лекцийг 10 дугаар сарын 12-ны өдөр болгон хойшлуулж 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Хүрээлэн буй орчин хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Жон Ноксын “Хүний эрхийг хамгаалахад хүрээлэн буй орчныг хамгаалах нь” сэдэвт олон нийтийн лекцийг зохион байгуулав. Тус лекцид төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургуулийн багш, оюутнуудын төлөөлөл зэрэг 138 хүн хамрагдлаа.

4. 2017 оны 10 дугаар сарын 12*-ний өдөр “Ус бол хүний эрх”* сэдвээр УИХ-ын гишүүн асан, Нутгийн шийдэл сангийн тэргүүн Ц.Оюунгэрэл лекц уншив. Лекцид 51 хүн оролцлоо.

5. 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр МУИС-ын ХЗС-ын захирал, доктор Ж.Эрдэнэбулган “Эрүүгийн хууль ба хүний эрх” сэдвээр лекц уншив. Лекцид 54 хүн оролцлоо.

#### 2.1.2 “Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалтыг зохион байгуулах

Хүний эрхийн Үндэсний Комисс, Нээлттэй нийгэм форум ТББ-тай хамтран хүний эрхийн тулгамдсан асуудал, чухалчлагдаж буй сэдвийн хүрээнд төр, иргэний нийгмийн байгууллага, судлаач, иргэдийн үзэл бодол, байр суурийг харилцан солилцох, хүний эрхийн мэдлэг ойлголтыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалтыг жилд 10 удаа буюу 7-8 сараас бусад үед сар тутам зохион байгуулдаг уламжлалтай. 2017 оны байдлаар нийт 10 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 400 гаруй хүн хамруулсан байна.

“Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалтыг 2017 онд зохион байгуулсан байдал:

| д/д | Өглөөний уулзалтын сэдэв | Уулзалтын зочин | Огноо, уулзалт болсон газар |
|---|---|---|---|
| 1. | Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг Монголд нутагшуулах нь | Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Удирдах зөвлөлийн дэд дарга У.Тамир | 2017.01.19 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 2. | Улаанбаатар хотын дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэдийн орон байртай байх эрх | Эмнести интернэшнл ТББ-ын зохицуулагч П.Мөнхжаргал | 2017.02.16 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 3. | Шинэчлэн найруулсан | Монгол Улсын Дээд Шүүхийн | 2017.03.16 Нээлттэй |

| | | | |
|---|---|---|---|
| | эрүүгийн хууль | Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн | нийгэм форумын хурлын танхимд |
| 4. | Зөрчлийн тухай хуулийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл | МУИС-ийн ХЗС-ийн багш, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор П.Одгэрэл | 2017.04.20 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 5. | Эрүүгийн процесст халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалах нь | МУИС-ийн ХЗС-ийн багш, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор О.Мөнхсайхан | 2017.05.18 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 6. | Ерөнхий боловсролын сургуулийн засаглалд эцэг эхчүүдийн оролцоо | “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвслийн зохицуулагч Д.Тунгалаг | 2017.06.15 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 7. | Хүрээлэн буй орчин ба хүний эрх | НҮБ-ын хүрээлэн буй орчин, хүний эрхийн тусгай илтгэгч, ноён Жон Х Нокс | 2017.09.21 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 8. | Эрх зүйн туслалцаа ба хүний эрх | ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа | 2017.10.19 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 9. | Тогтвортой хөгжлийн зорилтууд Монгол Улсад | ҮСХ-ны Статистик, эрдэм шинжилгээ, арга зүйн газрын ахлах статистикч М.Оюунжаргал | 2017.11.16 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |
| 10. | Монгол Улс дахь хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал | "Хүний эрхийн хяналтын төв" ТББ-ын Тэргүүн О.Нацагдорж | 2017.12.14 Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд |

Өглөөний уулзалтыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын эрүүгийн багц хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрүүгийн багц хуулиас урган гарч болзошгүй нөхцөл байдал, давуу тал, шинэлэг зохицуулалтын талаар мэргэжлийн хуульчид, эрдэмтэн судлаачдыг урьж мэдээлэл хийсэн байна.
Сар бүр зохион байгуулдаг Хүний эрхийн тухай ярилцъя өглөөний уулзалтын 11 дүгээр сарын ээлжийг төлөвлөн 11 дүгээр сарын 16-ны өдөр Үндэсний Статистикийн Хорооны ахлах статистикч М.Оюунжаргалыг зочноор урьж танилцуулга хийлгэх ажлыг ЗХАХ зохион байгуулав.
Түүнчлэн өглөөний уулзалтуудаар Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн байгууллага ёс зүйн зөрчил дутагдал гаргасан тохиолдолд түүнийг шийдвэрлэж буй байдал, дотоод зохицуулалтын механизм, Улаанбаатар хотын дахин төлөвлөлтөөс урган гарч буй хүндрэл бэрхшээл, Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, Эрх зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт, Тогтвортой хөгжлийн зорилтууд-Монгол Улсад, Хөдөлмөрлөх эрхлэлтийн нөхцөл байдал, асуудлыг шийдвэрлэх арга зам, гарцыг хэлэлцэн ярилцсан юм. Ирэх 2018 онд уг арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулахаар тогтоод байна.

**2.1.3 Хуульчийн багц цаг олгох сургалт зохион байгуулах ажлын хүрээнд**

Монголын Хуульчдын Холбоонд 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Үндсэн хууль ба хүний эрх, Хүний эрхийн олон улсын гэрээ, Хүүхдийн эрх ба хамгаалал, Нийтийн хэв журам ба хүний эрх, Эрүү шүүлтээс ангид байх эрх, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх нийт 6 сэдвийн сургалтын танилцуулга, хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр хүргүүлсэн.

Монголын хуульчдийн холбооны чиг үүргийн хорооноос 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 1/211 тоот албан бичгээр “Үндсэн хууль ба хүний эрх” сэдэвт 0.5 багц цагийн сургалт, “Хүний эрхийн олон улсын гэрээ” сэдэвт 0.5 багц цагийн сургалт, “Хүүхдийн эрх ба хамгаалал” сэдэвт 0.5 багц цагийн сургалт, “Нийтийн хэв журам ба хүний эрх” сэдэвт 0.5 багц цагийн сургалт, “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт 0.5 багц цагийн сургалт, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх” сэдэвт 0.5 багц цагийн сургалтын хөтөлбөрийг тус тус магадлан итгэмжилсэн болно. Хөтөлбөрийн пагуу

- 2017 оны 5 дугаар сарын 18-ний өдөр Орхон аймаг дахь Хуульчдын холбооны хуульч, өмгөөлөгчдөд Хүүхдийн эрхийн үндсэн асуудал сэдвээр, 4 цагийн сургалт, 52 хүнд.

- 2017 оны 5 сарын 19-ний өдөр Хуульчдын холбооны хуульч, өмгөөлөгчдөд Хүний эрх ба Үндсэн хууль, Хүний эрхэд суурилсан хандлага сэдвээр 4 цагийн сургалтыг, 18 хүнд
- 2017 оны 5 сарын 20-ны өдөр Монголын Хуульчдын холбооны гишүүдэд " Хүүхдийн эрх, хамгаалал сэдвээр 4 цагийн сургалт, 18 хүнд
- 2017 оны 10 дугаар сар Хүний эрхийн олон улсын гэрээ, Хүүхдийн эрх ба хамгаалал сэдвээр 4 цагийн сургалт 20 хүнд
- 2017 оны 11 сарын 23-ний өдөр Үндсэн хууль ба хүний эрх сэдвээр 4 цагийн сургалт 30 хүнд
- 2017 оны 11 сарын 10-ны өдөр Эрүү шүүлтээс ангид байх эрх, Халдашгүй чөлөөтэй байх эрх сэдвээр 4 цаг, 15 хүнд
- 2017 оны 12 сарын 15-ны өдөр Хүний эрх ба Үндсэн хуулийн эрх зүй сэдвээр 4 цагийн сургалт 19 хүнд тус тус зохион байгуулсан байна. Сургалтыг ХЭҮК-ын дарга, гишүүн, ажлын албаны дарга, хэлтсийн дарга нар заасан бөгөөд ажлын албаны зүгээс зохион байгуулалтын ажлыг хангаж ажилласан болно.

Нийт 7 удаа, 28 цагийн сургалтыг 172 хүнд зохион байгуулсан байна.

**2.1.4** *Байгууллагын хүсэлт, захиалгаар хүний эрхийн сургалт зохион байгуулах*

2017 онд төвийн ажилтнууд 106 удаагийн, 317,5 цагийн сургалтыг 5032 оролцогчид, орон нутгийн ажилтнууд 447 удаагийн, 588,8 цагийн сургалтыг 18432 оролцогчид тус тус зохион байгуулсан ба орон даяар нийтдээ 553 удаагийн 90663 цагийн сургалтыг 23765 оролцогчид зохион байгуулсан байна.

| д/д | Аймгийн нэр | Сургалт | |
|---|---|---|---|
| | | Давтамж/цаг | Оролцогчдын тоо |
| 22. | Архангай аймаг | 4 удаа, 7 цаг | 68 хүнд |
| 23. | Баян-Өлгий | 17 удаа, 29,5 цаг | 577 хүн |
| 24. | Баянхонгор | 30 удаа, 33 цаг | 1207 хүн |
| 25. | Булган | 28 удаа, 37,5 цаг | 1592 хүн |
| 26. | Говь-Алтай | 21 удаа, 26,5 цаг | 930 хүн |
| 27. | Говьсүмбэр | 15 удаа, 20 цаг | 708 хүн |
| 28. | Дархан-Уул | 39 удаа, 49 цаг | 1689 хүн |
| 29. | Дорнод | 7 удаа, 6,5 цаг | 446 хүн |
| 30. | Дорноговь | 72 удаа, 76 цаг | 3701 хүн |
| 31. | Дундговь | 26 удаа, 41,5 цаг | 1093 хүнд |
| 32. | Завхан | 18 удаа, 30 цаг | 380 хүн |
| 33. | Орхон | 6 удаа, 11 цаг | 141 хүн |
| 34. | Өвөрхангай | | |
| 35. | Өмнөговь | 18 удаа, 23 цаг | 288 хүн |
| 36. | Сүхбаатар | 7 удаа, 12,8 цаг | 160 хүн |
| 37. | Сэлэнгэ | 26 удаа, 37,5 цаг | 1008 хүн |
| 38. | Төв | 29 удаа, 41 цаг | 707 хүн |
| 39. | Увс | 22 удаа 20,5 цаг | 1196 хүн |
| 40. | Ховд | 21 удаа, 25.5 цаг | 1171 хүнд |
| 41. | Хөвсгөл | 15 удаа, 17 цаг | 378 хүн |
| 42. | Хэнтий | 26 удаа, 44 цаг | 992 хүн |

**2.1.5** *Хуулийн байгууллагуудад хүний эрхийн сургалт зохион байгуулах*

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн сургалт
   2017 онд Төвийн ажилтнууд ШШГЕГ-ын харьяа анги, байгууллагуудад нийт 8 удаа, 44 цагийн сургалт хийж 272 хүн хамрагдсан байна.
2. Цагдаагийн байгууллагад хийсэн сургалт
   2017 онд Төвийн ажилтнууд 34 удаа, 63 цагийн сургалт хийж 1747 алба хаагч хамрагдсан байна.
3. ЗХЖШ, ХХЕГ-ын харьяа анги, байгууллагуудад хийсэн сургалт
   8 удаа 14 цагийн сургалт хийж 439 алба хаагч хамрагдсан байна.

**2.1.6 ХЭСХ, ХЭБ, Хүүхдийн эрх зэрэг сэдвээр цахим сургалт зохион байгуулах, сургалтын агуулга, арга зүйг баяжуулах**

9 дүгээр сарын 4-өөс 9 дүгээр сарын 22-ны өдрүүдэд 3 долоо хоногийн хугацаанд Комиссын орон нутгийн ажилтнуудад зориулан “Хүний эрхийн боловсрол” цахим сургалтыг зохион байгуулав.

Мөн Гүүд Нэйборс олон улсын байгууллагатай хамтран “Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар цахим сургалтын 10 цуврал хичээл бүхий модуль бэлтгэн гаргасан бөгөөд, цахим талбарт байршуулахад шаардлагатай талбарын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагын үүднээс Мэдээлэл, харилцаа, холбооны зохицуулах газарт хүсэлт тавьж 3gbt-ын хэмжээтэй талбарыг 20gbt болгон нэмэгдүүлснээр цахим сургалтын видео материалуудыг бүрэн байршуулж ашиглах боломжтой болоод байна.

**2.1.7** *Хамтран ажиллагч байгууллагуудад "Хүний эрхийн сургагч" багш бэлтгэх сургалт зохион байгуулах*

Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Цагдаагийн Ерөнхий газрын сургалтын нэгдсэн төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран тус байгууллагуудын ажилтнуудад Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажилласан.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг төлөвшүүлэхэд Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа алба, байгууллагуудын сургалт хариуцсан ажилтнуудыг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэж, тухайн алба хаагчдаар дамжуулж хүний эрхийн боловсрол олгох сургалтыг тасралтгүй зохион байгуулах зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 11,12,13-ны өдрүүдэд сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг Цагдаагийн Ерөнхий Газрын Сургалтын нэгдсэн төвийн сургалтын танхимд зохион байгууллаа.

Сургалтад “Хүний эрхийн үндсэн ойлголт, зарчим, хүний эрхэд суурилсан хандлага”, “Хүний эрхийн олон улсын гэрээг хэрэглэх нь” “Жендэрт суурилсан хүчирхийлэл ба гэр бүлийн хүчирхийлэл” “Хүүхдийн эрх” “Амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрх” “Эрүү шүүлтээс ангид байх эрх чөлөө” зэрэг сэдвээр 10 дугаар сарын 11-ний өдөр онолын мэдээллийг өгөв.

Сургалтын хоёр дахь өдөр буюу 10 дугаар сарын 12-ны өдөр дээрх сэдвүүдээр багаар ажиллах, хэлэлцүүлэг, кейс дээр ажиллах, дадлага ажлыг хийлгэх зэрэг оролцооны аргад тулгуурлан хичээлийн сэдвүүдийг бататгасан.

Сургалтын гурав дахь өдөр буюу 10 дугаар сарын 13-ны өдөр сургалтад хамрагдсан алба хаагчдыг 5 бүлэгт хувааж, “Төрийн үйлчилгээ ба иргэдийн эрх”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм”, “Ажлын байрны бэлгийн дарамт”, “Халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах төрийн үүрэг”, “Хүүхдийн эрхийг хамгаалах хамтарсан баг” сэдвүүдээр оролцогчдоор хичээл заалгуулж сургалтын агуулга, оролцоо, идэвх санаачлага, заах арга зүй, ур чадвар, чанарт үнэлгээ өгч багуудыг байр эзлүүлэв.

Сургалтад нийт 25 алба хаагч оролцсоноос эрэгтэй 15, эмэгтэй 10 алба хаагч хамрагдаж, сургалтын явцад санал солилцох, асуулт хариулт, харилцан ярилцаж идэвхтэй оролцлоо.

Цагдаагийн байгууллагын сургагч багш нарыг давтан сургах, ХЭҮК-той танилцуулах 1 өдрийн сургалтыг зохион байгуулж Улаанбаатар хотын харьяаны 20 алба хаагчийг хамруулав.

2017 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, тус байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг төлөвшүүлэхэд ШШГЕГ-ын харьяа алба, байгууллагуудын сургалт хариуцсан ажилтнуудыг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэх, тэднээр дамжуулан хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах зорилгоор "Хорих байгууллага ба хүний эрх” сэдэвт хүний эрхийн сургагч багш бэлтгэх кредит цагийн сургалт зохион байгууллаа.

Тус сургалтаар "Эрүү шүүлтээс ангид байх эрх”, "Хорих байгууллага ба хүний эрх”, "Онцгой анхаарал шаардлагатай хоригдлууд”, "Хоригдлын хөдөлмөр ба албадан хөдөлмөрийг хориглох нь”, "Хуульчийн

ёс зүй", "Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх үед хүний эрхийг хангах нь" зэрэг сэдвээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв болон орон нутгийн 38 алба хаагчийг оролцуулж, хүний эрхийн сургагч багшаар бэлтгэж, сертификат гардуулав. Сургалтад оролцогчид цаашид хүний эрхийн сургалт, сурталчилгааг харьяа анги байгууллагууддаа зохион байгуулах юм. Мөн дээрх сургалтад зориулж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргаж буй цувралын 4 дэх дугаар болох "Хорих байгууллага ба хүний эрх" сэдэвт сургагч багш нарт зориулсан гарын авлагыг 250 хувь хэвлүүлэн өгсөн бөгөөд тус сургалтад оролцогчдыг олон улсын болон дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд бие даан судлах, эзэмших арга зүйг хослуулан хүний эрхийн сургалтыг дадлагатай нь хамтатган эзэмшүүлэх, цаашид үргэлжлүүлэн бие даан сургалт явуулах чадавхтай болгохыг зорьсон юм.

Монголын Ажил олгогч эзлийн нэгдсэн холбоотой сургалтын талаар хэд хэдэн удаагийн уулзалт хийхээр хүсэлт тавьсан боловч тухайн байгууллагын ажлын зохион байгуулалттай холбоотойгоор тус сургалтыг хийх боломжгүй болсон.

**2.1.8** *Сургагч багшийн гарын авлагуудыг шинэчлэн сайжруулах*

Сургагч багшийн 22 гарын авлагыг хариуцсан эрхийн хүрээнд ажилтнууд хуваарь гарган шинэчлэх, сайжруулах ажлыг хийж байна.

**2.1.9** *"Хүний эрхэд суурилсан хандлага - Төр-иргэний харилцаа" сургалтыг төрийн албан хаагчид, бичил уурхай эрхлэгчдийг хамруулан зохион байгуулах*

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бичил уурхай бүхий сумдын удирдлага, төрийн албан хаагч нийт 400 хүн, бичил уурхай эрхлэгч 1000 нийт 1400 хүнд "Хүний эрхэд суурилсан хандлага ба Төр-иргэний харилцаа" сургалтыг 10 аймгийн 25 суманд хүрч ажиллахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу **2017 онд 6 аймгийн (Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Увс, Ховд, Хэнтий) 17 суманд ажиллаж нийт 843 хүнийг хамруулсан 92 цагийн сургалтыг зохион байгууллаа**.

Мөн "Бичил уурхай дахь хүний эрх" жижиг тэтгэлэгт хөтөлбөрийг **Баянхонгор, Дундговь, Увс, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад хэрэгжүүлсэн бөгөөд тус тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтад 991 хүн, нийт 1825 хүн хамрагдсаны 1046 нь эрэгтэй, 779 нь эмэгтэй,** эдгээрийн 691 нь төрийн албан хаагч, 764 нь бичил уурхайчин, 225 нь хувиараа ашигт малтмал олборлогч, 53 иргэн, 95 ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, 9 нь уул уурхайн компани ажилтнууд байсан байна.

Сургалтад оролцогчдын дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээс харна уу

| № | Хаана | Хэзээ | Оролцогчид | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Баянхонгор аймгийн Галуут сум** | 2017.05.12 Баасан гариг | **Нийт оролцогч 49** | **33** | **16** |
| | | | Төрийн албан хаагч -24 | 15 | 9 |
| | | | Бичил уурхайчин-25 | 18 | 7 |
| 2 | **Баянхонгор аймгийн Жаргалант сум** | 2017.05.13 Бямба гариг | **Нийт оролцогч 44** | **30** | **14** |
| | | | Төрийн албан хаагч | Амралтын өдөр | |
| | | | Бичил уурхайчин-44 | 30 | 14 |
| 3 | **Архангай аймаг Цэнхэр сум, Орхон баг** | 2017.05.22 Даваа гариг | **Нийт оролцогч -78** | **34** | **44** |
| | | | Төрийн үйлчилгээ -28 | 5 | 23 |
| | | | Төрийн захиргаа -8 | - | 8 |
| | | | Иргэн-6 | 2 | 4 |
| | | | ХАМО -36 | 27 | 9 |
| 4 | **Архангай аймаг Эрдэнэбулган сум** | 2017.05.23 Мягмар гариг | **Нийт оролцогч -37** | **4** | **33** |
| | | | Төрийн үйлчилгээ -33 | 3 | 30 |
| | | | Төрийн захиргаа -3 | - | 3 |
| | | | иргэн -1 | 1 | |
| 5 | **Хэнтий аймгийн Батноров сум** | 2017.05.24 Лхагва гариг | **Нийт оролцогч -66** | **14** | **52** |
| | | | Улс төрийн албан хаагч-4 | 4 | - |
| | | | Төрийн захиргаа-11 | 4 | 7 |
| | | | Төрийн үйлчилгээ-26 | 2 | 24 |
| | | | Иргэн -5 | 2 | 3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Бичил уурхайчин -7 | 2 | 6 |
| | | | ХАМО-13 | - | 13 |
| 6 | **Хэнтий аймгийн Бэрх тосгон** | 2017.05.25 Пүрэв гариг | **Нийт оролцогч -58** | **24** | **34** |
| | | | Төрийн тусгай (Цагдаа)-6 | 6 | - |
| | | | Төрийн захиргаа-10 | 4 | 6 |
| | | | Төрийн үйлчилгээ-23 | 4 | 19 |
| | | | Иргэн -4 | - | 4 |
| | | | Бичил уурхайчин -5 | 1 | 4 |
| | | | ХАМО-10 | 9 | 1 |
| 7 | **Хэнтий аймгийн Бор-Өндөр сум** | 2017.05.26 Баасан гариг | **Нийт оролцогч -57** | **19** | **38** |
| | | | Төрийн тусгай (Шүүх, Цагдаа, Онцгой)-10 | 2 | 8 |
| | | | Төрийн захиргаа-16 | 4 | 12 |
| | | | Төрийн үйлчилгээ-23 | - | 23 |
| | | | Уул уурхайн компани-7 | 7 | - |
| | | | Бичил уурхайчин -11 | 6 | 5 |
| 8 | **Говь-Алтай, Бигэр сум** | 2017.06.11 | **Нийт оролцогч -30** | **10** | **20** |
| | | | Төрийн албан хаагч-30 | 10 | 20 |
| 9 | **Говь-Алтай, Есөнбулаг сум** | 2017.06.12 | **Нийт оролцогч-113** | **46** | **67** |
| | | | Төрийн албан хаагч-85 | 41 | 44 |
| | | | Бичил уурхайчин-7 | 4 | 3 |
| | | | ХАМО-2 | 1 | 1 |
| | | | Иргэн-19 | | 19 |
| 10 | **Ховд, Цэцэг сум** | 2017.06.14 | Тайлбар: УИХ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Бямбацогт тус суманд ирсэнтэй холбоотойгоор иргэд, төрийн албан хаагчидтай хийх уулзалттай давхцсантой холбоотой сургалтад оролцох хүмүүс цуглараагүй тул сургалт хийгээгүй болно. | | |
| 11 | **Ховд аймгийн Мөст сум** | 2017.06.14 | **Нийт оролцогч -18** | **9** | **9** |
| | | | Төрийн албан хаагч-11 | 4 | 7 |
| | | | ХАМО-3 | 3 | - |
| | | | Иргэн -4 | 2 | 2 |
| 12 | **Ховд аймгийн Үенч сум** | 2017.06.15 | **Нийт оролцогч -33** | **20** | **13** |
| | | | Төрийн албан хаагч-16 | 4 | 12 |
| | | | Бичил уурхайчин-11 | 11 | - |
| | | | ХАМО-3 | 2 | 1 |
| | | | Иргэн -3 | 3 | - |
| 13 | **Ховд, Алтай сум** | 2017.06.15 | **Нийт оролцогч -22** | **16** | **6** |
| | | | Төрийн албан хаагч-18 | 12 | 6 |
| | | | Бичил уурхайчин-3 | 3 | - |
| | | | ХАМО-1 | 1 | - |
| 14 | **Ховд, Булган сум** | 2017.06.16 | **Нийт оролцогч -23** | **17** | **6** |
| | | | Төрийн албан хаагч-7 | 6 | 1 |
| | | | Бичил уурхайчин-13 | 9 | 4 |
| | | | ХАМО-3 | 2 | 1 |
| 15 | **Увс, Өмнөговь сум** | 2017.06.18 | **Нийт оролцогч -29** | **11** | **18** |
| | | | Төрийн албан хаагч-22 | 9 | 13 |
| | | | Бичил уурхайчин-5 | 2 | 3 |
| | | | Иргэн -2 | | 2 |
| 16 | **Увс аймгийн Тариалан сумын Бор-хавцалд** | 2017.06.18 | **Нийт оролцогч -155** | **123** | **32** |
| | | | Бичил уурхайчин-155 | 123 | 32 |
| 17 | **Увс аймгийн Түргэн сум** | 2017.06.19 | **Нийт оролцогч -22** | **123** | **32** |
| | | | Төрийн албан хаагч -19 | 11 | 8 |
| | | | Бичил уурхайчин-3 | 2 | 1 |
| | | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | **Нийт оролцогч** | **843** | **423** | **411** |
| | **Төрийн албан хаагч** | **433** | 150 | 283 |
| | **Бичил уурхайчин** | **290** | 211 | 79 |
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | **71** | 45 | 26 |
| | **Иргэн** | **42** | 10 | 32 |
| | **Уул уурхайн компани (улсын үйлдвэрийн газар)** | **7** | 7 | |

| **“Бичил уурхай дахь хүний эрх” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **УВС АЙМАГ** | | | | | |
| **№** | **Хаана** | **Хэзээ** | **Оролцогчид** | **Эрэгтэй** | **Эмэгтэй** |
| 1 | **Увс аймгийн Түргэн сум** | 2017.05.26 Баасан гариг | **Нийт оролцогч 23** | **18** | **5** |
| | | | Төрийн албан хаагч -10 | 5 | 5 |
| | | | Иргэн-1 | 1 | |
| | | | Бичил уурхайчин-1 | 1 | |
| | | | ХАМО иргэн - 11 | 11 | |
| 2 | **Увс аймгийн Давст сум** | 2017.05.27 Бямба гариг | **Нийт оролцогч 21** | **9** | **12** |
| | | | Төрийн албан хаагч-17 | 6 | 11 |
| | | | Иргэн-2 | 1 | 1 |
| | | | Бичил уурхайчин-2 | 2 | |
| 3 | **Увс аймгийн Тариалан сум** | 2017.07.27 Пүрэв гариг | **Нийт оролцогч -150** | **115** | **35** |
| | | | Төрийн албан хаагч-7 | 4 | 3 |
| | | | Бичил уурхайчин-85 | 59 | 26 |
| | | | ХАМО иргэн-58 | 52 | 6 |
| 4 | **Увс аймгийн Түргэн сум** | 2017.07.26 Лхагва гариг | **Нийт оролцогч 30** | **25** | **5** |
| | | | Төрийн албан хаагч-9 | 4 | 5 |
| | | | Бичил уурхайчин-10 | 10 | |
| | | | ХАМО иргэн-11 | 11 | |
| 5 | **Увс аймгийн Давст сум** | 2017.07.26 Лхагва гариг | **Нийт оролцогч 22** | **20** | **2** |
| | | | Төрийн албан хаагч-8 | 6 | 2 |
| | | | Бичил уурхайчин-9 | 9 | |
| | | | ХАМО иргэн-5 | 5 | |
| **Нийт дүн** | **Нийт оролцогч** | | **246** | **187** | **59** |
| | **Төрийн албан хаагч** | | **51** | **25** | **26** |
| | **Бичил уурхайчин** | | **107** | **81** | **26** |
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | | **85** | **79** | **6** |
| | **Иргэн** | | **3** | **2** | **1** |
| **БАЯНХОНГОР АЙМАГ** | | | | | |
| 1 | **Баянхонгор аймгийн Баян-овоо сум** | 2017.05.23 Мягмар гариг | **Нийт оролцогч 116** | **68** | **48** |
| | | | Төрийн албан хаагч -43 | 15 | 28 |
| | | | Бичил уурхайчин-73 | 53 | 20 |
| 2 | **Баянхонгор аймгийн Өлзийт сум** | 2017.05.25 Пүрэв гариг | **Нийт оролцогч 78** | **41** | **37** |
| | | | Төрийн албан хаагч-36 | 14 | 22 |
| | | | Бичил уурхайчин-42 | 27 | 15 |
| **Нийт дүн** | **Нийт оролцогч** | | **194** | **109** | **85** |
| | **Төрийн албан хаагч** | | **79** | 34 | 45 |
| | **Бичил уурхайчин** | | **91** | 59 | 32 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | | **22** | 9 | 13 |
| | **Уул уурхайн компани (улсын үйлдвэрийн газар)** | | **2** | 2 | |
| **СЭЛЭНГЭ АЙМАГ** | | | | | |
| 1 | **Сэлэнгэ аймгийн Ерөө сум** | 2017.06.16 | **Нийт оролцогч 98** | | |
| | | | Төрийн албан хаагч -14 | 6 | 8 |
| | | | Бичил уурхайчин-54 | 21 | 33 |
| | | | ЕБС-ын сурагч-30 | 30 | - |
| | **Сэлэнгэ аймгийн Хүдэр сум** | 2017.06.16 | **Нийт оролцогч 69** | | |
| | | | Төрийн албан хаагч-9 | 3<br>6 | |
| | | | Бичил уурхайчин-25 | 16 | 9 |
| | | | ЕБС-ын сурагч-35 | 25 | 10 |
| | **Сэлэнгэ аймгийн Бугант тосгон** | 2017.06.17 | **Нийт оролцогч -76** | | |
| | | | Төрийн үйлчилгээ -4 | - | 4 |
| | | | Төрийн захиргаа -6 | 2 | 4 |
| | | | Иргэн-8 | 6 | 2 |
| | | | ХАМО-28 | 22 | 6 |
| | | | ЕБС-ын сурагч-30 | 30 | - |
| **Нийт дүн** | **Нийт оролцогч** | | **243** | **161** | **82** |
| | **Төрийн албан хаагч** | | **33** | **11** | **22** |
| | **Бичил уурхайчин** | | **79** | **37** | **42** |
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | | **28** | **22** | **6** |
| | **Иргэн** | | **8** | **6** | **2** |
| | **ЕБС-ийн сурагчид** | | **95** | **85** | **10** |
| **ХЭНТИЙ АЙМАГ** | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Хэрлэн сум | 2017.08.07 Даваа гараг | **Нийт оролцогч -15** | **10** | **5** |
| | | | ХАМО иргэн - 15 | 10 | 5 |
| 2 | Баян-Адарга сум | 2017.10.24 Мягмар гараг | **Нийт оролцогч -13** | **10** | **3** |
| | | | Төрийн албан хаагч-3 | 2 | 1 |
| | | | Бичил уурхайчин- | 8 | 2 |
| 3 | Батноров сум | 2017.10.25 Лхагва гараг | **Нийт оролцогч -20** | **10** | **10** |
| | | | Төрийн албан хаагч-10 | 4 | 6 |
| | | | Бичил уурхайчин-9 | 5 | 4 |
| | | | ХАМО иргэн-1 | 1 | - |
| 4 | Норовлин сум | 2017.10.26 Пүрэв гараг | **Нийт оролцогч -39** | **28** | **11** |
| | | | Төрийн албан хаагч-4 | 2 | 2 |
| | | | Бичил уурхайчин-26 | 26 | 9 |
| | | | ХАМО иргэн-0 | | |
| 5 | Бэрх тосгон | 2017.10.27 Баасан гараг | **Нийт оролцогч 30** | **25** | **5** |
| | | | Төрийн албан хаагч-3 | 1 | 2 |
| | | | Бичил уурхайчин-27 | 24 | 3 |
| **Нийт дүн** | **Нийт оролцогч** | | **117** | **83** | **32** |
| | **Төрийн албан хаагч** | | **13** | **9** | **4** |
| | **Бичил уурхайчин** | | **88** | **63** | **23** |
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | | **16** | **11** | **5** |
| **ДУНДГОВЬ АЙМАГ** | | | | | |
| 1 | **Дундговь аймгийн Өлзийт сум** | 2017-05-25 Пүрэв гариг | Нийт оролцогч 60 | 27 | 33 |
| | | | Төрийн албан хаагч –33 | 12 | 21 |
| | | | Бичил уурхайнчин-27 | 15 | 12 |
| 2 | **Дундговь** | 2017.05.26 | Нийт оролцогч 60 | 25 | 35 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **аймгийн Хулд сум** | Баасан гариг | Төрийн албан хаагч –34 | 10 | 24 |
| | | | Бичил уурхайнчин-26 | 15 | 11 |
| 3 | **Дундговь аймгийн Хулд сум** | 2017.09-22 Пүрэв гариг | **Нийт оролцогч -71** | **36** | **35** |
| | | | Төрийн албан хаагч –15 | 10 | 5 |
| | | | Бичил уурхайнчин-56 | 26 | 30 |
| **Нийт дүн** | **Нийт оролцогч** | | **191** | **88** | **103** |
| | **Төрийн албан хаагч** | | **82** | **32** | **50** |
| | **Бичил уурхайчин** | | **109** | **56** | **53** |
| **Төслийн хүрээнд сургалтад хамрагдсан хүний тоог нэгтгэн дүгнэвэл** | | | | | |
| | **Нийт оролцогч** | | **991** | **623** | **368** |
| | **Төрийн албан хаагч** | | **258** | **111** | **147** |
| | **Бичил уурхайчин** | | **474** | **296** | **178** |
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | | **151** | **121** | **30** |
| | **Уул уурхайн компани (улсын үйлдвэрийн газар)** | | **2** | **2** | |
| | **Иргэн** | | **11** | **8** | **3** |
| | **ЕБС-ын ахлах ангийн сурагч** | | **95** | **85** | **10** |
| | | | | | |
| | **Нийт оролцогч** | | **1825** | **1046** | **779** |
| | **Төрийн албан хаагч** | | **691** | **261** | **430** |
| | **Бичил уурхайчин** | | **764** | **507** | **257** |
| | **Хувиараа ашигт малтмал олборлогч** | | **225** | **166** | **56** |
| | **Иргэн** | | **53** | **423** | **411** |
| | **Уул уурхайн компани (улсын үйлдвэрийн газар)** | | **9** | **9** | |
| | **ЕБС-ын ахлах ангийн сурагч** | | **95** | **85** | **10** |

**2.1.10** *Хүүхдийн эрхийн ажилтнууд, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдэд сургалт зохион байгуулах*

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн А/80 тушаалаар батлагдсан Хүүхдийн эрхийн улсын байцаагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Хүүхдийн эрхийн улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг хөтөлбөрт заасан хуваарийн дагуу 2017 оны 9 дүгээр сарын 13-ний өдөр Хүүхдийн эрхийн улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн зөрчлийг таних нь, Хүүхдийн эрх хамгаалал зэрэг сэдвээр Ажлын албаны дарга, хэлтсийн дарга, ажилтнууд 8 цагийн сургалт зохион байгуулж 38 хүн хамрагдав.

**2.1.11** *"Хүний эрх ба Бизнесийн зарчмууд" сэдвээр сэтгүүлчдийн дунд уралдаан зохион байгуулж, шалгаруулах, тайлагнах) "Байгаль орчны засаглал ба хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх" сэдэвт нийтлэл нэвтрүүлгийн уралдааныг сэтгүүлчдийн дунд зохион байгуулж, шалгаруулж тайлагнах*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах, байгаль орчны засаглал" төслийн дэмжлэгтэйгээр "Байгаль орчны засаглал ба эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх" шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн уралдааныг 2016 оны 12 дугаар сарын 09-нөөс 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн дунд зарлан зохион байгууллаа.

Уралдаанд сонин, сайтын нийтлэлийн төрөлд нийт 49 бүтээл, нэвтрүүлгийн төрөлд телевизийн 4 бүтээл, радиогийн 5 бүтээл ирснээс нийтлэлийн төрлийг 2 үе шаттайгаар шүүж, хоёрдугаар шатанд 12 бүтээлийг авч үлдэн, эхний 3 байрыг шалгаруулаа. Орон нутгаас нэг бүтээл ирэв. Нэвтрүүлгийн төрөлд ирсэн бүтээлээс нэгдүгээр байр -1, хоёрдугаар байр-1, гуравдугаар байр-1 тус тус

шалгаруулахаар зарласан байсан ч сэтгүүлчдийн бүтээлийг үнэлэх урамшуулах үүднээс 3-р байрыг нэгээр нэмж нийт 7 бүтээлийг шалгаруулан шагнаж урамшуулахаар шүүгчдийн баг шийдвэрлэлээ.

Шүүгчдийн бүрэлдэхүүнийг хөндлөнгийн хараат бус байлгах зорилгоор сэтгүүл зүйн онолын багш, эрдэмтэн судлаачид, Хүний эрхийн Үндэсний Комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс оролцуулан цөөнгүй тооны шүүгчтэйгээр үнэн зөв, шударга шүүхийг эрмэлзлээ. Хүний эрхийн чиглэлээр мэргэшин бичиж, нэвтрүүлж сурвалжилдаг сэтгүүлч цөөн биш байгаа ч уралдаанд ирүүлсэн бүтээлүүд нь тухайн уралдааны зорилгод бүрэн дүүрэн нийцээгүй, асуудалд өнгөц хандсан, баримт, судалгаа ашиглаагүй, сэтгүүл зүйн бичлэгийн ур чадвар сайтай нийтлэл, нэвтрүүлэгт хүний эрхийн асуудлыг тусгахдаа уншигч, үзэгчдэд хүний эрхийн яг ямар эрх зөрчигдөж, хөндөгдөж байгааг таниулах, сануулах явдал учир дутагдалтай, нэг ижил сэдэв, судалгааны дүнг олноороо давхацуулан, давтан нийтэлж, нэвтрүүлсэн, тухайн асуудлын гүн рүү ороогүй зэрэг нь уралдааны шүүгчдийг эргэлзүүлэх, маргаж мэтгэлцүүлэхэд хүргэж байлаа.

Байгаль орчны засаглал ба эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх" шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн уралдааны нэвтрүүлгийн төрөлд ТВ9 телевизийн сэтгүүлч Д.Ганзоригийн "Алт дагасан харуусал буюу гэрийн буурийн эрх мэдэл" Сэлэнгэ, Баянхонгор аймгаас бэлтгэсэн цуврал нэвтрүүлгүүд I байр, Гэр бүлийн радио 104.5-ын сэтгүүлч Б.Баясгалангийн "Би сурмаар байна", "Хүний эрхийн тухай ярилцъя" асуудал дэвшүүлсэн цуврал нэвтрүүлгүүд II байр, ETV телевизийн сэтгүүлч С.Шүрэнчимэгийн "Заамарчууд "Алт-2 хөтөлбөр"-ийн золиос болох уу" асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг III байр, МҮОНР-ийн Хурд агентлагийн "Баримт" эрэн сурвалжлах албаны багийн бүтээл, сэтгүүлч Ж.Золзаяа нарын "Хайрганд үнэгүйдсэн эрх" асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг III байрыг тус тус эзлэв.

Нийтлэлийн төрөлд "Засгийн газрын мэдээ" сонины сэтгүүлч Б.Баярмаагийн "Удам таслах хар хор" асуудал дэвшүүлсэн нийтлэл I байр, Инфо.мн сайтын сэтгүүлч Ц.Алдармаагийн "Хөшиглөж татсан манан буюу бид утааг ирээдүйд үлдээх үү?!!" асуудал дэвшүүлсэн нийтлэл II байр, сэтгүүлч Х.Өнөрсайханы "Би агаарын бохирдолд буруутай, би өөрийнхөө эрхийг зөрчсөн" нийтлэл III байрыг тус тус эзэлснийг снийг 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Хүний эрхийн олон улсын өдөрт зориулсан Хэвлэлийн бага хурлын үеэр шагналыг тус тус гардууллаа.

**2.1.12** _Залуучууд хөгжлийн төвийн сургагч багш, гишүүдэд сургалт зохион байгуулах (Улаанбаатар хот болон 11 аймагт)_

Тус ажлын хүрээнд Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь аймгууд болон Ханбогд, Цогтцэций сумдын Залуучууд хөгжлийн төвийн гишүүд, дэмжигчдэд 32 цагийн сургалт зохион байгуулж 85 хүн хамрагдав.

Оролцогчид сургалтаас авсан мэдлэг, ойлголт, чадвартаа тулгуурлан орон нутгийнхаа бусад залуучуудад хүний эрхийн боловсрол түгээх бүтээлч төсөл боловсруулсан ба тус аймгийн Залуучууд хөгжлийн төв, сургалтын оролцогчид, ХЭҮК-ын орон нутаг дахь ахлах мэргэжилтэн хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр Дархан-Уул аймаг дахь төрийн байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, налуу замын стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, аймгийн удирдлагуудад хүргэх санал гаргав.

Сургалтын дараа ЗХТ-өөс тус сургалтаас авсан мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан 5 дугаар сард аймгийн ахмадуудад Хүний эрхийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд Комисс арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа

**2.1.13** _Хүний эрхийн төлөө Залуучууд сургалтын гарын авлагад тулгуурласан Хүний эрхийн боловсролын сургалт зохион байгуулах_

Хүний эрхийн төлөө залуучууд сургалтын гарын авлагад тулгуурлан Хүний эрхийн боловсролын сургалтыг АНУ-ын Фор Ди байгууллагын санхүүжилтээр зохион байгуулах бөгөөд тус байгууллагаас санхүүжилт өгөөгүй байгаа тул тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.

**2.1.14** "Хүний эрхийн нээлттэй өдөр" арга хэмжээг сонгогдсон аймгуудад зохион байгуулах хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд Сэлэнгэ, Дархан-Уул аймагт хүний эрхийн нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгууллаа.

Сэлэнгэ аймагт зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд тус аймгийн төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой "Хүний эрхэд суурилсан хандлага" сургалтыг тус аймгийн татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгал, улсын бүртгэл, нийгмийн халамж, үйлчилгээний

асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын алба хаагчдад 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр, аймгийн ЗДТГ, ИТХ, ЕБС, СӨБ-ын байгууллагын алба хаагчдад 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Нутгийн удирдлагын ордны Хурлын танхимд 09:00-13:00 цагт "ХЭҮК-ын танилцуулга", "Хүний эрхэд суурилсан хандлага", "Жендэрийн тэгш байдал ба хүний эрх", "Төрийн үйлчилгээ ба хүний эрх", "Мэдээллийн ил тод байдал ба иргэдийн мэдэх эрх" сэдвээр тус тус зохион байгуулж 62 хүн хамрагдав.

Мөн 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 14:00-18:00 цагт "Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх", "Хүний эрхийн олон улсын гэрээ", "Хүний эрхийн зөрчлийг таних нь", "Төрийн үйлчилгээ ба хүний эрх" сэдвээр Сэлэнгэ аймгийн хууль сахиулах байгууллагын алба хаагчдад сургалт зохион байгуулж, 52 хүн хамрагдав.

Дархан-Уул аймагт "Хүний эрхийн нээлттэй өдөр" арга хэмжээг 4 сарын 27-28-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд удирдамжид заасны дагуу Дархан-Уул аймгийн төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой "Хүний эрхэд суурилсан хандлага" сургалтыг тус аймгийн татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгал, улсын бүртгэл, нийгмийн халамж, үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын алба хаагчдад зохион байгууллаа.

Сургалтыг Дархан-Уул аймгийн Нутгийн удирдлагын ордны Хурлын танхимд 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 09:00-13:00 цагт "ХЭҮК-ын танилцуулга", "Хүний эрхэд суурилсан хандлага", "Жендэрийн тэгш байдал ба хүний эрх", "Төрийн үйлчилгээ ба хүний эрх", "Мэдээллийн ил тод байдал ба иргэдийн мэдэх эрх" сэдвээр зохион байгуулж 33 хүн хамрагдав.

Мөн тус аймгийн ЗДТГ, ИТХ, ЕБС, СӨБ, ЭМГ-ын байгууллагын алба хаагчдад 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 14:00-18:00 цагт "ХЭҮК-ын танилцуулга", "Хүний эрхэд суурилсан хандлага", "Жендэрийн тэгш байдал ба хүний эрх", "Хүүхдийн эрх ба хамгаалал", "Мэдээллийн ил тод байдал ба иргэдийн мэдэх эрх" сэдвээр сургалт зохион байгуулж 39 хүн хамрагдав.

Дархан-Уул аймгийн төрийн тусгай албан хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг бэхжүүлэх зорилготой "Хүний халдашгүй дархан байх эрх" сургалтыг тус аймгийн прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагуудын алба хаагчдад зохион байгуулсан бөгөөд сургалтыг Дархан-Уул аймгийн Дархан сумын Нутгийн удирдлагын ордны Хурлын танхимд 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 09:00-13:00 цагт "ХЭҮК-ын танилцуулга", "Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх", "Жендэрийн тэгш байдал ба хүний эрх", "Хүний эрхийн олон улсын гэрээ", "Хүний эрхийн зөрчлийг таних нь" сэдвээр зохион байгуулж 35хүн хамрагдав.

Нээлттэй өдөр арга хэмжээний удирдамжид заасны дагуу Сэлэнгэ болон Дархан-Уул аймгийн ИТХ-ын тогтоол болон Засаг даргын захирамжаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актад дүн шинжилгээ хийх, аймгийн Цагдан хорих, баривчлах байранд хяналт шалгалт хийх, Алтанбулаг дахь Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж энэхүү арга хэмжээний үр дүнд үндэслэн аймгийн хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг зөвлөн Сэлэнгэ аймгийн ИТХ, Засаг даргад 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 1/11, Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг даргад 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 1/11 тоот зөвлөмжийг, Цагдаагийн Ерөнхий газрын даргад 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 1/08, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 1/09 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн.

Гомдол, хяналт шалгалтын ажилтнууд дараах Хүний эрхийн Нээлттэй өдрийн арга хэмжээг зохион байгуулахад оролцсон байна. Үүнд:

1.2017 оны 4 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ, Дархан-Уул аймагт Хүний эрхийн Нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулсан. Уг ажлын хэсэгт референт Б.Сэмжидмаа, Г.Ууганбаатар нар ажилласан байна. Тэрээр дээрх аймгуудад ажиллахдаа референт Б.Сэмжидмаа хуулийн байгууллагын ажилтнуудад халдашгүй чөлөөтэй байх эрх, Эрүү шүүлтээс ангид байх эрх сэдвээр сургалт хийснээс гадна тус аймгуудын Цагдан хорих байр, эрүүлжүүлэх, саатуулах байранд хяналт шалгалт хийсэн. Мөн референт Г.Ууганбаатар иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх болон тус аймгийн засаг даргын гаргасан захирамж, тушаалд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж тус тус ажилласан.
2.2017 оны 9 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд Комиссын гишүүн П.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг Төв аймагт Хүний эрхийн Нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тус хэлтсийн дарга Т.Ихтамир, ахлах референт Л.Дүгэрсүрэн нар Комиссын даргын баталсан удирдамжид заасны дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

| № | Ажилтан | Гүйцэтгэсэн ажил | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | | Удирдамж боловсруулж, батлуулж, арга хэмжээний бэлтгэл ажил зохион | |

| | | | |
|---|---|---|---|
| 1. | Хэлтсийн дарга Т.Ихтамир | байгуулалтын асуудлыг хариуцан ажиллав. | Арга хэмжээний хүрээнд дүнг нэгтгэн Аймгийн Засаг даргад 2017.10.26-ны өдөр 3/21 дугаартай Комиссын гишүүний Зөвлөмжийг хүргүүлсэн ба Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч 2017.11.30 өдрийн 04/1918 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн байна. |
| | | Удирдлагуудын уулзалт, ИНБ болон олон нийттэй хийх уулзалт, урьдчилсан дүнгийн хуралд оролцов. | |
| | | хуулийн байгууллагын ажилтнуудад “Халдашгүй чөлөөтэй байх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдвээр 1 цаг 20 минутын сургалт хийв. | |
| | | Тус аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын барилга байгууламж, зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй эсэхэд аймгийн ЗДТГ болон ИНБ төлөөлөлтэй хамт мониторинг хийв. | |
| | | Хүний эрхийн Нээлттэй өдөр арга хэмжээний талаар тухай бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, ярилцлага өгөв. | |
| 2. | Ахлах референт Л.Дүгэрсүрэн | Иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх | |
| | | Эрх зүйн актад дүн шинжилгээ хийх | |
| | | Эрүүлжүүлэх саатуулах байр, Цагдан хорих байранд хяналт шалгалт хийсэн. | |

3. 2017 оны 9 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд Комиссын гишүүн П.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Хүний эрхийн Нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тус хэлтсийн дарга Т.Ихтамир, референт Г.Уганбаатар нар Комиссын даргын баталсан удирдамжид заасан ажил үүргийг дараах байдлаар хийж гүйцэтгэлээ. Мөн Дорноговь аймгийн Улаанбадрах суманд тусгай удирдамжийн дагуу ажиллав. Үүнд:

| № | Ажилтан | Гүйцэтгэсэн ажил | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Хэлтсийн дарга Т.Ихтамир | Удирдамж боловсруулж, батлуулж, арга хэмжээний бэлтгэл ажил зохион байгуулалтын асуудлыг хариуцан ажиллав. | Арга хэмжээний хүрээнд дүнг нэгтгэн Аймгийн Засаг даргад 2017.11.14-ны өдөр 3/22 дугаартай Комиссын гишүүний Зөвлөмжийг хүргүүлсэн хариуг ирүүлээгүй байна. |
| | | Удирдлагуудын уулзалт, ИНБ болон олон нийттэй хийх уулзалт, урьдчилсан дүнгийн хуралд оролцов. | |
| | | Хуулийн байгууллагын ажилтнуудад “Халдашгүй чөлөөтэй байх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдвээр 1 цаг 20 минутын сургалт хийв. | |
| | | МХЕГ-ын Замын-Үүд сум дахь Хилийн боомтын хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд тусгай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийв. | |
| 2. | Референт Г.Уганбаатар | Иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөв. | |
| | | Эрх зүйн актад дүн шинжилгээ хийв. | |
| | | Хилийн цэргийн анги дахь саатуулах байрны нөхцөл байдалтай танилцав. | |
| | | Батлагдсан тусгай удирдамжийн дагуу Байгаль орчин, хүрээлэн буй орчны асуудлаар тус сумын байгаль орчин хариуцсан ажилтан болон мэргэжлийн хяналтын байгаль орчин хариуцсан ажилтнуудыг байлцуулан уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулав. | |
| | | Тус сум дахь Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байранд хяналт шалгалт хийв. | |
| | | Дорнод аймгийн Улаанбадрах суманд тусгай удирдамжийн дагуу байгаль орчны асуудлаар эрх бүхий албан тушаалтнуудтай уулзаж, мэдээлэл цуглуулав. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Дорнод аймгийн Улаанбадрах суманд төрийн албан хаагчдад “Төрийн үйлчилгээ ба иргэдийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулав. | |

4. 2017 оны 10 дугаар сарын 03-06-ний өдрүүдэд Комиссын дарга Ж.Бямбадоржоор ахлуулсан ажлын хэсэг Орхон, Булган аймагт Хүний эрхийн Нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд Хэлтсийн дарга Т.Ихтамир, референт Б.Сэмжидмаа нар батлагдсан удирдамжид заасны дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

| № | Ажилтан | Гүйцэтгэсэн ажил | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Хэлтсийн дарга Т.Ихтамир | Удирдамж боловсруулж, батлуулж, арга хэмжээний бэлтгэл ажил зохион байгуулалтын асуудлыг хариуцан ажиллав. | Орхон аймгийн Засаг даргад 2017.10.10 1/19 дугаар, Булган аймгийн Засаг даргад мөн өдрийн 1/20 дугаар Комиссын гишүүний зөвлөмжийг тус тус хүргүүлэв. Хариу ирүүлэх хуулийн хугацаа дуусан. Шаардаж байна. |
| | | Удирдлагуудын уулзалт, ИНБ болон олон нийттэй хийх уулзалт, урьдчилсан дүнгийн хуралд оролцов. | |
| | | Цагдан хорих, эрүүлжүүлэх, саатуулах байранд хяналт шалгалт хийсэн | |
| | | Хорих 437, Хорих 439 дүгээр ангиудад хяналт шалгалт хийсэн. | |
| 2. | Референт Б.Сэмжидмаа | Иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх | |
| | | Эрх зүйн актад дүн шинжилгээ хийх | |
| | | Сургалт зохион байгуулсан | |
| | | Хорих 439 дүгээр ангид хяналт шалгалт хийсэн | |

## 2.2 Хүний эрхийн сурталчилгаа

**2.2.1** *"Хүний эрх" сэтгүүл, "Хүний эрхийн мэдээллийн хуудас"-ыг бэлтгэн хэвлүүлэх, цахим хуудаст байршуулах*

Хүний эрх сэтгүүлийн 2017/1, 2017/2 дугаарыг тус бүрийг 500 хувь хэвлүүлэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглахын зэрэгцээ Комиссын цахим хуудас болон цахим номын санд байршуулсан болно.

Комиссын улирал тутмын Мэдээллийн хуудсын загварыг шинэчлэн, агуулгыг баяжуулж, 2017 оны №01 (50) дугаарыг бэлтгэн “Соёмбо принтинг” ХХК-д 500 хувь хэвлүүлж сурталчилгаанд ашиглаж байна. Мэдээллийн хуудасны 2017 оны №02(51), №03(52) дугааруудыг бэлтгэж цахим хуудаст байршуулаад байна. 2017 оны 4 дүгээр улирлын хуудсыг хэвлүүлэхээр эх бэлтгэлийн шатанд явж байна.

**2.2.2** *"Хүний эрхийн төлөө-сэтгүүлчид" клубыг чадавхжуулах, сургалт, уулзалт зохион байгуулах*

“Хүний эрхийн төлөө-сэтгүүлчид” клубын үйл ажиллагааг 2017 онд Швейцарын хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн дэмжлэгтэйгээр хамтран ажиллаж байна.

Хүний эрхийн төлөө-сэтгүүлчид 2017 онд хүний эрх, байгаль орчны засаглал, тогтвортой бичил уурхай төсөл, уул уурхай дахь хүний эрх зэрэг сэдвээр нийт 391 мэдээ, сурвалжлага, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Швейцарийн Хөгжлийн Агентлагийн хамтын ажиллагааны хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын сэтгүүлчдийг бичил уурхай дахь сайн туршлагатай танилцах аялал-сурвалжлага арга хэмжээг 2017 оны 9 дүгээр сарын 15,16,17,18-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн Баянхонгор, Баян-Овоо, Галуут сумдад зохион байгууллаа. Бичил уурхайн үйл ажиллагаатай танилцах аялалд 15 хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийт 18 сэтгүүлч, Хүний эрхийн Үндэсний Комиссын Баянхонгор аймаг дахь ахлах мэргэжилтэн Б.Содонцэцэг нар оролцлоо. Хөтөлбөрийн дагуу Баянхонгор аймгийн Засаг дарга Г.Батжаргалтай бичил уурхай эрхлэлтийн асуудлаар уулзалт хийж, тус аймагт хэрэгжиж байгаа төслийн явцын мэдээллийг сонсч, Баян-Овоо сум дахь хувиараа ашигт малтмал олборлогчидтой

болон тус суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж, сайн туршлага буюу мөнгөн усгүйгээр олборлолт хийж буй Хонгорын хүдэр баяжуулах цехтэй танилцан, шороон ордын ажиллагаагсурвалжлан, Галуут сум дахь нөхөн сэргээлтийн талбайгаар явж, “Батсайхан сэтгэл” ТББ-ын үйл ажиллагаатай танилцан мэдээ сурвалжлага бэлтгэн гаргаад байна.

Клубын гишүүд 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүүхдийн асрах төв буюу "Өнөр бүл” төвийн үйл ажиллагаатай танилцан хүүхдийн эрхийн тулгамдсан асуудлыг илүү мэдэрч ойлгохыг зорьж, гишүүд болох Эх сурвалж мэдээллийн агентлаг, С1 телевиз, ETV, NTV телевиз, "Зууны мэдээ”, "Өнөөдөр” сонин, www.news.mn, www.time.mn зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл хагас өдөр ажиллаж, төрийн асрамж хамгаалалд буй хүүхдүүдийн аж амьдралтай танилцаж, 10 орчим сурвалжлага, мэдээ бэлтгэлээ.

Клубын гишүүдийн бүтээлийг “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” фэйсбүүк хуудас нээж архивлаж эхэлсэн бөгөөд 2011 оноос хойшхи бүх бүтээлийг хуулж оруулж, цэгцэлж, мөн олон нийтэд хүргэж эхлээд байна.

*Сэтгүүлчдийн клубын уулзалт зохион байгуулсан байдал:*

| д/д | Уулзалтын сэдэв | Уулзалтын зочин | Огноо, уулзалт болсон газар |
|---|---|---|---|
| 1. | ХЭҮК, сэтгүүлчдийн хамтын ажиллагаа | ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж | 2017.02.07, ХЭҮК-ын 514 тоот өрөөнд |
| | “Хүний эрхийн төлөө-сэтгүүлчид” клубын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө | ХЭҮК-ын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл | |
| | ШХА-ын “Тогтвортой бичил уурхай” төслийн болон Монголын бичил уурхайн мэдлэгийн төвийн танилцуулга | ТБУТ-ын мэргэжилтэн Ц. Тансагмаа | |
| | Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээ, шударга олборлолтын стандартын тухай | ТБУТ-ийн мэргэжилтэн Ө.Батсайхан | |
| | Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны танилцуулга | МБУНДХ-ны гүйцэтгэх захирал Д.Баярмаа | |
| 2. | Бичил уурхайн хууль эрх зүйн асуудал | Ашигт малтмал, газрын тосны газрын ахлах мэргэжилтэн С.Баттулга | 2017.03.17, Төрийн албаны зөвлөлийн шалгалтын танхимд |
| | Бичил уурхай дахь хууль эрхзүйн асуудлууд | МБУНДХ-ны гүйцэтгэх захирал Д.Баярмаа | |
| | Бичил уурхай дахь аюулгүй ажиллагаа | Уул уурхайн аврах ангийн ажилтан Бадамцэцэг | |
| 3. | Татварын тухай ойлголт, ач холбогдол, (Хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар) | Татварын Ерөнхий Газрын УТОХГ-ын эрдэс баялаг,олон улсын татварын хэлтсийн дарга Д.Баяраа | 2017.05.05, ХЭҮК-ын 514 тоот өрөөнд |
| | Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээнд Монгол банкны оролцоо | Монголбанкны Зах зээлийн газрын ахлах мэргэжилтэн Д. Алтансүх | |
| | Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээнд ҮМСХГ-ын оролцоо | Үнэт металлын Сорьцын хяналтын газрын дарга Б.Бэхбат | |
| 4. | Хүний эрхийг хамгаалагчдын эрх-Монгол Улсад тулгамдсан асуудлууд<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгаа, УИХ-д хүргүүлсэн санал<br>Тохиолдол, жишээ кэйс | Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах референт Х.Мөнхзул<br>Монголын Эмнести Интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал, ХЭҮК-ын ОТБЗ-ийн гишүүн | 2017.08.28 Монголын Эмнести Интернэшнл байгууллагын Уулзалтын |

| | | | |
|---|---|---|---|
| | | Б.Алтантуяа | танхимд |
| 5. | Байгаль орчны нөхөн сэргээлт<br>Бичил уурхайчдын эрх зүйн орчин<br>Баянхонгор аймагт томилолтоор ажиллах тухай | Швейцарийн Хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн эксперт Ц.Тансагмаа<br>Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбооны төлөөлөл<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл | 2017.09.12<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын сургалтын 514 тоот танхимд |
| 6. | Хүний эрхийн асуудалд хэвлэл мэдээллийн оролцоо, нөлөөлөл<br><br>Бичил уурхайн асуудлууд<br>Хүний эрхэд суурилсан хандлага - сургалт | Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж<br>Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбооны тэргүүн Д.Наранцогт<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Г.Золзаяа | 2017.10.10<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын сургалтын 514 тоот танхимд |
| 7. | Хүний эрхийн олон улсын өдрийг Монгол Улсад тэмдэглэн өнгөрүүлэх кампанит ажлын төлөвлөгөө<br>Бичил уурхайн өнөөгийн байдал<br>Иргэдийн мэдэх эрх ба хэвлэл мэдээлэл - сургалт | Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл<br>Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбооны мэргэжилтэн Д.Түмэндэмбэрэл<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын референт З.Бадмаараг | 2017.11.17<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын сургалтын 514 тоот танхимд |

**2.2.3** *"Нээлттэй сургууль" сонинд хүний эрхийн булан ажиллуулах*

"Нээлттэй сургууль" сонины Хүний эрх буланд 2017 онд нийтлүүлэх мэдээллийн хуваарийг гарган Ажлын албаны даргаар батлуулж, тус сонины эрхлэгч А.Бүрэнжаргалд хүргүүлж батлагдсан сэдвийн хүрээнд мэдээллийг цаг тухайд нь бэлтгэн хүргүүлж байна.

| д/д | Сэдэв | | Хэвлэгдсэн дугаар |
|---|---|---|---|
| 1. | "Амьд явах эрх" | | 2017 оны 1 дүгээр сар №01 (190) |
| 2. | Хүний эрхийн боловсролын онол, зарчмууд | Хүний эрхийн боловсролын онол, арга зүйн хүрээ | 2017 оны 2 дугаар сар №02 (191) |
| | | Хүний эрхийн боловсролын хандлага | 2017 оны 3 дугаар сар №04 (192) |
| 3. | Хүний эрхийн боловсролын хандлага | Олон талт арга, хандлагын онолын хүрээ | 2017 оны 4 дүгээр сар №04 (193) |
| 4. | | Хүний эрхийн боловсролын төлөвлөлт ба загвар | |
| 5. | Хүний эрхийн боловсрол-Практикт | Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаар зохион байгуулах | 2017 оны 5, 6 дугаар сар № 05, 06 (194, 195) |
| 6. | | Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаар хэрхэн зохион байгуулах, шалгуур үзүүлэлтийг боловсруулах | 2017 оны 8 дугаар сар № 07, 08 (195,196) |
| 7. | | | |
| 8. | Хүний эрхийн боловсролыг хэрхэн үнэлэх, үр дүнг тайлагнах | Хүний эрхийн боловсролын үнэлгээ<br>Сургалтын үр дүнг тайлагнах<br>Жишээ, кэйстэй ажиллах | 2017 оны 9 дүгээр сар № 09, 10 (197, 198) |
| 9. | Хүний эрхийн | Хүний эрхийн боловсрол ба сурч | 2017 оны 11 дүгээр сар |

| | | | |
|---|---|---|---|
| | боловсрол Ерөнхий боловсролын сургуулиудад | боловсрох эрх<br>Сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол<br>Хүний эрхийн боловсролд ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх үүрэг | № 11, 12 (199, 200) |
| 10. | Хүний эрхийн боловсрол Ерөнхий боловсролын сургуульд | Хүний эрхийн сургалт явуулах аргачлал<br>Хүний эрхийн сургалтын үр дүнг хэрхэн үнэлэх вэ? | 2017 оны 12 дугаар сар<br>№ 13, 14 (201, 202) |

**2.2.4 Олон улын хүний эрхийн өдрийн арга хэмжээ зохион байгуулах.**

Хүний эрхийн олон улсын өдрийн хэмжээнд зохион байгуулах ажлын тусгай төлөвлөгөөг боловсруулж, нийт 24 арга хэмжээг хийхээр төлөвлөсний дагуу сургалт сурталчилгааны ажлуудыг хийж байна.

Төлөвлөгөөнд заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс нь Хууль сахиулахын их сургуультай хамтран 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 16.00-18.00 цагийн хооронд тус сургуулийн байранд 2 болон 3 дугаар дамжааны 75 оюутны дунд хөгжөөнт, танин мэдэхүйн АХА нэвтрүүлгийг зохион байгуулав.

Тус өдөрт зориулсан тусгай цахим бичил хуудсыг бүтээж, НҮБ-ын ХЭДКГ-ын илгээлт, болон хуудсыг холбуулж, мэдээллийг нэгтгэн ажиллуулж эхлэв. Тус өдөрт зориулсан 13 албан ёсны үйл ажиллагааг 12 телевиз, 6 сонин, 8 мэдээллийн агентлаг давхардсан тоогоор нийт 57 удаа, хүний эрхийн олон улсын өдөрт зориулсан хэвлэлийн бага хурлыг UBS, SBN,TB9, C1, TM, NTV, MNC зэрэг 11 телевиз, Өдрийн сонин, Зууны мэдээ, Үндэсний шуудан, Засгийн газрын мэдээ зэрэг 7 сонин, gogo.mn, info.mn, eagle.mn, news.mn зэрэг 10 мэдээллийн сайт, МОНЦАМЭ мэдээллийн агентлаг, МҮОНР, Гэр бүлийн радио 104,5 2 радио, нийт 31 хэвлэл мэдээллийн хэрэгсэл ирж сурвалжиллаа. Уг ажлын хүрээнд тусгай хуваарийн дагуу ХЭҮК-ын дарга, гишүүд, Ажлын албаны ажилтнууд МҮОНТВ, TB9, SBN, UBS, ETV, C1 зэрэг телевиз, МҮОНР-ийн Хурд агентлаг, Гэр бүлийн радио 104,5, Эх сурвалж агентлаг, Өдрийн сонин, “Зууны мэдээ” зэрэг сонинд нийт 18 удаа зочноор уригдан хүний эрхийн асуудлаар ярилцлага, мэдээлэл өгсөн байна.

Хүний эрхийн олон улсын өдрийн хүрээнд МҮОНРТ-ээр “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах нь”, “Хүний эрх гэж юу вэ?”, “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”, “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс”, “Хүний эрхийн төлөө тэмцэгчийн үлгэр” зэрэг баримтат кино, хүүхэлдэйн кино, шторкуудыг олон нийтэд хүргэв. “Хүний эрхийн хамгаалагчийн нэг өдөр” сурвалжлагыг “Зууны мэдээ” сонин, МҮОНТВ-ийн “Өглөө” хөтөлбөртэй хамтран бэлтгэж, олон нийтэд хүргэлээ. Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын уриалга мэндчилгээг “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ” сонинд, info.mn сайтад нийтлүүллээ. Тус өдөрт зориулан 10 хэвлэлийн мэдээ, тусгай мэдээллийг бэлтгэн албан ёсны цахим хуудастаа болон олон нийтийн сүлжээ, фэйсбүүк хуудаст байршуулан нийтлэв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Хүний эрхийн олон улсын өдрийг угтан Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Монголын Хуульчдын Холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбоотой хамтран 2017 оны 12 дугаар сарын 5, 6, 7, 8-ны өдрүүдэд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Мишээл, Дүнжингарав, Оргил салбаруудад “Иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг тус өдөрлөгийн хөтөлбөрийн дагуу:

- 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр НҮНТ-ийн Дүнжингарав салбарт /Өдөрлөгийн эхний өдөр нийт **59** иргэнд **1370** минут буюу **22** цаг **50** минутын хууль зүйн зөвлөгөө өгсөн байна/
- 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр НҮНТ-ийн Мишээл салбарт / Өдөрлөгийн хоёр дахь өдөр нийт **61** иргэнд **1257** минут буюу **20** цаг **57** минутын хууль зүйн зөвлөгөө өгсөн байна/
- 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр НҮНТ-ийн Драгон салбарт / Өдөрлөгийн гурав дахь өдөр нийт **64** иргэнд **1176** минут буюу **19** цаг **36** минутын хууль зүйн зөвлөгөө өгсөн байна./
- 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр НҮНТ-ийн Оргил салбарт / Өдөрлөгийн дөрөв дэх өдөр нийт **40** иргэнд **818** минут буюу **13** цаг **38** минутын хууль зүйн зөвлөгөө өгчээ./

Уг арга хэмжээний хүрээнд нийслэлд нийт **224** иргэнд **4621** минут буюу **77** цаг **1** минутын хууль зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

Мөн Комиссын орон нутаг дахь ажилтнууд аймгийн Засаг даргын тамгын газар, хуулийн байгууллага, өмгөөллийн байгууллагуудтай хамтран уг арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулав. Өвөрхангай, Хөвсгөл аймгууд мэдээллээ өгөөгүй хугацаандаа мэдээллээ ирүүлээгүй байна. Хууль зүйн зөвлөгөөний мэдээллийг хүснэгтэд оруулав.

| **№** | **Аймгийн нэрс** | **Орон нутаг дахь ахлах мэргэжилтний нэрс** | **Зөвлөгөө өгсөн хүний тоо** | **Хугацаа** |
|---|---|---|---|---|
| 43. | Архангай | С.Мөнгөнзаяа | 79 | - |
| 44. | Баян-Өлгий | Л.Уранчимэг | 18 | |
| 45. | Баянхонгор | Б.Содонцэцэг | 67 | |
| 46. | Булган | Д.Мөнхсайхан | 17 | 225 минут |
| 47. | Говь-Алтай | Б.Ариунжаргал | 15 | 15 минут |
| 48. | Говьсүмбэр | Б.Наранбаатар | 33 | |
| 49. | Дархан-Уул | Ц.Долгорсүрэн | 25 | |
| 50. | Дорнод | Д.Дугарсүрэн | 2 | |
| 51. | Дорноговь | Ч.Нандин-Эрдэнэ | 30 | |
| 52. | Дундговь | Т.Баярцэцэг | 25 | 245 минут |
| 53. | Завхан | Ч.Наранхүү | 2 | 13 минут |
| 54. | Орхон | Ё.Эрдэнэболд | 68 | 680 минут |
| 55. | Өвөрхангай | Отгонжаргал | **өгөөгүй** | |
| 56. | Өмнөговь | Г.Нарангоо | 12 | |
| 57. | Сүхбаатар | Х.Наранцэцэг | 14 | 217 минут |
| 58. | Сэлэнгэ | Д.Гантулга | 13 | |
| 59. | Төв | У Чойжилсүрэн | 11 | |
| 60. | Увс | Я.Хонгорзул | 24 | |
| 61. | Хөвсгөл | М.Тунгалагмөрөн | **өгөөгүй** | |
| 62. | Хэнтий | Д.Эрдэнэбаясгалан | 11 | |
| 63. | Ховд | Г.Солонго | 13 | |
| | | **Нийт** | **484** | **1382 минут** |

Жич: Комиссын зарим орон нутаг дахь ажилтнууд хууль зүйн зөвлөгөө өгсөн хугацаагаа ирүүлээгүй тул ирүүлсэн мэдээллээр нэгтгэн гаргав.

**2.2.5** Хүний эрхийн талаарх ном товхимол, гарын авлага хэвлүүлэх, түгээх хүрээнд 13 төрлийн ном товхимол, сурталчилгааны материалыг боловсруулан 23500 хувь хэвлүүлж, сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглаж байна. Үүнд

| **Д/Д** | **Хэвлүүлсэн материалын нэр** | **Тоо** | **Санхүүжилт** |
|---|---|---|---|
| 1. | Комиссын танилцуулга | 1000 | ХЭҮК |
| 2. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл | 1500 | ХЭҮК |
| 3. | Мэдээллийн хуудас 2017/1 №(50) | 500 | ХЭҮК |
| 4. | Жендэр ба хүний эрх | 500 | ШХА |
| 5. | Хүний эрхэд суурилсан хандлага | 500 | ШХА |
| 6. | “Хүний эрх” сургалтын дэвтэр | 500 | ХЭҮК |
| 7. | Хүний эрх сэтгүүл 2017/2 | 500 | ХЭҮК |
| 8 | Хүний эрхийн 13 төрлийн брошур | 13*2500=15700 | ШХА |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Хууль сахиулагч ба Хүний эрх сургалтын гарын авлага-3 | 300 | ЦЕГ-ын сургалтын төв |
| 10 | Хүүхдийн эрх ба хамгаалал судалгааны тайлан | 500 | Гууд Нейборс ОУБ |
| 11 | Хорих байгууллага ба хүний эрх сургалтын гарын авлага-4 | 300 | ШШГЕГ- |
| 12 | Орон нутгийн шийдвэр гаргах түвшин дэх иргэдийг оролцоо –сургалтын гарын авлага-5 | 1000 | ШХА |
| 13 | Жижиг дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар | 700 | ОУХБ |
| 14 | Гомдол хянан шалгах процесс | 22 | 3 төрлийн хөлтэй сурталчилгааны самбарыг 21 аймаг бүрт |
| 15 | Хүн бүрт | 22 | |
| 16 | ХЭҮК-ын танилцуулга | 22 | |
| 17 | ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтны хаяг | 21 | |
| 18 | Сургалтын дэвтэр | 4800 | |

Мөн Хүний эрхийн олон улсын өдрийг тэмдэглэх аянт ажлын хүрээнд Комиссын даргын мэндчилгээний үгийг боловсруулж, мөн НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссараас Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан илгээсэн видео болон мэдэгдэл бүхий нийт 5 хуудас материалыг орчуулж, Комиссын цахим хуудаст байршуулахаар ХЭБС-ны хэлтэст хүргүүлэв.

Монголын Эмнести Интернейшнл, Хуульчдын Холбоо, МУИС-ын ХЗС-тай хамтран “Монгол Улсын Хүний эрхийн Боловсрол: Өнгөрсөн, Одоо, Ирээдүйд" сэдэвт онол практикийн бага хурал зохион байгуулав.

**2.2.6 Ном хэвлэл түгээсэн талаар сар тутам тайлагнах**

2017 оны эхний хагас жилийн байдлаар Хүний эрхийн нээлттэй өдөр, Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн хүрээнд орон нутагт зохион байгуулсан “Хүний эрхэд суурилсан хандлага-Төр-иргэний харилцаа” сургалт, “Хот дахин төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх” онол практикийн бага хурал болон "Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах нь" хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээ болон орон нутгийн ажилтнуудын сургалт, сурталчигааны үйл ажиллагаанд зориулан хүний эрхийн талаарх ном, товхимол, гарын авлага зэрэг **57 төрлийн 8306 ширхэг** ном товхимол тарааж бүртгэл хийсэн байна.

2.2.7 Хүний эрхийн Цахим номын санд 2017 онд **6786** хандалт хийгдсэн байна. Цахим номын сан нээгдсэнээс хойш нийт **1296** хэрэглэгчтэй болсоноос энэ жилийн байдлаар **848** хэрэглэгч шинээр нэмэгдсэн байна.

Цахим номын сан нээгдсэнээс хойш хамгийн их хандалттай номууд нь:

- Compulsory military service and conscript labour in Mongolia: Review of policy and practice - **2081**
- Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар Төрийн бус байгууллагуудаас 2012-2015 онд хийсэн судалгаа, мониторингийн тайлангууд -**1498**
- Олон улсын хүний эрхийн билл Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл (2015) - **1480**
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл – **1404**
- Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал (2013) – **1455**
- Хүний эрхийн цуврал нийтлэл (2012) - **1009**
- Хүний эрх сэтгүүл 2016/1 - **1124**
- Хүний эрх улирал тутмын сэтгүүл 2016/1 - **782**
- Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах хүний эрхийн төлөв байдлын судалгаа - **1129**
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл – **646**
- Хүний эрх сэтгүүл 2017/1 -786

- ❖ Хүний эрх сэтгүүл 2017/2 -12

Комиссын сургалт сурталчилгаанд ашиглах тараах материал хүлээж авсан байдал.

- ✓ Гүүд нэйборс ТББ-с хүүхдийн эрхийн сургалтад ашиглах “Хүүхдийн эрхийн тухай цуврал нэвтрүүлэг”-ийн DVD -200 ширхэг
- ✓ Комиссын танилцуулга – 1000 ширхэг /Хөх судар принтинг ХХК/
- ✓ Жендэр ба хүний эрх – 500 ширхэг /Мөнхийн үсэг ХХК/
- ✓ Хүний эрхэд суурилсан хандлага – 500 ширхэг /Мөнхийн үсэг ХХК/
- ✓ Мэдээллийн хуудас 2017/1 №(50) - 500 ширхэг /Соёмбо принтинг ХХК/
- ✓ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэл-1500 ширхэг / Соёмбо принтинг ХХК/
- ✓ Комиссын “Хүн бүр” дэвтэр – 4800 ширхэг / Соёмбо принтинг ХХК/
- ✓ Хүний эрхийн улирал тутмын сэтгүүл 2017/1 – 500 ширхэг /Хөх судар принт ХХК/
- ✓ Хүний эрхийн улирал тутмын сэтгүүл 2017/2 -500 ширхэг /Хөх судар принт ХХК/
- ✓ 13 төрлийн брошур нийт – 15700 ширхэг / Соёмбо принтинг ХХК/
- ✓ Гүүд нэйборс ТББ-с Хүүхдийн эрх ба хамгаалал судалгаа 200 ширхэг
- ✓ Швейцарын хөгжлийн агентлагаас Бичил уурхай дахь зөрчил, маргаан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх арга зам – 1500 ширхэг
- ✓ “Жижиг, дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгэээ ноос ноолуурын салбар” судалгаа – 700ш / Содпресс ХХК/
- ✓ Орон нутаг дахь шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо гарын авлага -1000 ширхэг / Соёмбо принтинг ХХК/

Комиссын тараах материалыг нээлттэй өдрийн хүрээнд Сэлэнгэ, Дархан Төв, Дорноговь, Орхон, Булган аймгуудад мөн 5,6 дугаар сарын төлөвлөгөөний дагуу Швейцарын хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн хүрээнд Хэнтий, Архангай, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудад хийсэн сургалт сурталчилгаанд, 10-р сард НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Өмнөговь аймагт зохион байгуулах “Байгаль орчны засаглал ба хариуцлагатай уул уурхай” туршлага судлахад, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хүний эрхийн Олон улсын өдрийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнүүд гэх мэтчилэн бусад байдлаар тараасан.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэлийг Улсын Их Хурлын 76 гишүүд, яам, агентлаг, нийслэлийн 9 дүүргийн тамгын газар, 21 аймгийн засаг дарга, номын сангууд, хууль зүйн их дээд сургуулиуд, иргэний нийгмийн байгууллагууд, орон тооны бус зөвлөлийн гишүүд, комиссын орон нутгийн ажилтнуудад тус тус хүргүүлсэн.

2017 оны байдлаар нийт 27509 ширхэг ном товхимол тараасан байна.

2017 онд Мэдээлэл лавлагааны төвөөс нийт 641 ном уншилгад гарсан байна. Мэдээлэл лавлагааны төвийн номын сангийн номыг LIB4U нэгдсэн програмд бүртгэхээр Волвес ХХК-тай 6 дугаар сарын 16-ны өдрөөс гэрээ байгуулан ажиллаж номын сангийн номын фондыг бүрэн цахим бүртгэлийн системд шилжүүлэв.

**2.2.8** *Комиссын цахим хуудас, олон нийтийн сүлжээ, сурталчилгааны самбаруудыг тогтмол баяжуулан монгол, англи хэл дээр хөтлөх, хэвийн үйл ажиллагааг хангах*

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээлэх, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссоос явуулж буй бүхий л үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг англи, монгол хэлээр, бичвэр, гэрэл зураг, дүрсээр цаг тухай бүрт цахим хуудастаа болон олон нийтийн сүлжээ фэйсбүүк хуудастаа байршуулан мэдээлэхээс гадна төвийн болон орон нутаг дахь салбаруудын мэдээллийн самбарыг 7 хоног бүрт шинэчлэн баяжуулж ажиллаж ирсэн болно. Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлаад зогсохгүй, хүний эрхийн боловсрол олгох ажлын хүрээнд хүний эрхийн сэдэвчилсэн мэдээллийн баазыг бий болгон цахим хэлбэрт шилжүүлэн олон нийтэд нээлттэй хүргэх, хүний эрхийн цахим номын санг, хайлтын системтэй нь шинэчилж, цахим номын санг ашиглахад илүү хялбар болгохыг зорьж ажиллалаа.

*ХЭҮК-ын цахим хуудас болон фэйсбүүк хуудаст 2017 онд оруулсан мэдээллийг хураангуйлан хүснэгтээр харуулбал:*

| Сар тутам | Хэвлэлийн мэдээ | Зургийн цомог | Дүрстэй мэдээ | Англи хэлээр | Мэдээллийн самбар шинэчлэл (төв оффист, давтамж) | Орон нутгийн мэдээ |
|---|---|---|---|---|---|---|
| I сар | 11 | 1 | 2 | 6 | 2 | 59 |
| II сар | 10 | 3 | 6 | - | 3 | 58 |
| III сар | 11 | 2 | - | 3 | 3 | 49 |
| IV сар | 8 | 2 | - | 3 | | 60 |
| V сар | 15 | 2 | 3 | 4 | 2 | 62 |
| VI сар | 10 | 2 | 2 | 5 | 1 | 40 |
| VII сар | 9 | 3 | 3 | - | 2 | 7 |
| VIII сар | 4 | 10 | 2 | - | 4 | 4 |
| IX сар | 23 | 35 | 4 | 1 | 10 | 47 |
| X сар | 21 | 46 | 2 | 2 | 10 | 63 |
| XI сар | 45 | 30 | 2 | 2 | 9 | 123 |
| XII сар | 28 | 50 | 3 | 6 | 6 | 113 |
| **Нийт** | **195** | **186** | **29** | **27** | **52** | 685 |

*Комиссын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулсан мэдээ, материал иргэдэд хэрхэн хүрч байгааг 2017 оны байдлаар харуулбал:*

| | **www.mn-nhrc.org** | **www.facebook.com/nhrcm** |
|---|---|---|
| I сар | 9081 | 28238 |
| II сар | 9495 | 24219 |
| III сар | 6306 | 26659 |
| IV сар | 5724 | 15497 |
| V сар | 1787 | 12097 |
| VI сар | 852 | 14176 |
| VII сар | 3513 | 15724 |
| VIII сар | 67 | 14178 |
| IX сар | 8191 | 35366 |
| X сар | 3043 | 68104 |
| XI сар | 4113 | 40599 |
| XII сар | 3123 | 33283 |
| **Нийт** | **33245** | **328140** |

*Комиссын орон нутгийн ажилтнууд өөрсдийн хариуцсан буландаа мэдээ оруулж буй байдлыг харуулбал:*

| Аймаг | I сар | II сар | III сар | IV сар | V сар | VI сар | VII сар | VIII сар | IX сар | X сар | XI сар | XII сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дорнод | **2** | **2** | **-** | **2** | **2** | **-** | **-** | **-** | **2** | **5** | **7** | **4** |
| Сүхбаатар | **4** | **1** | **3** | **-** | **3** | **1** | **-** | **-** | **1** | **3** | **3** | **3** |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэнтий | 4 | 2 | 2 | 3 | 4 | 3 | 1 | - | 2 | 3 | 8 | 4 |
| Дорноговь | 7 | 11 | 5 | 1 | 3 | 3 | - | 1 | 3 | 9 | 5 | 5 |
| Дундговь | 3 | 2 | 3 | 1 | 3 | 1 | - | - | 4 | 3 | 6 | 3 |
| Өмнөговь | - | 1 | - | 3 | 3 | 2 | - | - | - | 11 | 5 | 8 |
| Булган | 7 | 7 | 2 | 7 | 4 | 3 | - | - | - | 8 | 8 | 6 |
| Архангай | - | - | 1 | - | - | 4 | - | - | - | 7 | 9 | 5 |
| Өвөрхангай | 1 | 1 | - | - | - | - | - | - | 10 | 3 | 2 | 2 |
| Хөвсгөл | 4 | 1 | 6 | 7 | 7 | - | 5 | - | - | 10 | - | 7 |
| Сэлэнгэ | 3 | 3 | 3 | 8 | 5 | 4 | - | - | - | 3 | 5 | 4 |
| Төв | 1 | 3 | 2 | 1 | 2 | 1 | 1 | - | 5 | 2 | 2 | 4 |
| Завхан | 1 | - | 5 | 2 | - | 2 | - | - | - | 3 | 3 | 2 |
| Увс | 4 | 2 | 3 | 3 | 9 | - | - | 3 | 2 | 5 | 8 | 7 |
| Ховд | 4 | 5 | 5 | 6 | - | 6 | - | - | 8 | 5 | 18 | 11 |
| Говь-Алтай | 7 | 4 | 2 | - | 5 | 3 | - | - | 5 | 3 | 5 | 11 |
| Баянхонгор | 3 | 7 | 7 | 6 | 4 | 4 | - | - | 3 | 4 | 8 | 10 |
| Баян-Өлгий | 2 | 2 | - | 2 | 2 | - | - | - | - | 4 | 4 | 1 |
| Говьсүмбэр | 1 | 3 | 1 | 3 | 2 | 2 | - | - | - | 4 | 6 | 8 |
| Орхон | 1 | 1 | - | - | 2 | - | - | - | - | 4 | 2 | 2 |
| Дархан-Уул | - | - | - | 5 | 3 | 1 | - | - | 2 | 6 | 9 | 4 |
| **Нийт** | **59** | **58** | **49** | **60** | **62** | **40** | **7** | **4** | **47** | **63** | **123** | **113** |

*Хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, Комиссын үйл ажиллагааг таниулах чиглэлээр үндэсний, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах, мэдээлэл харилцааг тогтмол зохион байгуулах*

Хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, Комиссын үйл ажиллагааг таниулах чиглэлээр үндэсний, орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдтэй хамтарч ажиллах, мэдээлэл харилцааг тогтмол зохион байгуулах хүрээнд Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны дарга, хэлтсийн дарга нар болон референтүүд хүний эрхийн тулгамдаж буй асуудал, цаг үеийн асуудал, комиссын үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлуудаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, тодруулга, мэдээллийн бүртгэлийг 2017 оны байдлаар харуулав.

| | Телевиз | Радио | Сонин | Сайт |
|---|---|---|---|---|
| I сар | 10 | 1 | 4 | 1 |
| II сар | 3 | - | - | - |
| III сар | 32 | 4 | 3 | 2 |
| IV сар | 8 | 1 | 3 | 3 |
| V сар | 15 | 4 | 3 | 1 |
| VI сар | 2 | 1 | - | - |
| VII сар | 1 | 1 | - | 1 |
| VIII сар | 19 | 4 | 2 | 7 |
| IX сар | 25 | 9 | 6 | 4 |
| X сар | 27 | 12 | 7 | 5 |
| XI сар | 28 | 19 | 5 | 6 |
| XII сар | 32 | 20 | 6 | 8 |
| **Нийт** | **112** | **76** | **39** | **38** |

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу ил тод, нээлттэй үйл ажиллагааг явуулж, 2017 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны ажилтнууд хүний эрхийн асуудлаар телевизэд 112 удаа, радиод 76 удаа,

сонинд 39 удаа, мэдээллийн цахим хуудаст 38 удаа тус тус ярилцлага, тодруулга мэдээлэл өгч хамтран ажиллалаа.

Тогтмол харилцдаг хэвлэл мэдээллийн байгууллагатай болсон бөгөөд МҮОНТВ, С1, UBS, ТВ9, ETV, SBN зэрэг 16 телевиз, Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Үндэсний шуудан зэрэг өдөр тутмын 6 сонин, МОНЦАМЭ, Эх сурвалж мэдээллийн агентлаг, МҮОНР, Гэр бүлийн радио 104.5 2 радио, gogo.mn, news.mn, info.mn, top.mn, dorgio.mn зэрэг 18 мэдээллийн агентлаг нийт 42 хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байнга хамтран ажиллаж ирлээ.

*2017 онд Мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил:*

- 2001-2010 оны нийт 1871 гомдлын архивын материалыг шүүж гомдлын бүртгэл, мэдээллийг боловсруулсан.
- 2001-2010 оны Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байгууллага, албан тушаалтан, огноо, ямар асуудлаар хүргүүлсэн болох, хариу ирсэн эсэх, хугацаа хэтэрсэн эсэх зэрэг ангилалаар мэдээ боловсруулсан.
- 2001-2017 оны хооронд Комисс дангаараа болон бусад байгууллагатай хамтарч хийсэн судалгааны мэдээг гаргасан.
- 2001-2017 оны хооронд Комиссоос хийсэн хяналт шалгалтын мэдээг боловсруулсан.
- 2012-2017 оны хооронд эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн хүрээнд Комиссын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээг боловсруулсан.
- 2012-2017 оны хооронд сурч боловсрох эрхийн хүрээнд Комиссын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээг боловсруулсан болно.
- Комиссын дарга гишүүдийн хурал чуулганд хэлсэн үг, тавьсан илтгэлийн товъёог гаргаж, материалыг файл хэлбэрээр хадгалав.
- 2001-2017 оны хооронд Комиссоос зохион байгуулсан Хүний эрхийн нээлттэй өдөр арга хэмжээний талаарх мэдээг боловсруулав.

Комиссын цаг үеийн шинжтэй мэдээний Англи хэл дээрх орчуулгыг ЗХАХ-ийн дарга, Ө.Ундрах, референт Т.Ариунаа, түр орлон гүйцэтгэгч ажилтан Г.Түвшинжаргал нар тогтмол хийж, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтанд шилжүүлж ажиллав.

*НЭМЭЛТ АЖИЛ*
*“Хот дахин төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх” сэдэвт онол практикийн бага хурал*

2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “Хот дахин төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх” сэдэвт онол практикийн бага хурлыг төр болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил, эрдэмтэн, багш, судлаачид, дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэдийг оролцуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Эмнести Интернэшнл, Монголын Хуульчдын Холбоо, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран Гадаад Харилцааны Яамны “Зөвшилцөл” танхимд 130 оролцогчтой зохион байгууллаа.

Эрдэмтэн судлаач, хуульч, нөлөөлөлд өртсөн иргэдийн тавьсан “Хот суурин газрын төлөвлөлт ба иргэдийн оролцоо”, “Шударга нөхөн олговор”, “Хот суурин газрыг төлөвлөхтэй холбоотой үүссэн маргааныг шийдвэрлэх хүний эрхэд суурилсан механизм”, нүүлгэн шилжүүлэх, түр суурьшуулахтай холбоотой арга зам, “Хот суурин газрын дахин төлөвлөлтийн хэрэгжилт, зохион байгуулалтанд гарч буй алдаа, даван туулах арга зам”, “Эрх зүйн зохицуулалт хоорондын уялдаа, түүнийг сайжруулах нь сэдвээр илтгэл тавилаа.

Энэхүү онол практикийн бага хурлыг бэлтгэл ажил, техник зохион байгуулалтын үйл ажиллагааг Комисс хамтрагч талуудтай хэрэгжүүллээ. ГХЯ-ны зөвшилцөл танхимд зохион байгуулах талаар түрээсийн төлбөрөөс чөлөөлөх асуудлаар Комиссоос албан бичиг явуулсан нь дэмжигдсэн болно. Мөн төрийн байгууллагаас оролцох байгууллагуудын хүрээг тодорхойлж, нийт 45 оролцогчийг Комиссоос бүрдүүлж оролцуулав. Хэвлэл мэдээллийн сурталчилгаа, хэвлэлийн мэдээг бэлтгэж ажилласны үр дүнд нийт 10 орчим хэвлэл мэдээллийг байгууллага ирж сурвалжлага хийсэн болно.

Онол практикийн бага хуралд Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, НЗДТГ, нийслэл, дүүргийн газрын албад, дахин төлөвлөлтийн ажлыг гардан хэрэгжүүлж буй компаниуд, иргэний нийгэм, дахин төлөвлөлтөд хамрагдаж газраа чөлөөлсөн иргэдийн төлөөлөл оролцож, дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, талуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцов. Тус онол практикийн хурлын үеэр Нийслэлийн төр захиргааны байгууллагаас 65 айлын түрээсийн байрны асуудлыг шийдвэрлэхээр болсон зэрэг үр дүн гарсан байна.

Онол практикийн бага хуралд хэлэлцүүлсэн эрдэмтэн, багш судлаач, хуульчдын илтгэлээс дэвшүүлсэн санал дүгнэлт, хуралд оролцогчдын хэлэлцүүлгээс гаргасан саналыг үндэслэн Улсын Их Хурал, Засгийн газар болон Барилга, хот байгуулалтын яам, Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагууд, дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэд, газраа чөлөөлсөн иргэд, иргэдийн төлөөллийн байгууллагуудад хандаж 38 санал зөвлөмжийг гаргасан байна. Мөн илтгэгчдийн илтгэлийг товхимол болгон хэвлүүлж, нийтийн хүртээл болгов.

*“Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах нь” сэдэвт зөвлөлдөх уулзалт*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос санаачлан хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг угтан “Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд төр болон олон улсын байгууллага, хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага эвсэл холбоодын 60 оролцогчтой зохион байгууллаа.

Зөвлөлдөх уулзалтын зорилго нь Монгол Улс дахь хүүхдийн эрхийн өнөөгийн төлөв байдал, хүүхдийн эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлуудыг олон талын мэдээлэл оролцоогоор тодорхойлох, хүүхдийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэсэн билээ.

Хөтөлбөрийн дагуу тус зөвлөлдөх уулзалтыг Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл чиглүүлж, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор П.Оюунчимэг “Монгол Улс дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал-ХЭҮК-оос хүүхдийн эрхийн чиглэлээр хийсэн хяналт шалгалт, судалгаа, сургалт сурталчилгааны үйл ажиллагааны үр дүн”, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэд дарга Б.Халиун “Хүүхдийн эрх, хамгаалал-Төрийн бодлого, үйл ажиллагаа”, НҮБ-ын Хүүхдийн сангийн нийгмийн бодлогын ахлах мэргэжилтэн Н.Энхнасан “Хүүхдийн эрхийн талаарх НҮБ-ын Хүүхдийн сангийн чиг хандлага, бодлого үйл ажиллагаа”, Японы хүүхдийг ивээх сангийн Хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрийн зохицуулагч Э.Цолмон болон Сайн засаглалын төлөө хүүхэд залуусын бүлгийн хүүхдүүд “Өсвөр үеийн дуу хоолой” судалгааны дүнг танилцуулж, илтгэл тавьж хэлэлцүүллээ.

Зөвлөлдөх уулзалтад оролцогчид Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөртэй болох, хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулах ажилд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх шаарлагатай байна гэж дүгнэлээ.

Зөвлөлдөх уулзалтын бэлтгэл ажил, техник зохион байгуулалтыг үйл ажиллагааг Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсээс хариуцан гүйцэтгэж, ажил үүргийн хуваарийн дагуу Комиссын гишүүний тавих илтгэлийг боловсруулах, оролцогчдын нэрсийг цахимаар болон төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлж оролцогчдын нэрсийг хүлээн авах, мөн цайны завсарлага зохион байгуулах, худалдан авалт хийх, оролцогч тус бүрт Комиссоос хэвлүүлсэн ном, гарын авлага багцлан савлаж тараах ажлыг хийв.

Зөвлөлдөх уулзалтыг МҮОНТВ, МҮОНР, SBN, VTV, TM TV, ETV, Монгол HD, C1, Стар ТВ, өнөөдөр сонин, dorgio.mn зэрэг 9 телевиз, нэг радио, өдөр тутмын 1 сонин, 1 мэдээллийн агентлаг нийт 11 хэвлэл мэдээллийн хэрэгсэл сурвалжилж, мэдээллийг олон нийтэд хүргэлээ. ХЭҮК-ыг төлөөлж гишүүн П.Оюунчимэг, Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга Ц.Адъяахишиг нар ярилцлага өглөө.

*"GSP+ буюу Хөнгөлөлтийн ерөнхий хөтөлбөрт хамрагдаж буй орнуудад олон улсын гэрээний хэрэгжилт, түүнд тавих мониторинг сайжруулах нь" сэдэвт сургалт*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс "Equal Rights Trust" олон улсын байгууллагатай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд "GSP+ буюу Хөнгөлөлтийн ерөнхий хөтөлбөрт хамрагдаж буй орнуудад олон улсын гэрээний хэрэгжилт, түүнд тавих мониторинг сайжруулах нь" сэдэвт сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Их Британи Улсад байрлах Equal Rights Trust олон улсын байгууллага нь Монгол Улсад НҮБ-ын хүний эрхийн гол конвенцууд болон ОУХБ-ын хөдөлмөрлөх эрхийн тухай конвенцуудын хэрэгжилт, тэдгээрт хийх мониторинг сайжруулах зорилгоор иргэний нийгэм болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагад стратегийн, техникийн, практик болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд иргэний нийгмийн болон ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулав.

Тус сургалт нь 3 өдрийн турш үргэлжлэх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын эрх тэгш байх эрх болон ялгаварлан гадуурхалтын эсрэг суурь гэрээ конвенцуудын талаарх мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, нөлөөллийн ажиллагаа явуулах, мониторинг, дүн шинжилгээ хийх чадавхийг сайжруулах зорилготой юм.

Сургалтаар "GSP+буюу Хөнгөлөлтийн ерөнхий хөтөлбөр ба НҮБ-ын конвенцууд", "Эрх тэгш байдлын тухай хууль ба стандарт", "Эрх тэгш байдал ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн асуудал", "Ялгаварлан гадуурхалтын эсрэг нөлөөллийн ажиллагаа явуулах нь" зэрэг сэдвийн хүрээнд хичээл заасан юм. Сургалтад нийт 32 төлөөлөл оролцсон бөгөөд сургалтын эцэст сертификат гардуулсан болно. Оролцогчдын 30 орчим хувийг орон нутагт хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл байв.

*“Монгол Улс дахь Хүний эрхийн боловсролын өнгөрсөн, одоо, ирээдүй: Хүний эрхийн боловсрол-2017” сэдэвт онол практикийн бага хурал*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Монголын Эмнести интернэшнл, Монголын Хуульчдын холбоо, МУИС-ын Хууль зүйн сургуультай хамтран 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр “Монгол Улс дахь Хүний эрхийн боловсролын өнгөрсөн, одоо, ирээдүй: Хүний эрхийн боловсрол-2017” сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгуулав.

Онол практикийн бага хуралд Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Эмнести Интернэшнл, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Нийслэлийн боловсролын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль, Монголын хуульчдын холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цагдаагийн Ерөнхий газар, Глоб Интернэшнл ТББ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 90 орчим төлөөлөл оролцож “Насан туршдаа суралцах үйл явц дахь хүний эрхийн боловсрол”, “Монгол Улс дахь хүний эрхийн боловсрол: Ололт, амжилт, авсан сургамж”, “Албан бус сургалтаар хүний эрхийн боловсрол олгож буй нь” сэдвийн хүрээнд илтгэл тавьж, хэлэлцүүлсэн юм.

Мөн үдээс хойш “Сургалтын бодлого, холбогдох бусад бодлого, хэрэгжилт: Шилдэг туршлага, цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээ”, “Хүний эрхийн хичээлийн агуулга, хөтөлбөр, үнэлгээ” сэдвээр салбар хуралдаанууд болж, хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг хүний эрх, боловсрол, технологи гэсэн гурван хүчин зүйлсийн уялдаа холбоог хамгийн зүй зохистой, ашигтай байдлаар ашиглахаар төлөвлөж, цаашдын чиг хандлагаа тодорхойлон Зөвлөмж гарган шийдвэр гаргагчдад хүргүүлэхээр боллоо.

3.1.1 Комиссын тухай хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх, хараат бус байдлыг бэхжүүлэх талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд хэлтсийн ажилтнууд Комиссын 2001-2017 оны гомдол хянан шийдвэрлэх, хяналт шалгалт болон хууль зүйн зөвлөгөөний талаарх мэдээллийг гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Комиссын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгын дагуу явуулж буй Комиссын хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн талаарх дүн шинжилгээнд санал мэдээлэл өгөх ажлыг зохион байгууллаа. Комиссын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар бүлгийг англи, монгол хэлээр бэлдэж ГХЯ-нд хүргүүлэв.

3.1.2. Хүний эрхийн хамгаалагчдын хуулийг төслийн ажлын хэсгийн үйл ажиллагааг зохицуулан ажиллаж, хуулийн төслийг танилцуулга, үзэл баримтлалын хамт боловсруулж УИХ –ын нэр бүхий гишүүдэд өргөн барьсан. Энэ хүрээнд иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлчдээс санал авах

уулзалтыг тус тус зохион байгуулж саналыг төсөлд тусгасан болно. Мөн Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн ажлын хүрээнд Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн судалгааны багын гишүүдтэй хийх ажлын хэсгийн гишүүдийн уулзалтыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хуулийн дагуу судалгаа хийх шаардлагатай мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэж байна.

**3.1.3** Комиссын 16 дахь илтгэлд Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг нэн даруй бий болгож, төсөв орон тоог шийдвэрлэх санал тусгасан бөгөөд энэхүү илтгэлийг бичихдээ холбогдох эрх бүхий байгууллагуудаас мэдээлэл, судалгааг гаргуулан авсан болно.

3.1.4 Комиссын 16 дахь илтгэлд Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар үр дүнтэй мөрдөн шалгах байгууллагыг байгуулах, төсөв орон тоог шийдвэрлэх санал тусгасан бөгөөд энэхүү илтгэлийг бичихдээ холбогдох эрх бүхий байгууллагуудаас мэдээлэл, судалгааг гаргуулан авсан болно.

Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар үр дүнтэй мөрдөн шалгах байгууллагыг байгуулах талаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Комиссоос санал өгснөөс гадна хэлтсийн дарга Т.Ихтамир уг ажлын хэсэгт орж ажилласан.

3.1.5**.** Бизнесийн салбарт хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, стратеги боловсруулах талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилтын хүрээнд Орон тооны бус зөвлөлийн гишүүдтэй санал солилцсон бөгөөд Фридрих Эбертийн Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Нилс Хегевиштэй тохиролцсоны үндсэн дээр 2018 онд энэ чиглэлээр хамтран ажиллахаар болов.

***4.1 Гадаад хамтын ажиллагаа***

4.1.1. Ази Номхон Далайн Бүс нутгийн хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганыг даргалахтай холбоотой мэдээлэл харилцааг зохицуулах үүднээс АНДЧ-ны Хэрэг эрхлэх газрын орлогч дарга Пип Даргантай харилцаж НҮБ-ын Эмэгтэйчүүдийн статусын асуудал эрхэлсэн Комиссын 6 дүгээр хуралд оролцох болон бусад үйл ажиллагаанд оролцох эсэх талаар цахим шуудангаар мэдээллээр хангав. Мөн 2016 оны 3 дугаар сарын 6-ны өдрөөс 8-ний өдрүүдэд ХЭҮБДХ-ны хуралд оролцох үед АНДЧ-ын бүс нутгийн хурал даргалахтай холбоотой хурлын материалуудыг монгол хэл рүү орчуулав

АНДЧ-ны Ажлын албатай харилцанХЭҮК-ын дарга Ази Номхон Далайн Чуулганыг төлөөлөн 2017 оны 7 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд АНУ-ын Нью Иорк хотод болох ХЭҮБДХ, НҮБХХ, ХЭДКГ-ын гурван талт уулзалтад оролцох зохицуулалтыг хийж, АНДЧ-ны зүгээс ХЭҮБДХ болон хурал зохион байгуулагч бусад талуудад тавих асуудлаар санал солилцов.

Европын Холбooноос гаргах санхүүжилтийн 2 дахь үе шат 2019 онд эхлэх бөгөөд ЕХ-ны зүгээс Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбоо (ХЭҮБДХ), бүсийн сүлжээ болон бие даасан ХЭҮБ-уудад төслийн санхүүжилт олгох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан ХЭҮБДХ, Ази Номхон далайн бүс нутгийн ХЭҮБ-уудын Чуулган, Данийн Хүний эрхийн Хүрээлэн, Европын, Африкийн болон Америк тивийн ХЭҮБ-уудын холбоо нарын дунд байгуулах харилцан зөвшилцөлийн баримт бичгийн төслийг АНДЧ-ны дарга Ж.Бямбадоржид танилцуулсан болно. АНДЧ-ны Нарийн бичгийн дарга Киерэн Фицпатрикт тус баримт бичигт гарын үсэг зурж болохыг зөвшөөрсөн хариу илгээв.

АНДЧ-ны 22 дахь удаагийн уулзалтад оролцохтой холбогдуулан Комиссын зүгээс 2 төлөөлөл (Комиссын дарга болон ЗХАХ-ийн дарга) оролцох зардлыг хүссэн тухай захидал АНДЧ-ны Нарийн бичгийн газарлуу илгээж, зөвшөөрөл авав. Мөн уг хурлын үеэр Чуулганы хүсэлтээр зөвлөх үйлчилгээ явуулж буй хатагтай Жо Холлтой Комиссын даргын хийх ярилцлагын товыг тогтоов.

4.1.2. ХЭҮБДХ-ны 30 дугаар хуралд Комиссын дарга Ж.Бямбадорж оролцов.Бэлтгэл ажлын хүрээнд Комиссын даргын Шенгэний виз авах ажлыг зохицуулж, Швейцарийн Холбооны Улс дахь Элчин сайдын яаманд албан бичиг хүргүүлэн Комиссын дарга уг арга хэмжээнд оролцохтой холбогдуулан дэмжлэг үзүүлэхийг хүсэв. Мөн хурлын хөтөлбөр болон бусад материалыг орчуулж бэлэн болгов. Мөн ХЭҮБДХ-ны 30 дугаар хурлын тухай цахим хуудсан дээр мэдээлэл бэлтгэж, 2017 оны 3 дугаар сарын

9-ний өдөр хүүхдийн эрхийн чиглэлээр нэмэлт хуралд оролцох болсон тул холбогдох мэдээллийг монгол хэл рүү орчуулав.

4.1.3. Тайланд Улсын Бангкок хотод 2017 оны 11 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд АНДЧ-ны 22 дахь удаагийн уулзалт болох Комиссын дарга Ж.Бямбадорж, тус хэлтсийн дарга Ө.Ундрах нар оролцов. Хурлын нээлт болон эхний хэсгийг Ж.Бямбадорж дарга даргалан зохион байгуулав. Хөтөлбөр батлсны дараа Афганистан Улсын Хүний эрхийн Хараат Бус Комисст Чуулганы даргын үүрэгт ажлыг хүлээлгэн өглөө.

4.1.4. ХЭҮБДХ-ны Бизнес ба хүний эрхийн Ажлын хэсэгт 2016 оны 10 дугаар сараас 2017 оны 2 дугаар сар хүртэлх хугацааны ажлын тайлан болон 2017 оны 3 дугаар сараас 9 дүгээр сар хүртэлх хугацааны ажлын тайланд санал болон Комиссын зүгээс оруулах мэдээлэл өгөв. Ажлын хэсгийн гишүүдтэй цахим шуудангаар харилцаж, тухай бүр нь цаг үеийн шинжтэй мэдээлэл солилцож ажиллалаа.

4.1.5. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын Монгол дахь зохицуулагч Жылдыст харьяалалгүй иргэдийн статистик үзүүлэлтүүдийг Гадаад иргэдийн харьяатын газраас авч шилжүүлэв.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн статусын асуудал эрхэлсэн Комиссын 61 дүгээр чуулганд оролцох асуудлаар АНДЧ-аас ирсэн цахим шууданг Комиссын даргад орчуулан танилцуулж, уг арга хэмжээнд оролцох Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн Комиссын даргыг оруулж өгөхийг хүссэн албан бичгийг төлөвлөн хүргүүлэв. Ийнхүү оролцох талаар АНДЧ-ны Хэрэг эрхлэх газрын дэд захирал Пип Дарганд цахим шуудангаар мэдэгдэв.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Хүний эрхийн үндэсний байгууллагуудаар бэлдэж буй тайлангийн санал асуулгад О.Ичинхорлоогийн бэлтгэсэн материалыг 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хянаж явууллаа.

АНДЧ-ын гишүүдийн дотоод хяналт, үнэлгээний асуудлаар хийж буй судалгааны ажлын хүрээнд холбогдох санал асуулгыг 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр бөглөн явуулж, 4 дүгээр сарын 21-ны өдөр цахим шууд ярилцлагад хамрагдав.

НҮБ-ын ХЭДКГ, Хүүхдийн эрхийн хорооны Ажлын албатай харилцан уг Хороонд Комиссын хөндлөнгийн илтгэл өгөх эцсийн хугацааг товлон 5 дугаар сарын 15-ны өдөрт багтаан Комиссын хөндлөнгийн мэдээллийг хүргүүлэв.

АНДЧ-ны гишүүн орнуудаасаа авч байгаа тус байгууллагын гишүүнчлэлийн тухай судалгаанд хариулж, Комиссын Ажлын албаны даргаар батлуулан хүргүүлэв. НҮБ-ын ХЭДКГ, Хүний эрхийн хорооны Ажлын албатай харилцан уг Хороонд Комиссын хөндлөнгийн мэдээллийг хүргүүлэв.

Данийн Хүний эрхийн Хүрээлэн болон НҮБ-ын Хүүхдийн Сангаас ирүүлсэн санал асуулгад хэлтсийн дарга Ц.Адъяахишиг хариу бэлтгэхэд дмжлэг үзүүлж, бэлтэн болсон асуулгын хариуг холбогдох цахим хаягаар илгээв.

Олон Улсын Парламентын Хүний эрхийн Хорооны төлөөлөгчид Комиссын дарга, гишүүдтэй хийсэн уулзалтын бэлтгэлийг хангаж, зохион байгуулав. Т.Ариунаа референт уулзалтын тэмдэглэл хөтлөв.

НҮБ-ын Хүн Амын Сантай ХЭҮК хамтран ажиллах 5 жилийн гэрээнд гарын үсэг зурах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулав.

Мөн дээрх хамтын ажиллагааны хүрээнд НҮБХАС-аас зохион байгуулсан тал өдрийн санхүүгийн сургалтад Ахлах нягтлан бодогч С.Нармандах, Т.Ариунаа референт нар Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн референт Г.Золзаягийн хамтаара хамрагдав.

Эмнести Интернешнл байгууллагын дэлхийн үйл ажиллагааг хариуцсан захирал ХЭҮК-ын гишүүн Н.Ганбаяр уулзах уулзалтыг зохион байгуулав.

НҮБ-ын Хүний эрх ба байгаль орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгч Жон Нокс МУ-д айлчлал хийж байгаатай холбогдуулан ХЭДКГ, Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй харилцан ноён Жон Ноксын айлчлалын хөтөлбөрийн хүрээндХЭҮК-той уулзалт хийх, Олон нийтийн лекц унших, Хүний эрхийн өглөөний цай уулзалтад оролцох, Төв аймгийн Заамар сум дахь уул уурхайн нөлөөлөлд өртсөн нутгийн нөхцөлтэй танилцах зэрэг ажлуудыг тусгуулан зохион байгуулалтыг ханган ажиллав.

Филиппинь Улсын Хүний эрхийн Комисс-т тус улсын төр болон олон нийтийн зүгээс дарамт шахалт үзүүлж байгаатай холбогдуулан МУ-ын ХЭҮК-ын зүгээс Филиппиний Комиссын үйл ажиллагааг дэмжиж байгаагаа илэрхийлсэн захидлыг англи хэл дээр боловсруулан хүргүүллээ.

НҮБ-ын Орон байраар хангагдах эрхийн асуудал хариуцсан Тусгай Илтгэгч ХЭҮБ-ууд болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс энэ асуудлаар мэдээлэл бэлтгэж явуулахыг хүссэн бөгөөд ахлах референт З.Өнөржаргал-д Тусгай Илтгэгчээс ирүүлсэн агуулга, асуултыг орчуулж (1.5 хуудас), бэлтгэсэн мэдээллийг буцаж англи хэлрүү орчуулж (3 хуудас)цааш хүргүүлэв.

АНДЧ-ны Хурлын үеэр Чуулганы хүсэлтээр зөвлөх үйлчилгээ явуулж буй хатагтай Жо Холлтой Чуулганы стратеги төлөвлөгөөний хүрээнд явуулж буй үйл ажиллагааны өгөөж, гүйцэтгэлд үнэлгээ хийх зорилгоор Комиссын даргатай ярилцлага хийв. Чуулганы ээлжит хурлын үеэр Комиссын төлөөлөгчид цаазаар авах ялыг сэргээхтэй холбоотой нөхцөл байдалд явуулах боломжит үйл ажиллагааны талаар ХЭДКГ-ын хэлтсийн дарга Владлен Стефанов болон АНДЧ-ны Хэрэг эрхлэх газрын дарга Киэрен Фицпатрик нартай санал солилцон ирэх онд нөлөөллийн үйл ажиллагаа хамтран зохион байгуулахаар урьдчилсан байдлаар тохиролцов.

Мэдээлэл солилцох үүднээс АНДЧ-ны хэвлэл мэдээллийн ажилтан руу цахим хуудаст орчуулсан 5 мэдээг хүргүүлсэн бөгөөд АНДЧ-ны цахим хуудсанд Equal Rights Trust-тай хамтран зохион байгуулсан тухай мэдээг одоогоор оруулсан байгаа бөгөөд АНДЧ-ны мэдээллийн хуудасны "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл болон хувийн хэвшил дэх хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт” зөвлөлдөх уулзалтыг онцлох мэдээгээр оруулуулахаар төлөвлөж байна.

**4.1.6.** Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын Женев дэх төвийн үйл ажиллагаанд оролцох зорилтын хүрээнд уг Төвөөс ирүүлсэн урилгын дагуу Зэвсэгт хүчний омбудс байгууллагуудын олон улсын ээлжит хуралд оролцох санхүүжилтийн асуудлаар уг Төвтэй мэйлээр харилцсан боловч зохион байгуулагчдын зүгээс уг арга хэмжээнд Комиссын төлөөлөл оролцоход энэ удаа туслалцаа үзүүлэх боломжгүй байгаа тул дараагийн арга хэмжээнд хамтран ажиллая гэсэн хариу өгсөн болно.

4.1.7.Дараах олон улсын хурал, сургалт семинарт Комиссын төлөөлөл оролцох бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулалтыг хийв. Үүнд:

- Тайландын Бангкок хотод 1 дүгээр сарын 30-31-ний өдөр болсон ‘Хувцас үйлдвэрлэлийн салбар: Бизнес ба хүний эрх’ бүс нутгийн семинарт Б.Сэмжидмаа референт оролцох бэлтгэл ажлын хүрээнд гадаад томилолтын тушаал гарган, Б.Сэмжидмаагийн цахим албан паспорт захиалгын ажлыг хийж, нислэгийн тийз захиалах, семинарын үеэр тавих танилцуулгын бэлтгэлд хяналт тавив.

- Катар Улсын Доха хотод 2 дугаар сарын 20-21-ний өдөр ‘Арабын бүс нутаг дахь мөргөлдөөний асуудалд хүний эрхийн өнцгөөс хандах нь’ Бүсийн бага хурал болон ХЭҮБ-ын зэргэлдээ арга хэмжээнд Комиссын Ажлын албаны дарга Ч. Алтангэрэл оролцох бүртгэл, нислэгийн тийзийн захиалга, цахим виз авах зохицуулалтыг хийж бэлтгэл ажлыг хангав.

- Женев дэх Зэвсэгт хүчний ардчилсан хяналт, ЕАБХАБ-ын АИХЭБ-ын хамтран зохион байгуулж буй Зэвсэгт хүчний омбудс байгууллагуудын 2017 оны 3 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд семинарт оролцох тухай урилга хүлээж авсны дагуу Комиссын гишүүн П.Оюунчимэг оролцох болсон. Оролцогчийн бүрдүүлэх маягт болон бусад материалыг явуулсан. Нислэгийн хуваарь тааралгүй тул энэ томилолт нь цуцлагдсан болно.

- АНДЧ, НҮБХХ-ийн Истанбул дахь бүс нутгийн төвтэй хамтран Төв Азийн хүний эрхийн байгууллагуудын ажилтнуудад зориулсан сургалтад оролцох тухай урилга ирсэн. Удирдлагуудад танилцуулсны дагуу Комиссын гишүүн П.Оюунчимэг, ахлах референт Л.Дугэрсүрэн нар оролцов. Бэлтгэл ажлын хүрээнд оролцогчдыг бүртгүүлэх, нислэгийн хуваарь зохицуулах, Комиссын

танилцуулга болон Нээлттэй хяналт шалгалтын ХЭҮК-ын туршлага зэрэг хоёр танилцуулга бэлдэв. Нээлттэй хяналт шалгалтын тухай танилцуулгыг монгол, англи, орос хэлээр бэлдэж явуулав.

- Тайландын вант улсын Бангкок хотод болсон “Залуучууд, энх тайван, аюулгүй байдал” олон улсын бага хуралд референт Г.Золзаяа оролцов.Уг томилолттой холбогдуулан цахим албан паспорт ГХЯ-аас авах бэлтгэл ажлыг хангаж маягт гарган өгч, гадаадад томилолтоор ажиллуулах тухай Комиссын АА даргын тушаал, цахим албан паспорт хүссэн тухай ноот бичиг боловсруулан гаргав.

- ХЭҮБДХ, ХЭДКГ, ФЭС-аас хамтран Швейцарийн Холбооны Улсын Женев хотод 5 дугаар сарын 1-5-ны өдөр зохион байгуулсан “Олон улсын хүний эрхийн тогтолцооны талаарх ХЭҮБ-уудын сургалт”-д ЗХАХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Ундрах оролцов.

- АНДЧ-ны Ажлын албатай харилцаж, Казахстан улсын Астана хотод 2017 оны 5 дугаар сарын 15-16-ны өдөр болох “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Казахстан улсын болон олон улсын туршлагууд” сэдэвт Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын анхдугаар чуулга уулзалтад Комиссын гишүүн Н.Ганбаяр АНДЧ-ныг төлөөлөн оролцов.

- АНДЧ, ДХЭХ-тэй хамтран Бизнес ба хүний эрх сэдвээр бүс нутгийн сургалт зохион байгуулсан бөгөөд тус сургалтад Комиссоос Говь-Алтай аймгийн ахлах мэргэжилтэн Б.Ариунжаргал оролцлоо. Б.Ариунжаргалд даатгалын баримт бичиг бүрдүүлж өгөх, аяллын явцын талаар зөвлөгөө өгөх, сургалтанд оролцох талаар зөвлөгөө өгөх байдлаар ажиллав.

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Солонгос Улсын Сөүл хотод 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс мөн оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хооронд зохион байгуулах “Хүний эрхийн ажилтнуудын түншлэл 2017” сэдэвт сургалтад Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн ажилтан О.Ичинхорлоо оролцов.

- Бүгд Найрамдах Польш Улсын Познань хотод ЕАБХАБ болон ХЭҮБЕС-нээс хамтран зохион байгуулсан ХЭҮБ-уудын 2017 оны Академи сургалтад референт Б.Сэмжидмаа оролцов.

- АНУ-ын Нью Иорк хотод 2017 оны 7 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд болох ХЭҮБДХ, НҮБХХ, ХЭДКГ-ын гурван талт уулзалтад Комиссын Ажлын албан дарга Ч.Алтангэрэл Комиссын даргын хамтаар оролцох бэлтгэл ажлын хүрээнд ГХЯ-ны Консулын газраар АНУ-ын Элчин сайдын яаманд өгөх ноот бичгийг гаргуулж, оролцогчдын урилгыг хүсэлт гарган хүн нэг бүр дээр гаргуулж, нислэгийн тийзийн захиалгыг ХЭҮБДХ-оор дамжуулан хийлгэв.

- Бүгд найрамдах Киргиз Улсын Бишкек хотод 2017 оны 9 дүгээр сарын 5-9-ний өдөр БНКУ-ын Омбудсманы Газраас зохион байгуулсан “Хүний эрхийн чиглэлээр хэм хэмжээ тогтоосон болон эрх зүйн актыг боловсронгуй болгоход омбудсманы байгууллагын гүйцэтгэх үүрэг роль” сэдэвт олон улсын хуралд Комиссын гишүүн Н.Ганбаяр оролцов. Уг томилолтыг зохион байгуулах ажлын хүрээнд Комиссын даргын тушаал боловсруулан гаргуулж, НҮБ-ын Хүүхдийн Сантай харилцан нислэгийн тийзийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэв.

- Комиссын дарга Ж.Бямбадорж, гадаад харилцаа хариуцсан ажилтан Г.Түвшинжаргал нар Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод 2017 оны 9 дүгээр сарын 18-нд болсон Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн чуулганы Насжилт хариуцсан Ажлын хэсгийн тусгай уулзалт, мөн Сөүл хотод 2017 оны 9 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд болсон Насжилт болон Ахмад настны хүний эрх сэдэвт Ази-Европын хоёрдугаар бага хуралд оролцов. Уг ажлын хүрээнд Комиссын даргад УИХ-ын даргын Захирамж гаргуулах, Ажлын албаны даргаар гадаад томилолтын тушаал гаргуулах, БНСУ-ын виз гаргуулахад шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг бэлтгэх, виз гаргуулах, Солонгосын хүний эрхийн үндэсний комисстой онгоцны тийз болон зочид буудлын талаар харилцах, тус хуралтай холбоотой мэдээллүүдийг орчуулах, Монгол Улсаас БНСУ-д суугаа элчин сайдын яамтай холбогдож онгоцны буудлаас тосох, буцаан хүргэж өгөх ажлыг зохион байгуулах ажлуудыг гүйцэтгэв.

Мөн дээр дурдсан уулзалт, бага хуралд Комиссын дарга оролцсон талаар илтгэх хуудас бэлтгэн хүргүүлэв.

- Ц.Адъяахишиг хэлтсийн дарга Бангкок хотноо болох АНДЧ-наас зохион байгуулж буй хяналт үнэлгээ хийж, тайлагнах нь нэртэй холимог сургалтад оролцохтой холбогдуулан Ц.Адъяахишигийг гадаадад

томилолтоор ажиллуулах тухай тушаалын төсөл боловсруулж, мөн зохион байгуулагч талтай имейлээр харилцахад техникийн туслалцаа үзүүлэв.

- Хэлтсийн дарга Ц.Адъяахишиг нь АНДЧ-наас зохион байгуулж буй “Хүний эрхийн боловсролыг чиглүүлэх нь” нэртэй цахим сургалтад оролцож эхэлж байсан боловч тэрээр хөлөө гэмтээсэнтэй холбогдуулж миний бие тус сургалтыг үргэлжлүүлэхэд нь туслах үүрэг авсан. Үүний дагуу тус сургалт зохион байгууалагчид хүргүүлэх үнэлгээний хуудсыг Ц.Адъяахишиг даргатай хамтарч бөглөж цааш явуулсан басургалтын хэлэлцүүлгийн форумд оролцож, өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэх зэргээр түр оролцож байна.

Хэлтсийн дарга Т.Ихтамирийг БНСУ-ын Жежү арал дахь UNITAR CIFAL байгууллагаас 2017 оны 11 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд “Хохирогч-төвтэй хандлагыг сайжруулах” нь сэдэвт хүн худалдаалах гэмт хэргийг хамарсан сургалтад оролцуулах тухай урилга ирсэн бөгөөд үүнтэй холбогдуулан зохион байгуулагч талруу холбогдох мэдээллийг явуулах, онгоцны билет захиалах ажлыг хийж байна.

- АНУ-ын Нью-Йорк хотноо болсон “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал сэдэвт олон улсын төсөл”-ийн жил тутмын зөвлөлдөх уулзалтад Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл оролцох ажлын хүрээнд тус хэлтсээс АНУ-ын ЭСЯ-нд визний өргөдөл гаргахад албан захидал боловсруулав. Мөн уулзалтад оролцсон тухай мэдээллийг Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл able програмд оруулсан болно.

- 2017 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Бангладеш Улсын Дакка хотод болсон Ази Номхон Далайн бүс нутгийн ХЭҮБ-уудын Чуулганы Харилцааны сүлжээний уулзалтад тус хэлтсийн Т.Ариунаа референт оролцов. Сургалт уулзалтад оролцохтой холбогдуулан БНХАУ-ын Бээжин хот дахь Бангладеш Улсын ЭСЯ-нд визний материалаа дипломат шуудангаар хүргүүлэв. Сургалтад нийт 25 улсаас ирсэн ХЭҮБ-уудын ажилтнууд хамрагдав. Тус сургалтаар ХЭҮБ-ууд хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагаандаа олон нийтийн дэмжлэгийг хэрхэн авч байгаа, ямар аян өрнүүлсэн, хэрхэн хэвлэл мэдээлэлтэй хамтарч ажиллах талаар өөрсдийн туршлагаас солилцов. Энэ үеэр МУХЭҮК нь Хүний эрхийн сэтгүүлчдийн клубтэй, мөн Орон тооны бус зөвлөлтэй буюу иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтарч ажилладаг тухай туршлагаасаа хуваалцав. Мөн дижитал контент хэрхэн боловсруулах тухай заасан бөгөөд оролцогч бүр дор бүрнээ өөрсдийн дижитал контентыг багшийн тусламжтай хийж гүйцэтгэв.

- Хэлтсийн дарга Ц.Адъяахишиг Индонез улсын Жакарта хотноо 12 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд болох Насанд хүрэгчдэд чиглэсэн хүний эрхийн боловсролын чиглүүлэгч нарт зориулсан танхимын сургалтад, референт Б.Сэмжидмаа Япон улсын Токио хотод 12 дугаар сарын 11-27-ны өдрүүдэд болох "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн манлайлагч бэлтгэх" сэдэвт сургалтад тус тусын уригч байгууллагын зардлаар оролцох юм. Үүнтэй холбогдуулан дээрх 2 ажилтныг гадаадад томилолтоор ажиллуулах тухай тушаалын төслийг боловсруулав. Мөн хэлтсийн дараг Ц.Адъяахишигийн хүсэлтээр аяллын даатгалыг нь хийж гүйцэтгэв.

4.1.8. ХЭҮБДХ-ны гишүүнчлэлийн татвар болох 5000CHF-ийг шилжүүлэв. АНДЧ байгууллагын гишүүнчлэлийн татвар 3000USD-ийг шилжүүлэхэд төсөв хүрэлцэхгүй байсан тул төсвийн тодотголоор ханшийн зөрүүнээс үүссэн нэмэлт төлбөрийг төсөвт нэмж тусгахаар Сангийн Яаманд албан бичиг өгч, төсвийн тодотголоор 2.1 сая төгрөг нэмж тусгуулан АНДЧ байгууллагын гишүүнчлэлийн татвар 3000USD-ийг шилжүүлэв.

4.1.9. Данийн Хүний эрхийн Хүрээлэнгээс ХЭҮБ-уудын дунд “Хүний эрхийн боловсрол” сэдвийн хүрээнд төслийн санхүүжилт зарлагдсантай холбогдуулж “Эрүүл мэндийн ажилтнуудын хүний эрхийн боловсролыг нэмэгдүүлэх нь” сэдэвт төслийн саналыг референт Х.Цэцгээ, референт Г.Золзаяа нартай хамтран боловсруулж, орчуулж цааш хүргүүлсэн төслийн санал маань шалгарсан. Төслийн саналыг сайжруулах үүднээс ДХЭХ-с хэд хэдэн санал зөвлөмж хүргүүлснийг төслийн саналдаа дахин тусгаж цааш явуулсан. Одоогоор хоёр талын байгууллагын дунд гэрээ байгуулсан байгаа ч төслийн санхүүжилтийг ирэх оны ихээр авах тухай тохиролцсон.

Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн ажитнууд төслийн санал боловсруулаагүй байна.

### *4.2. Дотоод хамтын ажиллагаа*

4.2.1. Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн ээлжит хурлыг 2017 оны 5 сарын 26 ны өдөр зохион байгуулав. Энэ удаагийн хурлаар Комиссын 2017 оны 1дүгээр улиралд хийсэн ажлын тайлан, 2,3-р улиралд ИНБ-тай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Комиссын Ажлын албаны дарга Ч. Алтангэрэл, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийн талаар Захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ө. Ундрах нар тус тус танилцуулж, хүний эрхийн тулгамдаж байгаа болон цаг үеийн зарим асуудлаар гишүүд санал солилцсон болно. Хурлаас Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ удаагийн илтгэлд тусгагдсан асуудлуудыг орон тооны бус зөвлөлийн гишүүд дэмжиж, өөр өөрсдийн чиглэл тус бүрийн хүрээнд төр засаг, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулахаар тохиролцов.

Орон тооны бус зөвлөлийн 2017 оны хоёр дахь хурлын үйл ажиллагааны хүрээнд 2017 оны 12 сарын 04 ны өдөр хуучин гишүүддээ талархал илэрхийлж, үйл ажиллагааны нь тайланг нэгтгэн танилцуулав. Мөн шинээр томилогдсон гишүүдийн анхдугаар уулзалтыг тус тус зохион байгуулсан ба уулзалтаар Зөвлөлийн гишүүдээс 2018 онд Комисстой хамтран ажиллах саналыг авч, зөвлөлийн дүрэм, зөвлөлийн ажиллах үүрэг, чиглэлийг танилцуулав.

4.2.3. Захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс “Тогтвортой хөгжлийн зорилтууд – Хамтын ажиллагаа” зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 1 дүгээр сарын 26, 11 дүгээр сарын 16-нд тус тус зохион байгуулав. Уг уулзалтуудаар уулзалтын сэдвийн хүрээнд 2017 он, 2018 онд явуулах үйл ажиллагаанхаа чиглэлээр оролцогчид мэдээлэл, санал солилцов.

4.2.4. Санамж бичиг байгуулсан нийт 6 байгууллагатай 2017 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж батлуулсан. Шинээр МӨХ, МХЕГ,ХҮТТ-тэй санамж бичиг байгуулсан. Мөн төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд Эмэгтэй удирдагч сан, МОНЭС-тай ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, Хөдөлмөрийн хуульд ажлын байрны бэлгийн дарамтын асуудлаар заалт оруулахаар ажиллаж байна. НҮБ-ын хүн амын сантай нөхөн үржихүйн эрх, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар хамтран ажиллах ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Жендэрийн үндэсний Хороотой тогтмол харилцаж, Жендэрийн тэгш байдлыг хангах “Үндэсний хөтөлбөр”, тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлт зэрэг баримт бичгүүдэд санал өгч ажиллав. Түүнчлэн Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жендэрийн ажлын алба хэрэгжүүлж буй “Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” төслийн удирдах хорооны гишүүнээр ажиллаж, тус хорооны хуралд тогтмол оролцож, хурлын шийдвэр үр дүнг Ажлын албаны даргад танилцуулсан болно.

Санамж бичгийн хүрээнд санамж бичиг бүхий байгууллагуудтай 2017 онд хийгдсэн ажлын тайланг нэгтгэн гаргаж, санамж бичгийн хугацаа нь дуусч буй ШШГЕГ, ЗХЖШ, ЦЕГ-тай байгуулах санамж бичгийн шинэчилсэн төслийг гарган Дарга, гишүүдээр хянуулав. Мөн энэ чиглэлээр санамж бичиг бүхий байгууллагуудаас 2018 онд хамтран ажиллах саналыг аван, Комиссын төлөвлөгөөнд тусгасан. 2017 оны 12 сарын 11-нд ШШГЕГ, ЗХЖШ, 12 дугаар сарын 19-ны өдөр ЦЕГ-тай санамж бичиг байгуулах арга хэмжээг зохион байгуулав.

### *Комиссын дотоод үйл ажиллагаа*

5.1.1. Орон нутгийн ажилтнуудын ажлын нэгдсэн үнэлгээг гарган ажлын алба болон Комиссын хуралд танилцуулсан. Мөн Комиссын менежерүүдийн хурлаар орон нутгийн ажилтнуудын тайлан, төлөвлөлт, ажлын гүйцэтгэлийг сайжруулах асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулж, энэ талаар орон нутгийн ажилтнуудад мэдээлсэн. Анхаарал татсан ажилтнуудад ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах асуудлаар биечлэн утсаар болон абле-ээр харилцаж холбогдон ажиллаж байна.

5.1.2. Комиссын ажилтнуудыг чадавхижуулах дотоод сургалтын хэрэгцээ шаардлагын талаар ажилтнуудаас цахим программаар санал авч, дараах сургалт зохион байгуулсан байна. Үүнд:

1. Комисст шинээр орсон ажилтнуудад “Комиссын гомдол шийдвэрлэх ажиллагаа, шаардлага, зөвлөмж, хяналт шалгалт, хууль зүйн зөвлөгөө”, Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага сэдвээр 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Ахлах референт Л.Дүгэрсүрэн, референт Б.Сэмжидмаа, Г.Золзаяа нар тус тус 1 цагийн сургалт хийв.

2. “Төрийн албаны дэг ёс, харилцаа”-ны талаар Ахмад дипломатч Ш.Юмжав гуайг урьж ажлын албаны 24 ажилтанд 2 дугаар сарын 14-ний өдөр сургалт хийв
3. Цагдан хоригдож байгаа этгээдээс мэдэгдэл тайлбар авах талаар орон нутгийн ажилтнуудад 4 дүгээр сард цахим сургалт хийв. Сургалтыг гомдол хүлээн авах, шалгах ажиллагаа явуулах, хянан шийдвэрлэх гэсэн 3 бүлэгт хувааж, өдөр бүр дээрх бүлэг сэдвийн хүрээнд даалгавар өгч, тодорхой тохиолдол дээр ажиллуулах, тухай бүр хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр зохион байгуулав.
4. "Хөдөлмөрлөх эрхийн суурь зарчмууд: Олон улсын чиг хандлага" сэдвээр ОУХБ-ын хөтөлбөрийн зохицуулагч П.Болормаа 5 сарын 3-нд 14 цагаас сургалт хийж ажлын албаны 20 ажилтан хамрагдав.
5. “Үр дүнд суурилсан төлөвлөлт, тайлагналт сэдвээр НҮБХХ-ийн Хяналт, дүн шинжилгээний мэргэжилтэн Ө.Буяндэлгэр 6 дугаар сарын 21-ний өдөр 1цаг 30 минутын сургалт хийж ажлын албаны 19 ажилтан хамрагдав.
6. Инфографик хэрхэн хийх талаар ХЭБСХ-ийн ажилтан С.Будрагчаа 6 дугаар сарын 23-ны өдөр 1цагийн сургалт хийж ажлын албаны нийт ажилтнууд хамрагдав.
7. “Тогтвортой хөгжлийн зорилтууд ба Хүний эрх " сэдвээр / НҮБХС-ийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Д.Хүрэлмаа / 2017 оны 12 дугаар сарын 18-ны 10.00-11.00 цагт 1 цагийн сургалт хийж ажлын албаны нийт ажилтнууд хамрагдав.
8. “Сэтгэцийн цочрол хямралтай байгаа хүмүүстэй ажиллах нь " сэдвээр /Монгол Өрх ТББ-ын тэргүүн С.Баасанбат 2017 оны 12 дугаар сарын 18-ны 14.00-15.00 цагт 1 цагийн сургалт хийж ажлын албаны нийт ажилтнууд хамрагдав.
9. "Бидний мэддэг хэрнээ мэддэггүй сэтгэл судлал " сэдвээр /Сэтгэл зүйч Д.Оюун-Номин / 2017 оны 12 дугаар сарын 20-ны 16.00-17.00 цагт 1 цагийн сургалт хийхээр төлөвлөж, ажлын албаны нийт ажилтнуудад мэдэгдэв.

Гомдол, хяналт шалгалтын хэлтсээс “Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр орон нутгийн ажилтнуудад зориулсан цахим сургалтыг 2017 оны 4 дүгээр сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулахаар сургалтын төлөвлөгөөг гаргаж, цахим сургалтыг эхлүүлэн ажиллаж байна. Сургалтыг гомдол хүлээн авах, шалгах ажиллагаа явуулах, хянан шийдвэрлэх гэсэн 3 бүлэгт хувааж, өдөр бүр дээрх бүлэг сэдвүүдийн хүрээнд даалгавар өгч, тодорхой тохиолдол дээр ажиллуулах, тухай бүр хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр явуулсан байна.

5.1.4. ажилтнууд хариуцсан эрхийн чиглэлээр мэдээллийн багц баяжуулж, шинэчилсэн.

5.2.1.Орон нутгийн ажилтнуудын ажлын хүрээнд хэлтэс тус бүр орон нутгийн ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэх гэсний дагуу Захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулав.

5.2.2. Комисс 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 12 удаа хуралдаж нийт 12 асуудал авч хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хурлын бэлтгэл ажлыг хангаж, тэмдэглэлийг хөтөлж баримтжуулсан.

5.2.3. Комиссын ээлжит хурлаар баталсан 2017 оны сар бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Авле программын олон нийтийн файлын санд байршуулж ажилтнуудад мэдэгдэв. Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн сарын тайланг тухай бүр гаргаж дотоод ажил хариуцсан референтэд хүлээлгэн өгөх, мөн хариуцсан мэдээллийн самбарыг тогтмол шинэчилэх зэрэг ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна

5.2.4. Энэ ажлын хүрээнд Хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хэмээн Комисст хандаж тусламж хүссэн, гомдол гаргасан иргэдийн судалгаа, танилцуулга болон гомдол шийдвэрлэлтийн талаар Комиссын 2016 онд хийсэн ажлын товч танилцуулгыг бэлтгэн Ажлын албаны даргаар хянуулж 2017.01.27-нд 4/69 дугаар албан бичгээр ҮАБЗ-ийн Ажлын албанд хүргүүлэв.

5.2.5. Комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд дотоод хяналт, үнэлгээ хийлгэх ажил үүргийн дагуу хэлтсийн дарга нараас сар бүрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг авч нэгтгэн Ажлын албаны даргад танилцуулж үнэлүүлж ажиллав.

Комиссын орон нутаг дахь ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хагас, бүтэн жилээр гаргаж, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллав.

Мөн Комиссын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгч жилийн эцсийн тайланг гаргав.

5.2.6. Комиссын 2016 оны 12-р сар, 2017 оны 1-ээс 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад нь хугацаанд нь хүргүүлэв. Комиссын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс мэдээллийн самбарт тухайн бүр төсвийн гүйцэтгэлийн тайланг байрлууллаа. Мөн Сангийн яамтай тооцоо нийлж 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хийв. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн яамны цахим системд шивж оруулсан. 2016 оны нэмэлт санхүүжилтийн санхүүгийн тайлан мэдээг санхүүжүүлэгч бүрээр гаргаж дуусав. Мөн өмнөх оны ILO төслийн санхүүжилтийг дансандаа буцаан авч, зарцуулах эрх нээлгэж, холбогдох гүйлгээнүүдийг хийж, зарцуулж дуусган тайланг санхүүжүүлэгчид хүргүүлэв. Швейцарийн Хөгжлийн агентлагийн 2016, 2017 оны санхүүжилтийн санхүүгийн тайлан мэдээг, санхүүгийн баримтын хуулбарын хамт хүргүүлэв.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний Аудитын газар хүргүүлсэн. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний Аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал аудит хийж дууссан. Аудитын дүгнэлт зөрчилгүй гарсан. Швейцарийн Хөгжлийн агентлагийн 2017 оны эхний санхүүжилтийг хүлээн авч дотоод томилолтын нарийвчилсан төсвийн хийж батлуулан холбогдох гүйлгээнүүдийг тухай бүрт нь хийв.
ХХОАТ-ын 2017 оны 1,2,3,4-р улирлын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад нь хугацаанд нь хүргүүлэв.

Комиссын 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлэв. Мөн Үндэсний аудитын газраас хийсэн 2017 оны явцын аудитын шалгалтад шаардлагатай мэдээллүүдийг 2017 оны 10 дугаар сараар тасалбар болгон гаргаж өгөв.

**5.2.7.** Комиссын 2016 оны 12-р сар, 2017 оны 1-ээс 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад нь хугацаанд нь хүргүүлэв.

Комиссын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс мэдээллийн самбарт тухайн бүр төсвийн гүйцэтгэлийн тайланг байрлууллаа.

2016 оны санхүүгийн баримтуудыг цэгцэлж үдэж архивт хүлээлгэж өгөв.

Комиссын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтөлж, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав. Тухайлбал дотоод сүлжээ, компьютер, хэвлэх төхөөрөмжүүдэд гарсан гэмтэл доголдолуудыг цаг тухай бүр нь засч тохируулан хэвийн ажиллагаанд нь оруулж байлаа.

Энэхүү ажлын хүрээнд комиссын эд хөрөнгийг тоолох ажлын хэсэгтэй хамтран 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 25-ны өдөр хүртэлх хугацаанд 501-514, 605, складад байрлах эд хөрөнгийг тоолж дуусгав. Мөн албан хаагчдын гар дээрх эд хөрөнгийн бүртгэлийн хуудсыг шинэчилж тооллогын комисстой хамтран складаас 1 багц номын тавиурыг 605 өрөөнд байршуулсан. Сар бүр зочны цайны үйлчилгээний худалдан авалт хийв.

Комиссоос зохион байгуулсан уулзалт, сургалт, хурлын зохион байгуулалт хийж оролцов.
 Сар бүрийн төлөвлөгөөнд заасан ажлуудын Хамтран ажиллагч олон улсын байгууллагуудтай хийсэн уулзалт, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтаж Наран моллын эвэнт холлд “Эмэгтэйчүүд ба жендэрийн тэгш байдал” сэдэвт уулзалт, иргэний нийгмийн байгууллагуудад Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 16 дахь илтгэл танилцуулах уулзалт, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж "Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах нь" зөвлөлдөх уулзалт, Санамж бичгийн хүрээнд зохион байгуулсан Цагдаагийн байгууллагын алба хаагчдад Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтуудадцай завсарлагын төсөв гаргаж худалдан авалт хийж мөн тараах материал, өрөө танхимын бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Цаг тухай үеийн зохион байгуулах ажилд оролцсон.

**5.2.8.** Эд хөрөнгийн 2016 оны жилийн эцсийн тооллого хийж, актлах шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг гаргав.

**5.2.9.** 2017 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар Комисст ирүүлсэн нийт 457 албан бичиг, иргэдийн 483 гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу цахим болон журналаар бүртгэн танилцуулж шийдвэрлэлтийн үр дүнг эргэн мэдээлэх ажилд туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Комиссоос нийт 707 албан бичиг, 23 зөвлөмж, 29 шаардлагыг холбогдох байгууллага, иргэдэд зохих журмын дагуу хүргүүлж, Удирдлагын цахим программын файлын санд байршуулсан.

2017 оны 12 сарын 18-ны байдлаар Комиссын ажилтнуудад архивын баримтыг -311 удаа түр ашиглуулж, хэвлэмэл хуудас - 2493 ширхэгийг дугаарлан, хуулбар үнэн болох тухай тэмдэг – 56 ш дарж баталгаажуулсан.

2007-2015 оны байнга болон түр хадгалах хадгаламжийн бүртгэлийг эмхлэн цэгцэлж, 2017 оны ХХНЖ-д санал авч нэгтгэн, байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл хийсэн.

2017 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт болон комиссын архивын ажлын төлөвлөгөөг ажлын албаны даргаар батлуулсан. Мөн 2017.03.24-ний 4/175 албан бичгээр архивын мэдээг АЕГ-т хүргүүлсэн байна.

2016 онд батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу комиссын ажилтнуудаас архивын баримтыг хүлээн авч байгаа бөгөөд Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэсийн дарга Ц.Адъяахишиг хүний эрхийн олон улсын өдрийн үйл ажиллагаатай холбоотой материал, ахлах референт З.Өнөржаргал Тахарын ерөнхий газрын үйл ажиллагаанд холбогдох хуулийн хэрэгжилт болон батлагдсан дүрэм, журам нь хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд хийх судалгаа, дүн шинжилгээ хийх ажлын удирдамж, холбогдох дүрэм журам, ахлах референт Х.Мөнхзул орон тооны бус зөвлөлийн материал, комиссын 15 жилийн ойн арга хэмжээний материал, ахлах референт Л.Дүгэрсүрэн Хорих 409, 421-р ангид гомдлын мөрөөр хийсэн хяналт шалгалтын материал, референт Б.Сэмжидмаа гомдол мэдээллийн мөрөөр хийсэн хяналт шалгалтын материал, референт М.Мөнхшүр Тахарын ерөнхий газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд хуяглан хүргэлтийн автомашин нь стандартад нийцэж буй эсэхэд хийсэн хяналт шалгалтийн материал, ЗХЖШ-ын газрын харьяа ангиудад хийсэн хяналт шалгалт, референт Г.Ууганбаатар ХХЕГ-ын хяналт шалгалтын материал, Дорнод аймгийн Дорнод их сургуульд ажиллагсдын хөдөлмөрлөх эрхэд хийсэн хяналт шалгалтын материал, гомдол хяналт шалгалтын ажилтан Х.Итгэл СЭМҮТ, ШШГЕГ-ын харьяа согтууруулах мансууруулах донтой өвчтөнг эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэхтэй холбоотой материал, референт Ж.Оюунхүү комиссын дарга, ажлын албаны даргын тушаалууд, комиссын хурлын тэмдэглэл, авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө, комиссын 15 дахь илтгэл, 2016 оны үйл ажиллагааны тайлан, ХЭҮК, ИНБ-уудын хамтын ажиллагаа, ээлжит уулзалт, шагналын тодорхойлолт, ажилтнуудын хувийн хэрэг, референт Э.Туул эрүү шүүлтийн элчин сайд төслийн танилцуулга, холбогдох материал Г.Золзаяа комиссоос зохион байгуулсан сургалтын материал, цахим сургалтын хөтөлбөр, илтгэх хуудас, олон нийтийн цуврал лекцийн хөтөлбөр, холбогдох материал, хэвлэл мэдээлэлийн ажилтан С.Будрагчаа хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчилсан материал зургийн цомог, хүний эрх мэдээллийн сэтгүүл, сэтгүүлчдийн клубын үйл ажиллагаатай холбоотой материал, ахлах нягтлан бодогч С.Нармандах үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, бараа материалын тайлан, НДШ, ХХОАТ-ын тайлан, цалингийн хүснэгт, kассын баримт, харилцахын баримт, ахлах мэргэжилтэн Д.Нансалмаа 2016 оны үндсэн үйл ажиллагааны чиглэлээр бусад байгууллагатай харилцсан албан бичиг, шаардлага, зөвлөмж, төлөөлөн нэхэмжлэл, 2016 оны ажилтнуудын үр дүнгийн гэрээ, гомдолтой холбоотой албан бичиг болон гадаад албан бичгүүдийг орчуулгын хамт архивт хүлээлгэн өгсөн бөгөөд нийт байнга болон түр хадгалах 72 ширхэг материалыг архивт хүлээн аваад байна.

Референт М.Мөнхшүр, Г.Ууганбаатар нарт 2015, 2016 оны гомдлоос эрүү шүүлттэй холбоотой явсан бичгийг түүвэрлэж өгсөн.

Комиссын 2007-2015 оны данс бүртгэлийг ҮТА-ын ББНШАЗК-ын хурлаар батлуулахтай холбогдуулан ҮТА-ын арга зүйчээс зөвлөгөө 2 удаа авсан байна.

Үүнд:

- 2007-2015 оны данс бүртгэлийг эмхэлж цэгцэлж, танилцуулсан.
- 2007-2015 оны ирсэн бичгүүдийг байнга, түрээр ангилан төрөлжүүлж, хадгаламжийн нэгж болгон хавтасласан.
- 2001-2006 оны баримтаас устгах хэргийн жагсаалт гарган, комиссын ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.
- Комиссын 2007-2015 оны өргөдөл гомдлыг эмхэтгэн цэгцэлж нийт 116 ш Хадгаламжийн нэгж болгов.

Мөн 2007-2016 оны 124 боть буюу нийт 31000 хуудас гомдлыг эмхэлж цэгцэлж, үдэж хавтаслахад бэлэн болгосон.

2017 оны 11-р сарын 20-ний өдөр Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд томилогдон дараах зүйлсийг Референт Д.Нансалмаагаас хүлээн авсан.

Архивын 2001-2016 оны Байнга хадгалах баримтын бүртгэл 01-487, Түр хадгалах баримтын бүүртгэл 01-450, 70 жил хадгалах баримтын бүртгэл 01-27 баримтуудыг нэг бүрчлэн тоолж, файлаар болон цаасаар, тусгай төрлийн баримтын бичиг 2001-2007 он VHS-49, DV-33, MD-12, CD-4 нийт 38 төрлийн - 97 ширхэг хадгаламжийн нэгж. Дүрс бичлэгийн баримтын бүртгэл -100ш /2001-2015 он файлаар болон цаасаар/, мөн архивын бусад баримт бичиг, эд хөрөнгө зэргийг хүлээж авав.

Хүний эрхийн Үндэсний Комисс-Иргэний нийгмийн түншлэл 14 дэх ээлжит уулзалтанд ажил үүргийн дагуу 32 байгууллага руу утасдаж, и-мэйл хүргүүлэв.

Төлөвлөгөөт ажлаас гадна дараах уулзалтад оролцсон байна. Үүнд: 2017.01.26-ны өдөр “ Тогтвортой хөгжлийн зорилтууд хамтын ажиллагаа” ОУ-ын байгууллагтай хийх зөвлөлдөх уулзалтанд ажил үүргийн дагуу оролцов.

2017 оны 2-р сарын 16-нд Нээлттэй нийгэм форум дээр “Зохистой орон байраар хангагдах эрх ’’ сэдвээр өглөөний цайнд оролцсон.

2017 оны 4 дүгээр сарын 17 нд зохион байгуулсан Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг танилцуулах “Хүний эрхийн байгууллага ба төр, иргэний нийгмийн түншлэл 13 дах удаагийн ээлжит уулзалт” -д
2017 оны 5 сарын 19- нд зохион байгуулсан “Хот дахин төлөвлөлт газар чөлөөлөлт хүний эрх” –онол практикийн бага хуралд тус тус ажил үүргийн дагуу оролцсон.

2017 оны 6 сарын 21-нд зохион байгуулсан “Үр дүнд суурилсан төлөвлөлт, тайлагналт’’ дотоодын сургалтанд оролцсон байна.

12-р сарын 04-ний өдрийн Орон тооны бус зөвлөлийн шинэ гишүүдийн хурал, Хүний эрхийн Үндэсний Комисс-Иргэний нийгмийн түншлэл ээлжит 14 дэх удаагийн уулзалтанд суун хурлын тэмдэглэл хөтөлсөн.

Хөдөө орон нутгаас ирүүлсэн гомдлыг хүлээн авсан бөгөөд
- Х.Наранцэцэг 2015-2017 оны нийт 11 гомдол
- Д.Гантулга 2015-2017 оны нийт 10 гомдол
- Я.Хонгорзул 2014-2017 оны нийт 51 гомдол
- Ц.Долгорсүрэн 2014 оны нийт 19 гомдол
- Д.Дугарсүрэн 2015-2017 оны нийт 15 гомдол
- Б.Содонцэцэг 2014-2017 оны нийт 29 гомдол
- Ч.Нандин-Эрдэнэ 2017 оны нийт 8 гомдол
- У.Чойжилсүрэн 2014-2017 оны 9 гомдол
- Ё.Эрдэнэболд 2014-2016 оны нийт 47гомдол
- М.Тунгалагмөрөн 2016-2017 оны нийт 12 гомдол
- Ч.Наранхүү 2017 оны нийт 2 гомдол
- Б.Наранбаатар 2014-2016 оны нийт 20 гомдол
- Д.Эрдэнэбаясгалан 2015-2016 оны нийт 16 гомдлын эх хувийг хүлээлгэн өгсөн байна.

5.2.10. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Комиссын төсвийн 2016 оны 12-р сар, 2017 оны 1-ээс 12 дугаар сарын мэдээллийг оруулсан. 2016 оны 4-р улирлын болон жилийн эцсийн оруулах шаардлагатай мэдээллийг нэмж оруулав. Мөн 2017 оны 1,2,3,4-р улирлын болон хагас жилийн

оруулах шаардлагатай мэдээллийг нэмж оруулав. Сарын мэдээллийг тухай бүр нь коридорын мэдээллийн самбарт хэвлэж тавив.

5.2.11. Төлөвлөгөөний төслийг боловсруулан хянуулахаар ААД-д шилжүүлсэн байсан бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын 17, 18-нд АТГ-аас хийсэн сургалтаар энэ жилээс эхлэн Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор АТГ-т Ажлын алба байгуулагдах, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө 5-6 сард гарч, байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-нд ирүүлж байхыг мэдэгдсэн болно.
Авлигатай тэмцэх үнэдсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд 2 сард санал өгсөн. АТГ-аас 6-р сард ирүүлсэн төлөвлөгөөтэй танилцаж Комиссын төлөвлөгөөний төслийг боловсруулан танилцуулж, батлуулахаар Ажлын албаны даргад 2017.06.16-ны өдөр шилжүүлэв.

5.2.12. Комиссын нийт албан хаагчдын 2016 оны бүрэлдэхүүн хөдөлгөөн, цалин хөлс, үр дүнгийн үнэлгээний мэдээлийг шинэчлэн ТАЗ-ын цахим программд оруулж, 2017.01.02-нд 4/2 дүгээр албан бичгээр тайланг ТАЗ-д хавсралт материалын хамт хүлээлгэн өгсөн.

5.2.13. Авлигатай тэмцэх газарт ХАСХОМ болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалт гаргаж хүргүүлэв.Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад хуулийн хугацаандаа багтааж мэдүүлгээ гаргахыг авле программын захидлаар 4 удаа сануулж, мэдүүлэг гаргагч нарт тухай бүр заавар зөвлөгөө өгч ажиллав.Нийт 22 албан тушаалтан мэдүүлгээ цахим хэлбэрээр мэдүүлсэн.Шинээр томилогдсон болон нэр дэвшсэн 9 ажилтны Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлж хариу авсан. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайлан, мэдээ гаргаж 4/128 дугаар албан бичгээр 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр АТГ-т хүргүүлэв.

5.2.13. Албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр томилогдсон ажилтнуудад /М.Мөнхшүр, Г.Ууганбаатар, Б.Наранбаатар, М.Зул, Д.Халиун, Б.Номин, Г.Түвшинжаргал, Б.Мөнх-Ундраа, Б.Отгонжаргал / хувийн хэрэг бүрдүүлэв. Нийт 46 ажилтны үнэмлэхийн хугацаа сунгуулах, нэрийн хуудас хийлгэх, сул орон тоонд ажилтан шалгаруулж авах, ТАЗ-ийн дүгнэлт гаргуулах, тангараг өргүүлэх, хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг тухай бүр нь зохион байгуулсан байна.

Жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Комиссын болон Ажлын албаны даргын нийт 83 тушаал, 106 албан бичгийн төсөл боловсруулж эцэслэн баталгаажуулж, хариутай албан бичгийг цаг тухайд нь шийдвэрлэж холбогдох байгууллагад хариу хүргүүлсэн байна.

5.2.14. Хэлтсийн ажилтнууд 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 2017 оны үр дүнгийн гэрээгээ байгуулж, үр дүнгийн гэрээг ажлын албаны даргаар хянуулж баталгаажуулав.

Мөн 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хэлтсийн ажилтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэв.

Хоёр. Бусад хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2.2.2 “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубыг чадавхжуулах, сургалт уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд 6 удаагийн уулзалт, сургалтад цай завсарлагын худалдан авалт хийж, бэлтгэл ажлыг хангах, тараах материал бэлдэж өгөх зэргээр туслалцаа үзүүлж ажиллав.

2.2.7. Хүний эрхийн Цахим номын санд 2017 онд 6786 хандалт хийгдсэн байна. Цахим номын сан нээгдсэнээс хойш нийт 1296 хэрэглэгчтэй болсоноос энэ жилийн байдлаар 848 хэрэглэгч шинээр нэмэгдсэн байна.Энэ жилд цахим номын санд Гэрэл татуулсан зөв зам комик, Хүний эрхэд суурилсан хандлага сургалтын гарын авлага, Жендэр ба хүний эрх, Human Rights and Disability Manual, Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх судалгааны тайлан, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэл дараах номуудыг шинээр бүртгэлжүүлсэн байна.

Цахим номын сан нээгдсэнээс хойш хамгийн их хандалттай номууд нь:

-  Compulsory military service and conscript labour in Mongolia: Review of policy and practice - 2081
-  Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар Төрийн бус байгууллагуудаас 2012-2015 онд хийсэн судалгаа, мониторингийн тайлангууд -1498

- Олон улсын хүний эрхийн билл Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл (2015) - 1480
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл – 1404
- Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал (2013)–1455
- Хүний эрхийн цуврал нийтлэл (2012) - 1009
- Хүний эрх сэтгүүл 2016/1 - 1124
- Хүний эрх улирал тутмын сэтгүүл 2016/1 - 782
- Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах хүний эрхийн төлөв байдлын судалгаа - 1129
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл - 646

Мэдээлэл лавлагааны төвийн комиссын номын сангийн номуудыг нэгдсэн програмд бүртгэлжүүлэх ажлыг энэ 6 дугаар сарын 16-ны өдрөөс Волвес ХХК-тай гэрээ хийж номын бүртгэлийг 19-ны өдрөөс эхлүүлээд байна. Одоогоор комиссын номын санд байгаа Монгол хэл дээрх 34, гадаад хэл дээрх 27 бүлэг нэр төрлөөрөө 3500 ном, товхимол бүртгэлтэй байгаас 1450 номыг одоогийн байдлаар бүртгэлжүүлээд байна.Мэдээлэл лавлагааны төвөөс энэ жил нийт 641 ном, товхимол уншилгад гарсан байна.

Комиссын сургалт сурталчилгаанд ашиглах тараах материал хүлээж авсан байдал.

- Гүүд нэйборс ТББ-с хүүхдийн эрхийн сургалтад ашиглах “Хүүхдийн эрхийн тухай цуврал нэвтрүүлэг”-ийн DVD -200ширхэг
- Комиссын танилцуулга – 1000ширхэг/Хөх судар принтинг ХХК/
- Жендэр ба хүний эрх – 500ширхэг /Мөнхийн үсэг ХХК/
- Хүний эрхэд суурилсан хандлага –500ширхэг /Мөнхийн үсэг ХХК/
- Мэдээллийн хуудас 2017/1 №(50) -500 ширхэг /Соёмбо принтинг ХХК/
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэл-1500 ширхэг /Соёмбо принтингХХК/
- Комиссын “Хүн бүр” дэвтэр – 4800 ширхэг /Соёмбо принтинг ХХК/
- Хүний эрхийн улирал тутмын сэтгүүл 2017/1 – 500 ширхэг /Хөх судар принт ХХК/
- Хүний эрхийн улирал тутмын сэтгүүл 2017/2 -500 ширхэг /Хөх судар принт ХХК/
- 13 төрлийн брошур нийт – 15700 ширхэг /Соёмбо принтинг ХХК/
- Гүүд нэйборс ТББ-с Хүүхдийн эрх ба хамгаалал судалгаа 200 ширхэг
- Швейцарын хөгжлийн агентлагаас Бичил уурхай дахь зөрчил, маргаан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх арга зам – 1500 ширхэг
- “Жижиг, дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгэээ ноос ноолуурын салбар” судалгаа – 700ш /Содпресс ХХК/
- Орон нутаг дахь шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо гарын авлага -1000 ширхэг /Соёмбо принтинг ХХК/

Комиссын тараах материалыг нээлттэй өдрийн хүрээнд Сэлэнгэ, ДарханТөв, Дорноговь,Орхон, Булган аймгуудад мөн 5, 6 дугаар сарын төлөвлөгөөний дагуу Швейцарын хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн хүрээнд Хэнтий, Архангай, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудад хийсэн сургалт сурталчилгаанд, 10-р сард НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Өмнөговь аймагт зохион байгуулах “Байгаль орчны засаглал ба хариуцлагатай уул уурхай” туршлага судлахад, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн Ерөнхийгазар, Шүүхийн шийдвэргүйцэтгэх ерөнхий газар, Хүний эрхийн Олон улсын өдрийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнүүд гэх мэтчилэн бусад байдлаар тараасан.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэлийг Улсын Их Хурлын 76 гишүүд, яам, агентлаг, нийслэлийн 9 дүүргийн тамгын газар, 21 аймгийн засаг дарга, номын сангууд, хууль зүйн их дээд сургуулиуд, иргэний нийгмийн байгууллагууд, орон тооны бус зөвлөлийн гишүүд, комиссын орон нутгийн ажилтнуудад тус тус хүргүүлсэн.

2017 оны байдлаар нийт 27509 ширхэг ном товхимол тараасан байна.